

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Цэцэрлэг хот.

Тайлангийн зорилго: Цагдаагийн газар нь 2017 онд Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Хууль зүйн яам, Цагдаагийн байгууллагын шинэчлэлийн бодлого, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын арга, хэлбэрийг боловсронгуй болгох, олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, цагдаагийн үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх, алба хаагч бүрийн ажлын бүтээлч чанар, үр дүнг ахиулж, аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангах зорилт тавин ажиллаа.

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар

- Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл болон холбогдох эрх зүйн баримт бичигт тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр; /хөтөлбөр, төлөвлөгөө холбогдох бусад баримт бичгийн хэрэгжилтийг гарган хүргүүлсэн байдал/

Цагдаагийн газраас Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурал, Засгийн газар, Хууль зүйн яам болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нараас гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шийдвэр, Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын дарга, удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг алба хаагчдад хүргэх, судлуулах, тайлбарлан таниулах, бие бүрэлдэхүүнийг шинэ мэдээ, мэдээллээр ханган тэдний мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллав.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх /код 108/ журам”-ын дагуу Цагдаагийн байгууллагаас 2017 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 бүлэг 22 заалт, Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс хийж гүйцэтгэхээр заагдсан заалтыг хэрэгжүүлэх 6 бүлэг 45 заалт, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, бүрэлдэхүүний сахилга ёс зүйг дээшлүүлэх тэдний дунд зохиох сургалт соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах зорилгоор цагдаагийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө 6 бүлэг 91 заалт, дотоодын хяналт шалгалтын төлөвлөгөө 36 заалт, цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө 35 заалт, албаны сургалтын төлөвлөгөө, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө, хуваарь зэргийг боловсруулан цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн “2017 онд хяналт шинжилгээ-үнэлгээ хийж, биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт”-д заагдсан Монгол улсын хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны тогтоол, шийдвэр, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр бүрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган заагдсан хугацаанд сар, улирал, хагас, бүтэн жилээр гарган хүргүүлэв.

Цагдаагийн газраас шинээр батлагдсан хууль тогтоомж болон Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, бусад албадын дарга нараас цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн үүрэг 73, даалгавар 4, ажлын чиглэл 148, зөвлөмж 22 нийт 247 албан бичгийг тухай бүрт нь нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, ажлын төлөвлөгөө гаргах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд оруулан хэрэгжүүлэх зэрэг тодорхой ажлуудыг зохион байгуулан биелэлт үр дүнг тооцож ажиллаа.

-Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, тушаалын тоо;

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгүүлж 26 удаа хуралдаж, 193 асуудал хэлэлцсэнийг ангилж үзвэл: албаны шалгалт, сахилга хариуцлагын талаар 23, тасаг албадын сарын ажил дүгнэх 11, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний талаар 6, хүний нөөцийн чиглэлээр 41, дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр явуулсан хяналт шалгалтын дүнгийн талаар 23, тодорхой чиглэлээр зохион байгуулж байгаа ажлын үр дүнгийн тухай сонсгол мэдээлэл 18, бусад 71 асуудлыг хэлэлцэж тус тус шийдвэр гаргасан ба зөвлөлийн хурлаас 22 үүрэг, даалгаврыг холбогдох алба хаагчдад өгч биелэлт үр дүнг тооцсон байна.

Тайлангийн хугацаанд цагдаагийн газрын даргын тушаалыг хүний нөөцийн чиглэлээр 102, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 70 -ыг тухай бүрт төлөвлөн гаргасан байна.

Хүний нөөцийн чиглэлээр гаргасан тушаалыг ангилж үзвэл: Сарын ажлын үр дүнгийн 11, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний дүн 8, алба хаагчдыг шагнах 18, сахилгын шийтгэл хүлээлгэх 28, шилжүүлэн томилох 20, цалин хөлс тогтоож олгох 4, алба хаагчид чөлөө олгож сургалтад хамруулах 3, үйлдвэрлэлийн сургалт дадлага зохион байгуулах 1,

ажилд томилох 6, ажлаас чөлөөлөх 3 тушаал гаргасан ба үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан тушаалыг ангилж үзвэл: ажлыг хэсэг томилох 36, батлагдсан төсвийн зарцуулалтын чиглэлээр 1 бусад 33 -ыг тус тус төлөвлөн гаргаж биелэлтэд нь хяналт тавьж хэрэгжүүлэв.

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанаар 2017 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу үндсэн ажил үүргийн гүйцэтгэл, ажлын хариуцлага, сахилга ёс зүйг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар 8 тасгийн дарга, 5 ахлах байцаагч, 5 хэсгийн төлөөлөгч, сонсгол мэдээллийг хэлэлцэж хугацаатай үүрэг даалгавар өглөө.

-Хүний нөөцийн талаар;

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/135 дугаар тушаалаар нийт 130 алба хаагч ажиллаа.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн тэргүүлэх чиглэлийг оновчтой тодорхойлж, хүний нөөцийг бүрдүүлэх, хүний нөөцийн мэдээллийг удирдлагын шийдвэр гаргах хэрэгсэл болгох, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалт, хөгжлийн бодлого боловсруулан хэрэгжүүлж, суралцагч байгууллага болох карьер хөгжлийн болон цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог ажлын бүтээмжийг дээшлүүлэх хөшүүрэг болгох, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх хэрэгсэл болгох үндсэн зорилго агуулсан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/164 дүгээр тушаалаар батлан ирүүлсэн “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Цагдаагийн газар нь үйл ажиллагаагаа иргэдэд шуурхай хүргэх, ил тод байлгах, оролцогч бүрийг ижил тэгш мэдээллээр хангах, асуудлыг шударгаар шийдвэрлэх зорилгоор цагдаагийн байгууллагад орж ажиллахаар хүсэлтээ гаргасан иргэдийг судлах, шалгаруулах, томилох, албан тушаал дэвшүүлэх, гадаад, дотоодод суралцуулах, шагнах, урамшуулах зэрэг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдолтой эрх зүйн актуудыг байгууллагын вэб хуудсанд байршуулснаар иргэд хүссэн үедээ шаардлагатай мэдээллийг чөлөөтэй авах боломжтой боллоо.

Цагдаагийн байгууллагад ажилд орохоор хүсэлт гаргасан иргэдийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/ журам”, “Хүний нөөцийг судлах, ажилд томилох /код 901/ журам”-ын дагуу эрүүл мэнд, бие бялдар, мэдлэг боловсрол, мэргэжлийн түвшин, ахуй амьдрал, амьжиргааны түвшин, ял шийтгэлийн байдлыг тогтоох зорилгоор судалгааны ажлыг чанартай явуулахад анхаарч “Цагдаагийн албанд ажилд орох, суралцахыг хүссэн иргэний бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт”, “Алба хаагчийн хувийн хэрэгт бүрдүүлвэл зохих бичиг баримтын жагсаалт”, “Цагдаагийн байгууллагад ажилд орохыг хүссэн иргэний тухай мэдээлэл”, “Эрүүл мэндийн үзлэг”, “Бие бялдрын шалгалт авсан тэмдэглэл”, “Биечилсэн судалгаа хийсэн хүүхдийн болон хэсгийн байцаагчийн дүгнэлт” зэргийн загварыг боловсруулж, ой тогтоолт, сэтгэн бодох, монгол хэл бичиг, гадаад хэл, компьютерийн мэдлэгийн түвшинг тогтоох сорил, тестүүдийн нэр төрлийг олшруулж, судлагдаж буй иргэний боловсролын түвшин, ажлын байрны онцлог зэргээс хамааран сонгож ашиглах зэрэг удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан цагдаагийн байгууллагад ажилд орох хүсэлт гаргасан 31 иргэнийг бүртгэснээс шаардлага шалгуур хангасан 14 иргэний материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлэн сонгон шалгаруулалтад хамруулсан.

Цагдаагийн газар нь сул орон тоо гарсан даруйд Төрийн албаны тухай хуулийн дагуу одоо ажиллаж байгаа алба хаагчдаас ажлын үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулж томилох, цагдаагийн байгууллагад ажиллах хүсэлтээ гарган журмын дагуу судлагдаж, нөөцөд бүртгэгдсэн иргэдийн хувийн хэрэг, материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлж журмын дагуу шалгалтанд оруулж тэнцсэн иргэдийг зөвшөөрлийн дагуу томилох зэргээр хүний нөөцийн нөхөн хангалтыг хийж байна.

Цагдаагийн газар нь жил бүр алба хаагчдын “Төрийн алба хаагчийн үр дүнгийн гэрээ”-г дүгнэж үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, сахилга ёс зүйн байдлыг харгалзан “А” буюу “Маш сайн” үнэлгээ авсан алба хаагчдыг албан тушаал дэвшүүлэх буюу энэ тухай саналыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлж нөөцөд бүртгэдэг.

Цагдаагийн газрын хүний нөөцийн судалгаа, алба хаагчдын үр дүнгийн үнэлгээ, ажлын үзүүлэлтийг харгалзан хэлтсийн болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын албан тушаалд дэвшүүлэх 1, тасгийн даргын албан тушаалд дэвшүүлэх 1, ахлах албан тушаалд дэвшүүлэх 4, ахлагч бүрэлдэхүүнээс офицерын бүрэлдэхүүнд оруулах нөөцөд 3 нийт 9 алба хаагчийн материалыг холбогдох газар хэлтэст хүргүүлсэн байна.

Томилолт:

Энэ хугацаанд цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Б/126 дугаар тушаалаар Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Э.Золбаатар Архангай аймаг дахь цагдаагийн газрын даргаар, мөн даргын 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Б/231 дүгээр тушаалаар Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтсийн эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн

дэд хурандаа Б.Баасанжаргал тус газрын Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн даргаар, мөн даргын 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн Б/388 дугаар тушаалаар Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын шүүх, шүүгчийн аюулшгүй байдлыг хангах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Б.Явуухулан тус газрын Замын цагдаагийн тасгийн даргаар, Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Д.Жаргал тус газрын Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагчаар, мөн даргын 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн Б/327 дугаар тушаалаар Өгийнуур сум дахь хурлын ажилтан Ц.Мөнхнасанд өмнө эдэлж байсан цагдаагийн ахлах дэслэгч цолыг сэргээж Өгийнуур сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, цагдаагийн газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Б/77 дугаар тушаалаар Х.Баярсайхан эргүүлийн цагдаагаар, мөн даргын 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн Б/81 дүгээр тушаалаар Б.Дэлгэрмөрөн Өгийнуур сум дахь хэв журмын цагдаагаар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Б/538 дугаар тушаалаар Булган аймаг дахь цагдаагийн газрын зохицуулагч, цагдаагийн хошууч Х.Наранбаатарыг тус газрын Замын цагдаагийн тасагт зохицуулагчаар, Цагдаагийн газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 18 өдрийн Б/100 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагад ажилд орох иргэний нөөцөд авагдсан Б.Оюундарийг эрүүгийн цагдаагийн тасагт мэдээлэл хүлээн авагч, жижүүрийн цагдаагаар тус тус томилогдсон байна.

Шилжилт хөдөлгөөн:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Б/126 дугаар тушаалаар Архангай аймаг дахь цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Т.Ганзориг Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын даргаар, мөн даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн Б/147 дугаар тушаалаар тус газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн ахмад Г.Алтан-Очир Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэст Мөрдөн байцаах тасгийн даргаар, мөн даргын 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Б/231 дүгээр тушаалаар Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Ш.Даваа-Эрдэнэ Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэст Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн даргаар, мөн даргын 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн Б/388 дугаар тушаалаар Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа О.Чинзориг Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагчаар, Замын цагдаагийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Х.Наранбаатар Булган аймаг дахь цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагт зохицуулагчаар, цагдаагийн газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн Б/72 дугаар тушаалаар зөрчлийн тоо бүртгэгч, цагдаагийн ахлах ахлагч О.Алимаа Чингэлтэй дүүрэг дэхь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн Б/532 дугаар тушаалаар зохицуулагч, цагдаагийн дэслэгч М.Бат-Эрдэнэ Баянзүрх дүүрэг дэх замын цагдаагийн хэтсийн зохицуулагчаар, мөн даргын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны Б/516 дугаар тушаалаар Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэст чиглэлийн ахлах зохицуулагчаар, цагдаагийн газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Б/83 дугаар тушаалаар Ихтамир сум дахь хэв журмын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Э.Бүрэнбаяр Нийслэлийн Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэст тус тус шилжин томилогдсон байна.

Байгууллагын дотоод шилжилт хөдөлгөөн:

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар нийт 5 алба хаагч / 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Б/115 тоот тушаалаар цагдаагийн дэслэгч Л.Эрхэмбаярыг Жаргалант сум дахь хэсгийн төлөөлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлж Булган сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, цагдаагийн ахмад Ж.Амгаланбаатарыг Хайрхан сум дахь хэсгийн төлөөлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлж Нийтийн хэв журам хамгаалах тасагт хэсгийн байцаагчаар, цагдаагийн дэслэгч Д.Цэнд-Аюушийг Булган сум дахь хэсгийн төлөөлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлж Хайрхан сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, цагдаагийн ахлах дэслэгч Э.Алтанбаатарыг Өлзийт сум дахь хэсгийн төлөөлөгчийн үүрэг ажлаас чөлөөлж Цэнхэр сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, цагдаагийн дэслэгч Д.Энх-Амгаланг Цэнхэр сум дахь хэсгийн төлөөлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлж Өлзийт сум дахь хэсгийн төлөөлөгчөөр тус тус шилжүүлэн, Мөн даргын мөн даргын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Б/171 дүгээр тушаалаар цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Т.Жигжидсүрэн Жаргалант сум дахь хэсгийн төлөөлөгчөөр дэвшин, төрийн тусгай албан тушаалд орох иргэний нөөцөд авагдсан М.Даваадалайг тус газарт холбоо, мэдээллийн инженерээр, мөн даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Б/288 дугаар тушаалаар шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн дарга, цагдаагийн хошууч Ч.Мөнх-Очирыг Хэрэг бүртгэх тасгийн даргаар, мөн даргын 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн Б/327 дугаар тушаалаар эрүүгийн мөрдөгч, Э.Эрдэнэбатыг шүүх, шүүгчийн аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагчаар, Цэцэрлэг сум дахь хэсгийн төлөөлөгч цагдаагийн ахмад Б.Баттогтохыг эрүүгийн мөрдөгчөөр, Өгийнуур сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Н.Бат-Эрдэнийг Цэцэрлэг сум дахь хэсгийн

төлөөлөгчөөр, бичиг хэргийн эрхлэгч, цагдаагийн ахлах ахлагч Д.Одгэрэлийг офицерын бүрэлдэхүүнд оруулан цагдаагийн цэслэгч цол олгож мөрдөгчөөр, мөн даргын 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн Б/532 дугаар тушаалаар мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Х.Эрдэнэчулууныг ахлах мөрдөгчөөр тус тус томилогдсон байна.

Цагдаагийн газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн Б/23 дугаар тушаалаар эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлагч Б.Даваадоржийг мэдээлэл хүлээн авагч цагдаагаар, мөн өдрийн Б/24 дүгээр тушаалаар Хангай сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Ч.Эрдэнэбаярыг Хайрхан сум дахь хэсгийн цагдаагаар, Б/25 тоот тушаалаар Хайрхан сум дахь цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч М.Ариунболдыг Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсэгт хамгаалалтын цагдаагаар, Б/26 дүгээр тушаалаар Хайрхан сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Л.Ариунбаярыг Эрдэнэмандал сум дахь сум дундын цагдаагийн тасагт цагдаа жолоочоор, Б/27 дугаар тушаалаар Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн хамгаалалтын цагдаа, цагдаагийн ахлагч Ц.Мандухайг мэдээлэл хүлээн авагч цагдаагаар, Б/28 дугаар тушаалаар Эрдэнэмандал сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Б.Алтанхуягийг Тариат сум дахь сум дундын цагдаагийн тасагт хэсгийн цагдаагаар, Б/29 дүгээр тушаалаар Эрдэнэмандал сум дахь сум дундын цагдаагийн тасгийн цагдаа-жолооч, цагдаагийн дэд ахлагч Т.Отгонбаатарыг Нийтийн хэв журам хамгаалах тасагт эргүүлийн цагдаагаар, Б/30 дугаар Тариат сум дахь сум дундын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Г.Энхболдыг Нийтийн хэв журам хамгаалах тасагт эргүүлийн цагдаагаар, Б/36 дугаар тушаалаар эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Г.Энхболдыг саатуулах байрны жижүүрийн цагдаагаар, эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Т.Отгонбаатарыг саатуулах байрны жижүүрийн цагдаагаар, саатуулах байрны жижүүрийн цагдаа, цагдаагийн ахлагч Д.Батбаатарыг мэдээлэл хүлээн авагч цагдаагаар, саатуулах байрны жижүүрийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Ш.Гунгааг эргүүлийн цагдаагаар, мэдээлэл хүлээн авагч цагдаа, цагдаагийн дэд ахлагч Э.Ганбаярыг эргүүлийн цагдаагаар, мэдээлэл хүлээн авагч цагдаа, цагдаагийн ахлагч Б.Даваадоржийг Батцэнгэл сум дахь хэсгийн цагдаагаар, Батцэнгэл сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Л.Санжиддоржийг Эрдэнэмандал сум дахь сум дундын цагдаагийн тасагт хэсгийн цагдаагаар тус тус шилжүүлэн, төрийн тусгай албан тушаалд орох иргэний нөөцөд Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц сургалтын хэлтсийн даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 2017/53 дугаартай зөвшөөрлийг үндэслэн Б/37 дугаар тушаалаар Н.Эрдэнэбаярыг мэдээлэл хүлээн авагч цагдаагаар, мөн даргын 2017 оны 04 дүгээр 13-ны өдрийн 2017/71 дүгээр зөвшөөрлийг үндэслэн Б/40 дүгээр тушаалаар Г.Гоцбаярыг Хангай сум дахь хэсгийн цагдаагаар, цагдаагийн газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 26-ны Б/42 дугаар тушаалаар мэдээлэл хүлээн авагч цагдаагаар, цагдаагийн ахлах ахлагч Б.Алтангэрэлийг цагдаа зохицуулагчаар, мөн даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн Б/71 дүгээр тушаалаар эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Э.Ганбаярыг бичиг хэргийн эрхлэгч бичээчээр, мөн даргын 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн Б/76 дугаар тушаалаар зөрчлийн тоо бүртгэгчээр, Өгийнуур сум дахь хэв журмын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Н.Дүүрэнбаярыг зөрчлийн тоо бүртгэгчээр, мөн даргын 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Б/82 дугаар тушаалаар Хотонт сум дахь хэв журмын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ө.Цогтбаатарыг эрүүлжүүлэх, саатуулах байрны жижүүрийн цагдаагаар, хүүхэд асрах чөлөөтэй байсан эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Г.Алтантуяаг шүүхийн хамгаалалтын цагдаагаар, шүүхийн хамгаалалтын цагдаа, цагдаагийн ахлагч М.Ариунболдыг шүүхийн харуулын цагдаагаар, шүүхийн харуулын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч П.Батсайханыг Жаргалант сум дахь хэв журмын цагдаагаар, мөн даргын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Б/89 дүгээр тушаалаар цагдаа жолооч, цагдаагийн ахлах ахлагч Д.Лхагва-Очир, эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Н.Данаахорол, шүүхийн харуулын цагдаа, цагдаагийн ахлагч М.Ариунболд нарын цагдаа зохицуулагчаар, цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч П.Одбаярыг цагдаа жолоочоор, цагдаа зохицуулагч, цагдаагийн дэд ахлагч Б.Чагнаадоржийг эргүүлийн цагдаагаар, цагдаа зохицуулагч Г.Улсболдыг шүүхийн харуулын цагдаагаар, шүүхийн харуулын цагдаа, цагдаагийн ахлагч М.Ариунболдыг цагдаа зохицуулагчаар, Өлзийт сум дахь хэв журмын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Ч.Алтанзулыг Ихтамир сум дахь хэв журмын цагдаагаар тус тус шилжүүлэн томилсон байна.

Албанаас халагдсан, чөлөөлөгдсөн байдал:

Энэ хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Б/123 дугаар тушаалаар ажлын байрны зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн жижүүрийн офицер, цагдаагийн ахмад Б.Хүрэлшагайн “Цагдаагийн ахмад” цолыг хураан, тус газрын мэдэлд шилжүүлж, “Цагдаагийн ахлах ахлагч” цол олгосныг Б/48 дугаар тушаалаар Хайрхан сум дахь цагдаа зохицуулагчаар томилов. Цагдаагийн газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн Б/67 дугаар тушаалаар эрүүлжүүлэх, саатуулах байрны жижүүрийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Т.Отгонбаатарыг албанаас дутагдлаар халжээ.

Цэргийн байнгын тэтгэвэр гарах хүсэлт гаргасан алба хаагчдаас Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 11 дүгээр 09-ний өдрийн Б/526 дугаар тушаалаар Хангай сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Д.Батболд, Тариат сум дахь сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн ахмад Ш.Тэрбиш, 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Б/540 дүгээр тушаалаар Тариат сум дахь замын цагдаагийн зохицуулагч, цагдаагийн ахмад Б.Чулуунбаатар, 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Б/591 дүгээр тушаалаар хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Л.Мөнхзул, жижүүрийн офицер, цагдаагийн хошууч Ч.Цэрэнбат, Хангай сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Д.Самбуу, Эрдэнэмандал сум дахь сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Н.Бадамдоо, 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Б/594 дүгээр тушаалаар ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Б.Батхуяг, Б/596 дугаар тушаалаар Жижүүрийн ахлах офицер Д.Мөнхбат, жижүүрийн офицер Д.Алтанзул, цагдаагийн газрын даргын А/98 дугаар тушаалаар эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Б.Насантогтох нар цэргийн байнгын тэтгэвэрт гарсан байна.

Шагнал урамшил:

Иргэдэд чирэгдэл учруулж, эрх ашгийг нь хөндөж хохироосон алба хаагч бүртэй хариуцлага тооцож, алба хаагчийг албан тушаал дэвшүүлэх, төрийн болон байгууллагын шагналаар шагнуулах санал гаргах, шагнах, цагдаагийн цол олгох асуудлыг хэлэлцэхэд тухайн алба хаагч хүний эрх зөрчиж иргэдийг чирэгдүүлж хүнд суртал гаргаж гомдоож байсан эсэхийг шалгуур үзүүлэлт болгож, алба хаагчдын ажлын үр дүнг цаг тухайд нь үнэлж дүгнэн, тэднийг шагнаж урамшуулах асуудлыг дэмжиж ажиллаа.

Тайлангийн хугацаанд 14 алба хаагчийн хугацааны цол, 1 алба хаагчийн хугацааны өмнө цол, 2 алба хаагчийн зэрэг дэв дээгүүр цагдаагийн цол, 28 алба хаагчид Цагдаагийн ерөнхий газрын “Цагдаагийн албаны төлөө” I, II, III дугаар зэргийн медалиар шагнуулахаар, 3 алба хаагчийг ЦЕГ болон холбогдох газар хэлтсийн шагналаар шагнуулахаар, 6 алба хаагчийн Төрийн одон “Цэргийн хүндэт медаль” –аар, 1 алба хаагчийн Хууль зүйн яамны “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр, 2 алба хаагчийг ЦЕГ-ын Замын цагдаагийн албаны “Осолгүй манлай жолооч” цол тэмдгээр шагнуулахаар, 3 алба хаагчид Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2-т заасны дагуу урамшил олгуулахаар нийт 72 алба хаагчийн шагналын материалыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасны дагуу бүрдүүлэн холбогдох газар хэлтэст хүргүүлснээс 16 алба хаагч хугацааны цолоор, 26 алба хаагч Цагдаагийн ерөнхий газрын “Цагдаагийн албаны төлөө” I, II, III дугаар зэргийн медалиар, Монгол улсын төрийн дээд шагнал “Цэргийн хүндэт медаль”-аар 4 алба хаагч, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар 1, “Хууль зүйн яамны жуух бичиг”-ээр 1, “Цагдаагийн алдар” тэмдгээр 1, “Цагдаагийн гавьяа”-аар 4, “Шударга журам” медалиар 1, “Спортын алдар” тэмдгээр 1, ЦЕГ-ын “Хүндэт жуух бичиг”-ээр 1 алба хаагч тус тус шагнагдсан байна.

-Байгууллагын үйл ажиллагаа түүнийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ;

Аймаг орон нутгийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, үр дүнтэй зохион байгуулах зорилгоор “Мал мах, малын гаралтай түүхий эдийг худалдан борлуулах үйл ажиллагааг зохицуулах журам”, “Малчдын бүлэг нөхөрлөлийг ажиллуулах журам”, “Мал мах малын гаралтай түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ, түүнийг хэрэгжүүлэх журам”, “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр” зэргийг хэрэгжүүлэхээр төслийг аймгийн Иргэдийн Тэргүүлэгчдийн хуралд батлуулахаар хүргүүлсэн.

Тус газраас энэ онд иргэдээс санал, хүсэлт хүлээн авах албан тушаалтны нэрс, өрөөний дугаар, утсыг ил харагдах газар байрлуулж, газрын удирдлага, тасгийн дарга, ахлахууд хуваарийн дагуу иргэдийг хүлээн авч санал, хүсэлтийг нь сонсон шийдвэрлэж, цагдаагийн газрын албан конторт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хуваарьт оруулан “Угтах үйлчилгээ”-г хэрэгжүүлснээр цагдаагийн байгууллагын иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанар дээшилж, цагдаагийн газрын дотоод журам, дотоод аюулгүй байдал, сахилга дэг журамд хяналт тавьж байна.

Цагдаагийн газрын алба хаагчдыг иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй түргэн шуурхай, харилцааны өндөр соёлтой үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор газрын үүдний иргэдэд үйлчлэх хэсэгт “Санал хүсэлтийн дэвтэр”, “Санал авах хайрцаг”, үүдний мэдээллийн самбар зэргийг шинэчлэн шилэн дансны мэдээлэл, хүний нөөцийн сонгон шалгаруулалт, тендер сонгон шалгаруулалт зэрэг мэдээллийг байршуулж, цагдаагийн алба хаагчийн хүнд суртал, авлига хээл хахуулийн талаарх мэдээллийг хүлээн авах ёс журам сахиулах эргүүлийн 93411102 утас, Цагдаагийн ерөнхий газрын 126 утасны дугаар бүхий зурагт хуудас зэргийг иргэдийн нүдэнд харагдахуйц газарт байрлуулж иргэдэд чиглэсэн төрөл бүрийн мэдээ мэдээллийг тогтмол явуулж байна.

Тус цагдаагийн газрын байгууллагын цахим хуудас <http://arkhangai.police.gov.mn/> вэб сайт, “Архангайн цагдаа” фэйсбүүк хуудас болон www.youtube.com сайтад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд шуурхай хүртээмжтэй хүргэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1.<http://arkhangai.police.gov.mn/> сайтын нүүрэн хэсэгт Цагдаагийн газрын лого зургийн чанарыг сайжруулж, текст үсгийн фонд болон өнгийг өөрчлөн 7033102 тусгай дугаарыг сайтын толгой хэсэгт харилцуурын хамт байршуулсан. Мөн “Бидний тухай” цэсэд 2017 оны 06 сарын 30-ны өдрийн А/135 дугаар тушаалаар батлагдсан тасаг албадын нэршлийг өөрчилж, шинээр үйл ажиллагаагаа явуулж байгаа тасгийн танилцуулгыг нэмэлтээр оруулсан.

2.Архангай аймгийн албан ёсны цахим сайт <http://arkhangai.gov.mn/> болон хуулийн legalinfo, шилэн дансны нэгдсэн систем <http://shilendans.gov.mn/org/784> сайтуудын линкийг өөрийн вэб сайттай холбож шууд хандах боломжийг бий болгосон.

3.<http://arkhangai.police.gov.mn/> сайт болон Архангайн цагдаа фэйсбүүк хуудсаар дамжуулан цагдаагийн газрын цаг үеийн мэдээ мэдээлэл, соёл, урлаг спорт, гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ, шилэн дансны мэдээлэл болон соён гэгээрүүлэх ажлын мэдээ мэдээллүүдийг тухай бүрт нь оруулж, сэрэмжлүүлэг видео шторкыг www.youtube.com видео сайт байршуулан ажиллаж байна.

4.Манай байгууллагын цахим сайтаас иргэд ял шийтгэлийн тодорхойлолт, тамга тэмдэг авах, гэрээт харуул хамгаалалт, тусгай хэрэгсэл ашиглах, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх, дуусгавар болох, жолоодох эрхийн шалгалт авах журам, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хангах чиглэлээр хийсэн мэдээ, зурагт танилцуулга, иргэдээс гэмт хэргийн талаар төлбөртэй мэдээлэл авах тухай зэрэг мэдээллүүдийг авах боломжтой. Мөн цагдаагийн байгууллагад орох хүсэлтэй иргэдэд шалгалт авах журам, бүртгүүлэх тухай зар зэрэг цагдаагийн байгууллагын 2017 оны хагас жил, улиралд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг бүрэн эхээр нь оруулсан.

5.Цагдаагийн газрын урлаг спорт болон соён гэгээрүүлэх ажлын мэдээ мэдээллийг 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн Цагдаагийн ерөнхий газрын хэвлэл мэдээллийн төвийн presscenter@police.gov хаягаар хүргүүлэн нийтлүүлэн хамтран ажиллаж байна.

2017 онд тус цагдаагийн байгууллагын <http://arkhangai.police.gov.mn/> цахим вэб сайт, “Архангай цагдаа” фэйсбүүк хаяг болон www.youtube.com сайтад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр 36 удаа видео сэрэмжлүүлэг, 112 мэдээ мэдээллийг оруулан байгууллагынхаа үйл ажиллагааг иргэд, олон нийтэд шуурхай хүртээмжтэй хүргэж ажиллаа. “Архангай цагдаа” фэйсбүүк хаяг нь одоогоор 4.600 дагалдагчтай, 18000 гаруй хандалттай байна.

Хууль зүй дотоод хэргийн сайдтай Архангай аймгийн Засаг даргын 2017 онд хамран ажиллах талаар байгуулсан гэрээний дагуу орон нутгийн санхүүжилтээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тоног төхөөрөмж /police reader бэлэн бус торгуулийн төхөөрөмж, согтуурал хэмжигч багаж, согтуурал тандагч, станц, сандал г.м/ худалдан авах 30000000 /гуч сая/ төгрөгийг шийдвэрлэн харилцуулсан үнийг судалгаагаар “SEC TEK” ХХК-аас /Police reader/ бэлэн бус торгуулийн төхөөрөмж 2 ширхэг, станц 20 ширхэг, согтуурал хэмжигч багаж 19 ширхгийг тус тус худалдан авсан. Мөн сумдын Засаг дарга нартай байгуулсан “Гурвалсан гэрээ”-ний дагуу Ихтамир, Цахир, Эрдэнэмандал, Жаргалант, Өгийнуур, Хашаат, Цэнхэр сумд орон нутгийн төсвөөс тус тус нийт 7 ширхэг /Police reader/ бэлэн бус торгуулийн төхөөрөмж худалдан авах төсвийг шийдвэрлэсэн байна.

Орон нутгийн хэсгийн төлөөлөгч нарыг албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай туулах чадвар сайтай автомашинаар хангах ажлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат Хашаат, Хотонт, Эрдэнэмандал, Хайрхан, Өлзийт, Батцэнгэл, Цэцэрлэг зэрэг 7 сумдын хэсгийн төлөөлөгч нарт Япон улсад үйлдвэрлэсэн YAMAHA маркийн 7 ширхэг мотоцикл олгосон. Мөн Хангай, Эрдэнэмандал, Өндөр-Улаан, Жаргалант сумдын Эрүүл мэндийн газар болон Засаг даргын тамгын газарт ашиглагдаж байсан автомашиныг бланс хооронд шилжүүлсэн байна.

Цагдаагийн газрын алба хаагчдын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор “Хурлын заал”-ны засвар үйлчилгээнд 15000000 /Арван таван сая/ төгрөгийг орон нутгийн санхүүжилтээр шийдвэрлэн засварлан алба хаагчдын ажиллах таатай орчныг бүрдүүллээ.

Хашаат сумын Тарнын гүүрний зам тээврийн хяналтын төвийн барилгын засварын ажлыг дуусгахад шаардлагатай төсөв санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр танилцуулга, албан бичгийг удаа дараа холбогдох газруудад хүргүүлсний үр дүнд 120000000 төгрөгийн санхүүжилтийг Авто тээврийн үндэсний төвөөс шийдвэрлэн, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг тус төвөөс зохион байгуулан “Мон Энержи” ХХК гүйцэтгэн 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

Тус хяналтын төвийн барилгын гүйцэтгэгч “Тэнгэр түшиг” ХХК-иас баталгаат хугацаанд тухайн барилгад шаардлагатай даалгасан ажлуудыг гүйцэтгэж байна.

-Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийсэн ажил, арга хэмжээ

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр баталсан Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, түүнийг дагаж батлагдсан бусад хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг алба хаагчдад шуурхай хүргэх, сургалт, сурталчилгааны ажлыг тасралтгүй зохион байгууллаа.

Шинэчлэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх тухай хууль, Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулиудаар тасаг албадын дарга нар цагдаагийн газрын батлагдсан орон тоогоор 133 алба хаагчид цагдаагийн албаны тухай хуулийн чиглэлээр 46 удаа давхардсан тоогоор 6118 алба хаагчид, Эрүү, Зөрчлийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн чиглэлээр 24 удаа 3192 алба хаагчид, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн чиглэлээр 23 удаа 2029 алба хаагчид, бусад хууль тогтоомжийн чиглэлээр 33 удаа 4389 алба хаагчид нийт 148 удаа 18654 алба хаагчдад сургалт зохион байгуулжээ.

Цагдаагийн ерөнхий газрын Сүлд чуулгатай хамтран Цагдаагийн албаны тухай хуулийг хэн сайн мэдэх вэ танин мэдэхүйн тэмцээнийг алба хаагчдын дунд зохион байгуулж 20 асуултад амжилттай зөв хариулсан 3 алба хаагчийг шагнаж урамшуулав.

Зохион байгуулсан сургалтуудын үр дүнг тооцож тайлангийн хугацаанд 6 удаа 30-40 асуулт бүхий тестийн шалга лт авч, шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн а/129 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг алба хаагчдын дунд асуулт, хариултын “АХА” тэмцээнийг зохион байгууллаа.

Мөн цагдаагийн албаны тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд орон нутгийн сумдад урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах, цагдаагийн газраас зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулах, аймгийн Хуулийн хэлтсээс зохион байгуулсан сумдын Засаг дарга нарын сургалт зөвлөгөөн үед сургалт орох, хуулийн зүйл заалтаар гарын авлага бэлтгэн тараах зэргээр сурталчилж ажилласан байна.

Дээрх хуулийг зөрчил дутагдалгүй хэрэгжүүлэх зорилгоор тус цагдаагийн газар нь аймгийн Прокурорын газартай хамтран уулзалт зөвлөгөөнийг 6 удаа, хичээл сургалтыг 10 удаа зохион байгуулан давхардсан тоогоор нийт 226 алба хаагчийг хамруулан ажилласан бөгөөд хэсгийн төлөөлөгч, мөрдөгч, замын цагдаагийн зохицуулагч, прокурорын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор зөвлөгөөнийг шинэлэг байдлаар тус аймгийн Булган сумын “Чингисийн хүрээ” амралтын газар зохион байгуулж шинээр батлагдсан “Эрүүгийн хууль”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Зөрчил хянан шийдвэрлэх тухай” хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар зөвлөлдөж тодорхой шийдэлд хүрч ажилласны дүнд алба хаагчдаас дээрх хуулиудыг хэрэгжүүлэх явцад зөрчил дутагдал гаргах асуудал буурсан байна.

Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргаас хүргүүлсэн ажлын чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлаас баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн эх бичвэрт хүндэтгэл үзүүлж, хүлээн авах ёслолын ажиллагааг ахмад ажилтнууд, алба хаагчид, тэдний гэр бүл, хамтран ажилладаг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зарлан мэдээлж, үзэж сонирхуулах ажлыг зохион байгуулан дээрх арга хэмжээнээс санаа авч тус цагдаагийн газарт Цагдаагийн албаны тухай хуулийг хүндэтгэлтэйгээр залж байршуулан, 63 офицер, 64 ахлах бүрэлдэхүүнийг тангараг өргүүлж баталгаа авах ёслолын арга хэмжээг зохион байгууллаа.

Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид заасан хүний эрхийг хангах, мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус цагдаагийн газрын “Таньж олуулах өрөө”, “Мэдүүлэг авах тусгайлсан өрөө” албан өрөөнүүдийг 7800000 төгрөгөөр засварлан тохижуулж хуулийн хэрэгжилтийг хангасан.

Аймгийн ЗДТГазар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн Архангай-2 олон улсын байгууллагатай хамтран хуулийн байгууллагын хуульчдын дунд шинээр батлагдсан хуулиар “Эрх зүйн олимпиад”-ыг зохион байгуулж тус цагдаагийн газраас амжилттай оролцлоо.

-Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан тухай /гэрээ, санамж бичиг байгуулсан, хамтран ажилласан байдлын талаарх мэдээлэл/

Цагдаагийн газраас аймгийн Шүүх, Прокурор, Онцгой байдлын газар, Тагнуулын хэлтэс, Авто, тээврийн газар, Татварын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Шүүх шинжилгээний алба, Хүнс,

хөдөө аж ахуйн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Хөгжимт драмын театр, хэвлэл мэдээлэл зэрэг байгууллагуудтай 2017 онд хамтран ажиллах төлөвлөгөө, гэрээг үзэглэх арга хэмжээг зохион байгуулж хэрэгжилтийг ханган ажиллаа.

Орон нутгийн цагдаагийн тасаг, хэсгийн төлөөлөгч нарын амьдрах, ажил үүрэг гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэх, сумдын удирдлагын дэмжлэг туслалцааг сайжруулах зорилгоор оны эхнээс цагдаагийн газрын дарга, сумын Засаг дарга, хэсгийн төлөөлөгчийн дунд “Гурвалсан гэрээ” байгуулан хагас жилээр биелэлт үр дүнг тооцлоо.

Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран 2017 онд зохион байгуулсан **“Хуулийн байгууллагуудын нээлттэй хаалга”**-ны өдөрлөгөөр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд шинээр орсон өөрчлөлтүүд, бусад хууль, “school police” эцэг эхийн эргүүл“-ийн үйл ажиллагааг танилцуулах самбарыг шинээр хийж, хуулиар гарын авлага, санамж, сэрэмжлүүлгийг шинэчлэн гаргаж, 200 гаруй тарааж өгөх материалыг иргэд олон нийтэд тараан өгч 70 гаруй иргэнд эрх зүйн туслалцаа үзүүлж ажиллаа.

“Олон нийт цагдаа хамтын ажиллагаа сайжруулах”, “Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм”, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн 2016 оны 03 сарын 01-ний өдрийн 09 тоот тогтоолоор батлагдсан “Хөршийн хяналт”-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр”, “Архи тамхины зөв зохистой хэрэглээ”, “ХДХВ, ДОХ” өвчнөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр зохион байгуулсан сургалтад нийт 120 алба хаагчид оролцлоо.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, тасаг албадуудын ажил үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, иргэд, олон нийттэй хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Аюулгүй орчныг бүрдүүлэхэд иргэдийн оролцоог сайжруулъя” урианы дор тус газраас “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн арга хэмжээг 2017 оны 03 сарын 17-ны өдрийн 19:00-21:00 цагт аймгийн Хөгжимт драмын театрт, мөн хуульчдын өдрийг угтан хуулийн байгууллагуудын хамтарсан “Иргэн танд бид тусална” “Нээлттэй хаалганы өдөр”-ийг аймгийн Засаг даргын 2017 оны 05 сарын 23-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд 2017 оны 05 сарын 26-ны өдөр 11:00-15:00 цагт нутгийн захиргааны ордны урд талбайд тус тус зохион байгууллаа.

Цагдаагийн газар нь аймгийн Засаг даргын тамгын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Татварын хэлтэс, Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбоо, Эмнэсти интернэшнл, Төгс таван мэдрэмж ТББ хамтран “Иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх нээлттэй өдөрлөг” арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 10:00-16:00 цагийн хугацаанд ХАСУ нийтийн худалдааны төвд зохион байгуулав.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах” өдрийн арга хэмжээг аймгийн Хөгжимт драмын театрт тэмдэглэж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тэгш боломж олгох нь” сэдэвт илтгэлийг хэлэлцүүллээ. Илтгэлээрээ дамжуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч боловсрох нөхцөл боломж ямар байгаа, цаашид дээрх хүүхдүүдийг сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн амьдралд оролцох оролцоог хангаж ажиллах саналаа танилцууллаа.

“Хүний Эрхийн Олон Улсын өдрийг” хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын ажилтнаас санаачлан ЛЭОС-ийн Архангай дахь Салбар Зөвлөлтэй хамтран Эрдэнэбулган сумын 2, 3 дугаар сургууль дээр 12 дугаар сарын 11-ний өдөр 09-18.00 хугацаанд “Хүүхдийн эрх сургуулийн орчинд” сэдэвт өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгийн хүрээнд сургуулийн багш, ажилтан сурагчид, эцэг эхэд зориулсан Хүний эрхийн сэдэвт цуврал лекцийг онлайн хэлбэрээр зохион байгуулж, хүний эрхийн сэдэвт ном, сэтгүүл, гарын авлага, танилцуулгын үзэсгэлэнг гаргалаа.

Өдөрлөгийн үеэр 12-р ангийн нийгмийн сонгоны 100 сурагчийн дунд “Алтан хонх” асуулт хариултын тэмцээн, дунд ангийн сурагчдад “Та үүнийг мэдэх үү? Чихэртэй асуулт” багш ажилчдын дунд Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар АХА асуулт хариултын тэмцээн, Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар 8, 9-р ангийн сурагчдаас судалгаа авах зэрэг олон ажлуудыг зохион байгууллаа.

Хүний эрхийн үндэсний комиссын ажилтан АХА, Алтан хонх тэмцээнд амжилттай оролцсон багш сурагчдыг 3 байр эзлүүлж тус бүр өргөмжлөл мөнгөн шагналаар шагнав.

Дээрх үйл ажиллагаанд нийт 2 сургуулийн 1300 сурагч, 150 багш, 46 сургуулийн ажилтан, 80 гаруй эцэг эх хамрагдаж хүний эрх, хүүхдийн эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох иргэдийн үүргийн талаар мэдээлэл авлаа. Хүүхдийн эрх, сурч боловсрох эрх, үе тэнгийн дарамт хүчирхийлэл, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг гарын авлага материалыг 1200 ширхгийг тараан өгөв.

Арга хэмжээний хүрээнд хийсэн ажлын танилцуулга, мэдээллийг “Архангай цагдаа” фэйс хаягт тавьж, иргэд олон нийтийн санал, хүсэлтийг хүлээн авч ажиллаа.

-Байгууллагын удирдлагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар;

Тайлангийн хугацаанд аж ахуй нэгж байгууллага, иргэдээс цагдаагийн алба хаагчтай холбоотой 13 өргөдөл гомдолыг хүлээн авсаныг төрлөөр нь авч үзвэл: Хууль ёс, хүний эрх эрх чөлөө зөрчсөн 1, хэрэг материал дутуу шалгасан 2, хээл хахууль, шан харамж авсан 1, бусдыг зодож, эрх чөлөөнд нь халдсан 2, ЭБШХ болон бусад хууль дүрэм зөрчсөн 6, архи дан согтуурсан 1 зөрчилд 15 алба хаагч холбогдон шалгагдсан байна. Хүлээн авсан өргөдөл гомдлын 5 алба хаагчид холбогдох өргөдөл гомдол нотлогдоогүй, 2 алба хаагчид холбогдох өргөдөл гомдол нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн, 3 алба хаагчид сануулж, 3 алба хаагчийн цалин хасч, 2 алба хаагчид холбогдох өргөдөл гомдолд эргүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж байна. Хүлээн авсаг өргөдөл, гомдол тухай бүрт бичгээр хариу өгсөн. Алба хаагчид болон иргэдээс цагдаагийн газрын удирдлагад хандан 191 санал хүсэлт гаргасныг төрөлжүүлэн авч үзвэл: Ажилд орох, суралцахыг хүссэн 60, ажилд дахин орохыг хүссэн 2, ажил, өөрчлөх шилжихийг хүссэн 18, захиргааны чөлөө хүссэн 95, тэтгэвэр тэтгэмж хүссэн 10, бусад 6 өргөдөл хүсэлт байна. Хүлээн авсан өргөдөл хүсэлтийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасны дагуу хүлээн авч шийдвэрлэн холбогдох алба хаагч иргэдэд хуулийн дагуу хариуг өгч ажилласан байна.

-Нэвтрүүлсэн шинэлэг ажил, арга хэмжээ; -Судалгаа, дүн шинжилгээ хийсэн ажлын талаар;

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн алба хаагчийн шинэ санал, санаачилгыг дэмжих /код 116/ журам”-ыг хэрэгжүүлж ажлын хүрээнд тус цагдаагийн газрын алба хаагчдаас 2017 оны хагас жилд Цагдаагийн алба хаагч, ажилтны гаргасан санал, санаачилга нь шинэлэг, амьдралд хэрэгжих бүрэн боломжтой, цаг хугацаа, төсөв санхүү, хүний нөөц, техник, технологийн зохих тооцоололтой байх нийтлэг шаардлагыг хангасан санал, санаачилгыг илтгэх хуудсаар нэгтгэн авч цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулан хэрэгжүүлж байна.

Тус цагдаагийн газраас 2017 оны эхний 9 сард алба хаагчдаас гаргасан санал, санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх журмуудыг боловсруулан Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах, Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг судлан нийт 18 сум болон Эрдэнэбулган сумын 7 багийг хуваарилан “Хамтарсан баг”-ийг ахлан орон нутгийн хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг ажлыг идэвхжүүлж хариуцсан багт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, түдгэлзүүлсэн болон эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэх, алба хаагчдын нийгмийн баталгааг хангаж чиглэлээр: хүнсний ногоо тариалах, албаны хөнгөлөлттэй орон сууц барих, өндөр хүүтэй хугацаатай хадгаламж нээлгэх, албан өрөө тасалгааг засварлах, албаны байрны гадна болон дотоод засал, цэцэгжүүлэлт хийх, нэг загварын биеийн тамирын хослол захиалах, сахилга ёс зүйг сайжруулах, сургалт соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр: “АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР” гэсэн хаалттай бүлгэм нээн жижүүрийн мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгч нар хоногийн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийн алдагдсан эд зүйл, хүн, малыг эрэн сурвалжлах ажлыг шуурхай зохион байгуулах, цагдаагийн газрын ахлагч бүрэлдэхүүнийг Мягмар, Лхагва, Пүрэв гаригт улс орны гадаад, дотоод шинэ мэдээллээр нийт бүрэлдэхүүнд “Сонсгол”-ыг явуулж, тасгийн дарга, ахлах албан тушаалтныг Баасан гариг бүр хувь хүний болон байгууллагын соёл, хүн чанар, ажилд хандах хандлага, сэтгэлгээг өөрчлөх, стресс тайлах арга гэх мэт 5-10 минутын мэдээллийг тогтмол явуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн хэмжээнд 2016-2017 онд үйлдэгдсэн зам тээврийн осол хэргийн судалгаан дээр үндэслэн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор явуулын пост байгуулах ажлыг санаачлан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд удаа дараа хүсэл хүргүүлсний үр дүнд хөдөлгөөнт, явуулын үүрэг гүйцэтгэх 2017 онд Монгол улсад орж ирсэн “Ford Transit” маркийн авто машиныг шийдвэрлүүлэн дотор тоноглол, техник хэрэгслийг байршуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

-Бусад. /Удирдлага зохион байгуулалтын шинжтэй бүхий л ажил, арга хэмжээг тусгана/

Цагдаагийн газрын удирдлагаас албадын үйл ажиллагааг сайжруулж, оршиж буй алдаа дутагдлыг засч арилгах, орон нутгийн цагдаагийн хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажлын хариуцлага сахилгыг дээшлүүлэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, болзошгүй хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 32 “Үүрэг, зааварчилга, зөвлөмж, ажлын чиглэл”-ийг бичиж, биелэлт үр дүнг нь тооцов.

Цагдаагийн алба хаагчийн өргөсөн тангараг, хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, 3 хүүхдийн алтан амийг аварч онцгой гавьяа байгуулсан Архангай аймаг дахь Цагдаагийн газрын Цахир сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч У.Баяртогтохыг Хууль зүй, дотоод хэргийн яамны “Цагдаагийн алдар” тэмдгээр, Цагдаагийн ерөнхий газрын “Цагдаагийн гавьяа” тэмдгээр тус тус шагналаа. Архангай аймаг дахь

цагдаагийн газрын нийт алба хаагчид Цахир сумын нийт иргэд талархал илэрхийлж ажлын өндөр амжилт хүссэн.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, илрүүлэх чиглэлээр

Тус цагдаагийн газар нь 2017 оны эхний 11 сарын байдлаар иргэд, байгууллага, аж ахуй нэгжээс гэмт хэргийн шинжтэй нийт 895 гомдол мэдээлэл хүлээн авсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 151 буюу 14.4 хувиар буурсан байна. Дээрх гомдол мэдээллээс 290-д нь мөрдөн байцаах тасгийн мөрдөгч нар, 605 -т нь хэрэг бүртгэгч нар болон эрүүгийн мөрдөгч, хэсгийн төлөөлөгч нар хойшлуулшгүй ажиллагааг явуулан 484 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн, 405 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 7 гомдол мэдээллийг харьяаллын дагуу бусад цагдаагийн газар хэлтэст шилжүүлж, 12 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна. Шалгасан гомдол мэдээллийн 556 буюу 62.1 хувийг 5 хоногт, 333 буюу 37.2 хувийг 6 ба түүнээс дээш хоногийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн байна.

Урьд оны мөн үеэс өссөн хэргүүд: Иргэдийн өмчийн хулгай 121 бүртгэгдсэн нь 31 буюу 25.6 хувь, хүчиндэх гэмт хэрэг 6 бүртгэгдсэн нь 1 буюу 16.6 хувь, танхайрах гэмт хэрэг 6 бүртгэгдсэн нь 4 буюу 66.6 хувь, хүрээлэн буй орчны гэмт хэрэг 13 бүртгэгдсэн нь 8 буюу 61.5 хувь тус тус өссөн байна.

Урьд оны мөн үеэс буурсан хэргүүд: Бусдыг санаатай алах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь 3 буюу 75 хувь, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 149 бүртгэгдсэн нь 1 буюу 0.6 хувь, бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэрэг 13 бүртгэгдсэн нь 4 буюу 23.5 хувь, Хулгайлах гэмт хэрэг 212 бүртгэгдсэн нь 16 буюу 7.02 хувь, үүнээс мал хулгайлах гэмт хэрэг 71 бүртгэгдсэн нь 6 буюу 7.7 хувь, тээврийн хэрэгсэлийн хулгай 19 бүртгэгдсэн нь 40 буюу 67.8 хувь, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 35 бүртгэгдсэн нь 5 буюу 12.5 хувь тус тус буурсан байна.

Энэ онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 334 хэргээс 143 хэргийг илрүүлсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 26.7 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Илрүүлэлт 42.8 хувьтай байна. 2017 оны эхний 11 сард 488 хэрэгт шинээр дугаар авсан бөгөөд эрүүгийн хэргийг өнгөөр нь авч үзвэл хөнгөн хэрэг 266, хүндэвтэр 135, хүнд 84, онц хүнд 3 хэрэг бүртгэгдсэн байна.

Мөрдөн байцаах чиглэлээр:

Энэ оны 12 дугаар сарын 15-ны байдлаар 305 гомдол мэдээлэлд мөрдөн байцаах тасгийн мөрдөгчид эрүүгийн хэрэг болон хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нь урд оны мөн үетэй харьцуулахад 42 буюу 13.7 хувиар өссөн үзүүлэлтэй, 123 хэрэгт хэрэг бүртгэгч эрүүгийн хэрэг үүсгэж нийт 428 хэрэгт мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан бөгөөд одоо мөрдөн байцаалтанд нийт 5 гомдол мэдээлэл, хэрэг бүртгэлтэд 23, мөрдөн байцаалтад 12 хэргийн нийт 35 хэргийн үлдэгдэлтэй байна.

Мөрдөн байцаалт явуулсан хэргээс 208 буюу 24.8 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн нь урд оны мөн үетэй харьцуулахад 41 буюу 24.5 хувиар өссөн, 208 буюу 24.8 хувийг хэрэгсэхгүй болгосон нь урд оны мөн үеэс 131 буюу 38.6 хувиар буурсан эерэг үзүүлэлтэй байна. 37 буюу 14.4 хувийг нэгтгэн шийдвэрлэж нийт хэргийн 64.0 хувийг шийдвэрлэж ажилласан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлд заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 179 хэргийг сэргээн шалгасан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 7 буюу 4.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллагад нийт 1.295.000.000 төгрөгийн хохирол учирч, мөрдөн байцаалтын хэргийн улмаас 860.3 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн нь урд оны мөн үеэс 31 хувиар өссөн байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад сэжигтэн, яллагдагчийн 110.4 сая төгрөгийн нуугдмал өмч, хөрөнгө эд зүйлсийг битүүмжлэн ажилласан нь урд оны мөн үеэс 17.2 сая төгрөг буюу 15.58% хувиар өссөн байна.

Цагдаагийн газраас 2017 онд аймаг орон нутгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүгнэлт хийж, тодорхой төрлийн гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, албадын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор улсын хэмжээнд болон орон нутгаас зохион байгуулсан “Сар шинэ-2017”, “Түдгэлзүүлсэн хэрэг”, “Хяналт”, “Шийдвэрлэлт 2017”, “Ноолуур 2017”, “Цохилт 2017”, “Хот хоорондын хяналт шалгалт”, “Халтиргаа”, “Галт зэвсэг 2017”, “Хөдөлгөөний соёл”, “Наадам” “Хонх”, “Шинэ жил”, “Сэргээн шийдвэрлэлт 1,2”, “Оюутан тээвэр” зэрэг 21 ерөнхий, “Хохирол нөхөн төлүүлэлт”, “Хөрөнгө битүүмжлэх ажиллагаа”, “Ломбард”, “Хулгай”, “Илрүүлэлт оргодол”, “Хурд хамгаалах бүс”, “Хяналт”, “Цагийн хуваарь”, “Камержуулалт”, “Архив 2017”, “Судалгаа”, “Зуслан”, “Хүүхэд хамгаалал” “Төгсөлт” “Мэдэгдэл түүний хариу авалт”, “Аялал жуулчлал”, “Гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Согтуу”, “Эрхийн үнэмлэх”, “Ачаа тээвэр”, “Тулгалт”, “Хөдөлгөөнт эргүүл”, “Хурд хамгаалах бүс”, “Хот хоорондын хяналт шалгалт”, “Нийтийн тээвэр”, “Аюулгүй бүс”, “Эвдрэл гэмтэл”, “Өнгө үзэмж”,

“Илрүүлэлт” зэрэг 29 тусгай, нийт 50 арга хэмжээг төлөвлөгөө удирдамжийн дагуу 7-90 хоногийн хугацаагаар зохион явуулж, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааг сайжруулах бүсийн зөвлөгөөн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 45 хоногийн аян, Орон нутгийн замын хөдөлгөөний соёл 4 сарын аян, хичээлийн шинэ жил-замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах аян, Хайрлая хамгаалъя аян зэрэг арга хэмжээнд тус зохион байгуулж үр дүнг тооцсон.

Хэрэг бүртгэлтийн чиглэлээр

Аймгийн хэмжээнд 2017 оны эхний 11 сарын байдлаар 14114 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь урьд оны мөн үеийнхээс 5889 буюу 41.7 хувиар, зөрчил гаргасан 13679 иргэнд торгуулийн арга хэмжээ авсан нь урьд оны мөн үеийнхээс 5864 буюу 42.8 хувиар тус тус өсч, 489060900 төгрөгөөр торгож, 266 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 169 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан.

Зөрчил гаргасан 13478 иргэн буюу 98.5 хувийг торгуулийн хуудсаар 340901900 төгрөгөөр, 201 иргэн буюу 1.4 хувийг шийтгэврээр 148159000 төгрөгөөр торгосон байна.

Шийтгэл ногдуулсан эрх бүхий албан тушаалтнаар нь авч үзвэл, 13941 буюу 98.7 хувьд цагдаагийн эрх бүхий алба хаагч, 173 буюу 1.3 хувьд шүүгч тус тус шийтгэл ногдуулжээ.

Шийтгэврээр торгох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах шийтгэл ногдуулсан бүх зөрчлийг хянаж шийдвэрлэсэн хууль тогтоомжоор нь авч үзвэл, 960 буюу 7.2 хувийг “Захиргааны хариуцлагын тухай хууль болон Зөрчлийн тухай”, 12361 буюу 91.7 хувийг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Зөрчлийн тухай” хуулиар, 155 буюу 1.1 хувийг бусад хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэсэн байна.

Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 13478 зөрчил бүртгэгдсэний дотор хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих 12361, танхайрах 687, цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх 102, худалдаа, үйлчилгээний журам зөрчих 18, бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах 6, бусад 147 зөрчил тус тус бүртгэгджээ.

Дээрх зөрчлийн 2206 нь Даваа, 2030 нь Мягмар, 2407 нь Лхагва, 2163 нь Пүрэв, 2165 нь Баасан, 1488 нь Бямба, 1655 нь Ням гарагт тус тус үйлдэгдсэн байна.

Зөрчлийн тухай шинэчлэгдэн батлагдсан хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш бүртгэгдсэн зөрчлийн шийдвэрлэлтийг авч үзвэл нийт 409 зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзсан 147, харьяаллын дагуу 5, Зөрчлийн хэрэг нээн шалгасан 51, хялбаршуулсан журмаар 245 зөрчлийг шалгаж шийдвэрлэсэн. Хэрэг бүртгэх тасаг нь 51 холбогдогчтой 51 үйлдэлд зөрчлийн хэрэг нээн шалгаж, шийтгэл оногдуулахаар 47 хэргийг прокурорт шилжүүлэн, хэрэгсэхгүй болгох саналтай 2 хэргийг прокурорт шилжүүлсэн, одоо 2 хэргийг хугацаа сунган ажиллагаанд шалгаж байна.

Зөрчлийн улмаас иргэд, байгууллагад учруулсан хохирлыг хэрэг бүртгэлтийн шатанд 100 хувь төлүүлж ажилласан.

-Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр;

Эрүүгийн цагдаагийн тасаг нь 2017 онд нууц далд аргаар, бүлэг зохион байгуулалттайгаар үйлдэгдсэн гэмт хэрэг болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын шатнаас оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, түүнчлэн гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдүүдийн талаар мэдээ мэдээлэл цуглуулан баримтжуулан шалгаж ажилласнаар 237 холбогдогчтой, 948.4 сая төгрөгийн хохиролтой 245 хэрэг үйлдлийг илрүүлжээ. Үүнээс эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар 141, нөхөн илрүүлсэн 104 хэрэг, үйлдлийн материалжуулан мөрдөн шалгах ажиллагаа явуулан ажилласан байна.

Тус цагдаагийн газраас эрүүгийн цагдаагийн тасгаас тайлангийн хугацаанд хулгайлах төрлийн гэмт хэргийн нөхцөл байдалд үндэслэн “Хяналт” “Хулгай”, “Оргодол”, “Ломбард” “Түдгэлзүүлсэн хэрэг-45” хоногийн аян, “Сар шинэ-2017”, “Шийдвэрлэлт-2017”, “Сэргээн шийдвэрлэлт 1, 2”, “Илрүүлэлт-Оргодол”, “Хяналт” зэрэг арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хот, Дархан, Орхон, Булган, Баянхонгор, Өвөрхангай аймгууд болон аймгийн бүх сум орон нутгийн чиглэлд 9682 км замд 1750 литр шатах, тослох материал зарцуулан орон байрны хулгайн эрүүгийн дугаартай 13 хэргийн эд мөрийн баримт болох хулгайд алдсан эд зүйлийг ломбардад зарагдсан байсныг илрүүлж, түдгэлзүүлснээс сэргээсэн урьд оны болон энэ оны дугаартай хэрэг бүртгэлтийн хэргээс 20 хэргийг шийдвэрлэн, 31 хэргийг нөхөн илрүүлж, гэмт хэрэгт сэрдэгдсэн 15, оргодол этгээд 11 олж тогтоон баривчилж ажилласан байна.

Цагдаагийн газрын нийт алба хаагч нараас 95 илтгэх хуудас бичиж санд оруулснаас малын хулгайн гэмт хэргийн талаар 22, орон байрны хулгайн гэмт хэргийн талаар 34, оргодол этгээдүүдийн хаяг байршлын талаар 11, тээврийн хэрэгсэлийн хулгайн гэмт хэргийн талаар 7, хууль бус галт зэвсгийн талаар 5, гэр бүлийн хүчирхийллийн талаар 6, эдийн засгийн гэмт хэргийн талаар 4, байгаль орчны эсрэг гэмт хэргийн талаар 5 илтгэх хуудас тус тус бичсэн

байна. Уг илтгэх хуудаснаас батлагдсан илтгэх хуудас 17, үүнээс дайчлан баривчилсан оргодолын талаар 2 илтгэх хуудас байна. Нийт илтгэх хуудасны 78 илтгэх хуудас нь батлагдаагүй.

Түдгэлзүүлсэн хэргийг илрүүлж шийдвэрлэх, хүн эд зүйлийг эрэн сурвалжлах, АСАП сангийн үйл ажиллагаа:

Тайлангийн хугацаанд эрэн сурвалжлах ASAP сангийн бүрдүүлэлт, ашиглалтыг сайжруулах, эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 2017 онд цагдаагийн газрын даргаас албан даалгавар 1, дэд даргаас зааварчилга 3, үүрэг, ажлын чиглэлийг тухай бүр хүргүүлэн биелэлт үр дүнг тооцон ажилласнаар 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн байдлаар тус Цагдаагийн газрын алба хаагчдаас ASAP сангийн мэдээлэлтэй нийт 20812 удаа танилцаж, эрэн сурвалжлах чиглэлээр сураггүй алга болсон хүн 11, оргодол болон гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 50, хэн болох нь тогтоогдоогүй цогцос 0, мал амьтан 20, тээврийн хэрэгсэл 11, эд зүйл-69, шүүхээс даалгасан бусад хүн 8, аман зургаар 1, нийт 170 мэдээлэл оруулж улсын хэмжээнд зарлан мэдээлж ажилласан.

Мөрдөн байцаах албаны Эрэн сурвалжлах хэлтсийн даргаас 2017 оны 06 дугаар сарын 13-ны өдөр ирүүлсэн 11/7-3895 дугаартай албан бичгийн дагуу Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах тасагтай хамтран ASAP санд эрэн сурвалжлах чиглэлээр зарлан мэдээлсэн мэдээллийг эрүүгийн хэрэг бүртэй тулгалт хийж 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар сураггүй алга болсон хүн 12, оргодол 13, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 27, мал амьтан 5, тээврийн хэрэгсэл 8, эд зүйл 13, шүүхээс даалгасан бусад хүн 4, энэ оны болон урьд онд зарлан мэдээлсэн нийт 82 маягтын эрэн сурвалжлалтыг зогсоож ажиллаа.

Эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал амьтан, эд зүйлийн мэдээллийг санд зарлан мэдээлж эрх бүхий алба хаагч нарт тухай бүр мэдээллийг санд бүрэн оруулж хэвшүүлэх, санд орсон мэдээлэлтэй тогтмол танилцаж байх чиглэлээр албадын дарга, алба хаагч нарт зөвлөмж 1, зааварчилга 3-г хүргүүлэн эрэн сурвалжлах санд алдаатай оруулсан мэдээллийг тухай бүр хариуцсан тасгийн дарга нар хянаж илэрсэн зөрчлийг засаж, дахин давтан зөрчил гаргахгүй байх зорилгоор 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс 2017 оны дүгээр сарын 15-ны өдрийн хооронд “Тулгалт” хэсэгчилсэн арга хэмжээг Цагдаагийн газрын даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, эрэн сурвалжлах санд зарлан мэдээлэл хийгдээгүй 8 хэрэгт шаардлагатай эрэн сурвалжлалтыг зарлан мэдээлж зөрчлийг арилгуулж ажилласан. 2017 оны 12 дугаар сарын 14-ны байдлаар санд алдаатай болон зөрчилтэй шивэгдсэн маягт байхгүй байна.

Тус цагдаагийн газраас 2017 онд эрэн сурвалжлах ажлын чиглэлээр “Сар шинэ”, “Түдгэлзүүлсэн хэрэг”, “Хулгай”, “Хяналт-2017”, “Шийдвэрлэлт-2017”, “Илрүүлэлт-Оргодол”, “Тулгалт” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг батлагдсан удирдамж төлөвлөгөөний дагуу зохион явуулж, арга хэмжээний хүрээнд нийт 114 хэргийг нөхөн илрүүлж, сангаар эрэн сурвалжлагдаж байсан оргодол этгээд 13, гэмт хэрэгт сэрдэгдсэн 27 этгээдийн орогнож буй хаяг байршлыг олж тогтоон баривчилж, холбогдох тасаг албадуудад хүлээлгэн өгч ажилласан.

Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр

Тус цагдаагийн газраас эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 2017 онд нийт 136,5 сая төгрөгийн хохиролтой, 38 холбогдогчтой, 22 материалд эрүүгийн хэрэг үүсгүүлэх, хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгуулахаар материалыг цагдаагийн газрын Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах тасаг болон Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн ажилласан.

Мөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчлийн шинжтэй нийт 35 гомдол мэдээлэл хүлээн авч шалгагдсанаас 34.360.000 мянган төгрөгийн хохиролтой, 17 холбогдогчтой, 13 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж 22 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг болон зөрчлийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлж шийдвэрлэсэн.

Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2015 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн 02 дугаартай/Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн, гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай/ албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төв зам дагуу эргүүл пост ажиллуулах хуваарийн дагуу Хотонт, Цэнхэр, Ихтамир, Өндөр-улаан, Тариат, Цахир сумдын алба хаагчдыг Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газрын алба хаагчидтай хамтран эргүүл шалгалт хийх хуваарийг гаргаж тодорхой ажил арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж үр дүнг тооцож ажиллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, Тагнуулын хэлтэстэй 1 удаа хамтарсан шалгалт зохион байгуулж хяналт тавьж ажиллаа.

Цагдаагийн газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр баталсан удирдамж

төлөвлөгөөний дагуу “Цохилт-1” хэсэгчилсэн арга хэмжээг сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, Зооноз өвчин судлалын Цахир сум дахь салбарын ажилчидтай хамтран Архангай аймгийн Цахир сумын төв зам дагуу худалдаа үйлчилгээ эрхэлдэг дэлгүүр гуанз зоогийн газруудад гэнэтийн шалгалт хийж 5 иргэнээс 31 ширхэг тулмалсан тарвагыг хурааж байгаль орчны хяналтын улсын байцаагчаар нөхөн төлбөр акт тавиулж, торгуулийн арга хэмжээ авч, тарвагыг устгах арга хэмжээ авах ажлыг зохион байгуулсан.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх талаар:

Аймгийн хэмжээнд 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 488 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 212 буюу 43.4 хувийг хулгайлах төрлийн гэмт хэрэг, үүний 71 буюу 33.4 хувийг мал хулгайлах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Малын хулгайн бүртгэгдсэн 71 гэмт хэргийн 68 буюу 95.7 хувийг бүртгэгдэх үедээ сэжигтнээр татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг шалгагдаж, илрүүлэлт 40.9 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 6 хэргээр буюу 28.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар тус аймгийн хэмжээнд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй мал хулгайлах 39 хэрэг, мөрдөн байцаалтаас оргон зайлсан үндэслэлээр түдгэлзүүлсэн 2 хэрэг хэрэг байна.

Архангай аймгийн “Хасу” худалдааны төвд махны худалдаа эрхэлж байгаа ченж нарын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор Улаанбаатар хот руу мах, мал тээвэрлэх үед гарал үүслийн бичгийг нядалсан малын толгойн зурагтай үзэж тулган шалгаж бүртгэлд хамруулан явуулж байна.

Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, Хүнс хөдөө аж ахуйн газраас баталсан мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх малчдын сайн дурын үүсэл санаачилгаар “Малчдын бүлэг, нөхөрлөл байгуулах үлгэрчилсэн дүрэм”-ийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр дэд даргаас 3 удаа зааварчилгааг сум дундын цагдаагийн тасгийн дарга, сумдын хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлж 2 удаа сургалт зохион байгуулсан.

Аймгийн Цагдаагийн газрын дарга, давж заалдах шатны шүүхийн шүүгч, Прокурорын газрын дарга, Иргэдийн хурлын нарын бичгийн дарга, аймгийн Цагдаагийн газрын олон нийттэй харилцах ахлах байцаагч, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга нар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу 2017 оны 05 дугаар сарын 15-аас 17-н, 2017 оны 06 дугаар сарын 02-оос 04-ийг хүртэл хугацаанд нийт 12 сумдад шалган зааварчлах чиглэлээр ажиллах хугацаанд сумдын багийн дарга нартай биечлэн уулзаж “Малчдын бүлэг”, “Хөршийн холбоо” байгуулах чиглэлээр яриа таниулга хийж, иргэдтэй хийсэн уулзалт, сургалтын үеэр мал хулгайлах гэмт хэргийн талаар мэдээ мэдээлэл авах, иргэдээс гаргасан асуултад зөвлөгөө өгч ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргын баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 45 хоногийн хугацаатай ажлын” төлөвлөгөөний хүрээнд Эрдэнэбулган сумын мал эмнэлгийн мэргэжилтэн, аймгийн хүнс хөдөө аж ахуйн газрын халдварт өвчин судлал хариуцсан их эмч нарыг оролцуулан аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа “Хасу”, “Малчны” захуудад хувиараа мал, махны худалдаа эрхэлж байгаа иргэд ченжүүдийг аймгийн Засаг даргын тамгын газрын иргэний танхимд малын хулгайн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд хүлээлгэх хариуцлагын талаар сургалт, яриа таниулга хийж, тэдний санал хүсэлтийг авч ажилласан.

Цагдаагийн газрын даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр “Цохилт-2017” хэсэгчилсэн арга хэмжээг 2017 оны 04 дүгээр сарын 15-аас 2017 оны 6 дугаар сар 20-ыг хүртэл хугацаанд зохион байгуулж малын хулгайн гэмт хэргийг илрүүлэх, мэдээ мэдээлэл шалгах чиглэлээр мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Цэнхэр, Төвшрүүлэх, Хотонт, Өгийнуур, Хашаат, Батцэнгэл сумын чиглэлд 4 удаа албан томилолтоор ажиллаж бүртгэгдэх үедээ яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй 16 хэргийг нөхөн илрүүлж, ASAP сангаар эрэн сурвалжлагдаж байсан 2 оргодол, сэрдэгдсэн этгээдээр эрэн сурвалжлагдаж байсан 1 иргэний хаяг байршлыг тогтоож дайчлан баривчилж хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт шилжүүлэн ажиллаж байна.

-Замын цагдаагийн албаны чиглэлээр;

Хариуцсан нутаг дэвсгэрт эхний 11 сарын байдлаар 35 холбогдогчтой 35 гэмт хэрэг, осол бүртгэгдсэн ба авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 5 буюу урд оны мөн үеэс 5 хэргээр буюу 12,2 хувиар буурсан байна.

2017 онд 118239 тээврийн хэрэгсэл шалгаж 14180 зөрчил илрүүлэн, 13669 иргэнийг 410.602.900 төгрөгөөр торгох арга хэмжээ авсан нь урьд оны мөн үеэс 450 буюу 31,3 хувиар өссөн байна.

2017 онд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 511 зөрчил илрүүлж, 275 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 236 иргэнийг шүүхээр баривчлуулан ажиллав.

Энэ онд гудамж замд хийсэн эргүүл, хяналт шалгалтаар 14180 зөрчил илрүүлснээс

согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 511 зөрчил илрүүлэн 275 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж 236 жолоочийг шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж торгуулийн хуудсаар нийт 133669 хүнийг 410.602.900 төгрөгөөр торгох арга хэмжээ авч замын хөдөлгөөнд үргэлжлүүлэн оролцох боломжгүй 821 тээврийн хэрэгслийг түр саатуулж ажилласан байна.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Замын цагдаагийн албанаас ирүүлсэн календарчилсан төлөвлөгөөний дагуу **“Эвдрэл гэмтэл техникийн байдал”** сэдэвт арга хэмжээг 3 удаа, **“Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэх хэрэгсэл”** сэдэвт арга хэмжээг 3 удаа, **“Тээврийн хэрэгслийн өнгө үзэмж”** сэдэвт арга хэмжээг 3 удаа, **“Ачааны авто машин ачаа тээвэрлэлт”** сэдэвт арга хэмжээг 2 удаа, **“Эрчимжүүлэлт”** гудамж замын хяналт шалгалт арга хэмжээг, **“Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл”** аян, **“Хичээлийн шинэ жил”**, **“Оюутан тээвэр-2”**, **“Баяр наадам”**, **“Нийтийн тээвэр-Аюулгүй зорчигч”**, **“Хамгаалах бүс” 1 сарын аян**, **“Хяналт”**, **“Эрчимжүүлэлт”** зэрэг нийт 20 нэгдсэн болон тусгай арга хэмжээнүүдийг зохион байгуулжээ.

Улсын болон олон улсын чанартай босоо, хэвтээ тэнхлэгийн дагуух хатуу хучилттай авто замуудад хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Монгол улсын Хууль зүй дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Монгол улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хамтран зохион байгуулж байгаа **“Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл”** аяныг орон нутагт зохион байгуулан аяны хүрээнд Архангай аймгийн Хашаат сумын Номгон багийн Элсэн тасархайн “Тарны гүүр”-ийг хяналтын цэгийг байнгын ажиллагаатай болгон Архангай, Булган, Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газрын дарга нарын хамтран баталсан хуваарийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Үүнтэй холбоотойгоор Замын цагдаагийн албаны дарга 2017.09.15-аас 16-ны өдрүүдэд орон нутагт ажиллан замын цагдаагийн тасгийн үйл ажиллагаатай танилцан аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нартай уулзаж, тус аймгийн Хашаат сумд байрлалтай “Тарны гүүр”-ын хяналтын цэгийг үйл ажиллагааг идэвхжүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор цахилгааны сүлжээнд холбох ажлыг зохион байгуулахыг орон нутгийн удирдлагуудад хариуцуулан, тус цэгт замын цагдаагийн алба хаагчаас гадна мөрдөгч хамт ажиллуулах талаар үүрэг, ажлын чиглэл өгч тус бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах шалгах багаж болон 1 ширхэг таблет гардуулж өгснийг хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Осол хэргийн шалтгаан нөхцөлийг судлан авто замын нөхцөл, тэмдэг тэмдэглэлийг сайжруулах ажлын хүрээнд Цэцэрлэг- Тосонцэнгэл чиглэлийн зам болон “Цагаан даваа”-аас “Чулуутын гүүр” хүртэлх авто замын 165 ш төмөр бетон чиглүүлэгч шон, 134 ш анхааруулах, мэдээлэх, заах тэмдэг, 88 метр туузан хашлагыг тус тус шинэчлэн сайжруулсан. Мөн осол, хэрэг ихээр үйлдэгддэг цэгүүд болох “Шуугиагийн горхи”-ийн зам 92 дахь км-т шинээр 25 ш чиглүүлэгч шон, “Шар булгын даваа”-ны арын тойрог буюу 103 дахь км-т 32 ш чиглүүлэгч шон шинээр суулгаж, “Цагаан даваа”-ны арын тойргийн туузан хашлага авто машин мөргөж эвдэрсэн байсныг 20 метр хашлагаар сольж, “Цагаан даваа”-ны 9 дэх км-т огцом эргэлт тойруутай хэсэгт 68 метр туузан хашлага шинээр суулгах зэрэг ажлууд хийсэн. Мөн Хархорин-Цэцэрлэг чиглэлийн замд анхааруулах тэмдэг 20 ш, чиглүүлэгч шон 26 ширхгийг шинээр суулгаж, 108 дахь км-с 113 км-т буюу “Янгиртай хясаа” орчмын огцом эргэлттэй, тахир замтай хэсгүүдэд 2,5 км замын хэвтээ тэмдэглэлийг сэргээн будаж, зорчих хэсэг дээр анхааруулах тэмдэглэл 14 ширхгийг тус тус будаж сэргээсэн байна.

Түүнчлэн тухайн замуудад хөдөлгөөнд оролцогчдыг мэдээллээр хангах, осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор жолооч нарт 740 ширхгийг санамж сэрэмжлүүлгийн хуудас тарааж, “АВ” телевизээр 5 удаа мэдээлэл хийж, “Архангай замын цагдаа”, “Орон нутгийн замын цагдаа” facebook цахим хуудсуудаар 6 мэдээлэл хийж ажиллав.

Зам тээврийн хөгжлийн яамны Авто замын хэрэгжилтийг зохицуулах газар Замын цагдаагийн албанаас хамтарч олон улсын болон улсын чанартай авто зам, замын тэмдэг тэмдэглэлийг шалгах, “Хар цэг”-ийн судалгаанд авагдсан газруудын замын зохион байгуулалтыг үзэж шалгах ажлын хүрээнд тус аймагт 2017 оны 04 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд ажиллаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Зам тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын замын ашиглалт, засварын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Зам тээврийн хөгжлийн төв Төрийн өмчит үйлдвэрийн газрын төвийн бүс нутаг хариуцсан мэргэжилтэн, Замын цагдаагийн албаны Орон нутгийн хяналтын хэлтэс ахлах зохицуулагч, Архангай аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, зохицуулагч нар болон замыг хариуцсан “Архангай АЗЗА” ТӨХК, Хархорин сумын АЗЗА” ТӨХК-ний гүйцэтгэх захирал, холбогдох албан тушаалтнууд оролцож Хархорин Цэцэрлэгийн А 0602, Цэцэрлэг Тосонцэнгэлийн А 0603 дугаартай замын Архангай аймгийн Хотонт сумын Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутгийн зааг Баян голын гүүрнээс Цэнхэр сумын Тамирын голын

гүүр хүртэл Хархорин сумын АЗЗА хариуцсан, Цэнхэр сумын Тамирын голын гүүр Аймгийн төв Эрдэнэбулган сум, Эрдэнэбулган сумаас Цахир сум, Завхан аймгийн Их-уул сумын нутгийн зааг Солонготын даваа хүртэл Архангай АЗЗА ТӨХК-ны хариуцсан замуудад үзлэг шалгалтыг хийж дүгнэлт гарган дээрх авто замуудын засвар арчлалтыг хариуцсан байгууллага болох "Архангай авто зам засвар арчлалт" ТӨХК-ны удирдлагад 15 төрлийн ажлын чиглэл өгсөн.

Үүний дагуу тус байгууллагаас дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

1. А 0602 дугаартай Хархорин Цэцэрлэг чиглэлийн замын 100-125 дахь км замд 371 тонн халуун асфальт бетоноор 3091м/кв газарт нөхөөс хийсэн, 2,5 км замын хэвтээ тэмдэглэл шинээр хийх буюу хуучныг сэргээж будсан. 8 ш босоо тэмдэг шинээр суулгасан. Ан цав хагарал засах, чиглүүлэгч шонгийн тэмдэглэл сэргээж будах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. ЗТХЯам-нд хүсэлт уламжилж 0.55 км замын шинэчлэлтийн ажлыг хийж эхэлсэн 40% ийн гүйцэтгэлтэй байна.

2. А 0603 Дугаартай Цэцэрлэг–Хархорин чиглэлийн замын 00-135 дахь км-т 82 тонн халуун асфальт бетоноор 1516 м/кв талбайд нөхөөс хийсэн, 35 км замын хэвтээ тэмдэглэл сэргээх, шинээр будаж, 135 ш замын тэмдэг шинээр суулгасан байна. Мөн үерийн улмаас эвдэрсэн хөвөө шуудуу засварласан. / Өндөр-Улаан сум Донгой баг бараан чулуутын ам/, Өндөр-Улаан сум Хануйн гүүр орчим 1км замд суурийг цементээр бэхжүүлж хучилт хийх ажил 50% тай хийгдэж байна.

3. А 27 дугаартай Лүн–Дашинчилэн чиглэлийн замын 306-328 дахь км замын ан цав, хагарлыг засварлах, чиглүүлэгч шонгийн тэмдэглэл будах сэргээх ажлууд хийгдсэн ба 2017 оны 08 дугаар сарын 18-19-нд шилжих шөнө үер буусны улмаас 306-309 дэх км-т 4 хэсэг газарт хучилт урсах, хөвөө нарийсах зэрэг эвдрэл гарсан байсныг 2017 оны 08 дугаар сарын 20- 25- ны өдрүүдэд засварласан байна.

Монгол улсын Хөдөлмөрийн сайд, Хууль зүйн сайдын 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/180, А/217 дугаар тушаалаар баталсан "Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журам, Хууль зүйн сайдын 2015 оны А/186 тоот тушаалаар баталсан "Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх журам"-ыг хэрэгжүүлэн жолооч бэлтгэх үйл ажиллагаа явуулж байгаа авто курсүүдийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасагдсан 175 иргэнээс эрх сэргээх шалгалт авч Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвд хүргүүлсэн ба тус төвөөс ирүүлсэн үүрэг, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

БХТН-ийн Архангайн зөвлөл, Лам гурван эрдэнэ ХХК, МСҮТ-н жолооны курс, Цэнхэр буян ХХК, Хөх хангай ХХК-ийн жолооны курсүүд В ангилал, В-ВС-д ангилал ахиулах сургалт, замын хөдөлгөөний хууль дүрэм болон жолооны давтан дамжааны сургалтуудыг хичээллүүлж тайлангийн хугацаанд жолооны курсүүдээс ирүүлсэн тушаалуудыг хүлээн авч хянан Лицензийн төвд хүргүүлэн цохолтын хугацааг үндэслэн сургалтын хугацааг тооцож дээрхи курсүүдэд элсэгчээс мэргэжлийн шалгалт авч тэнцсэн элсэгчийн материалыг Лицензийн төвд хүргүүлэв.

Тээврийн хэрэгсэл жолоодох шалгалтад тэнцсэн 709 жолоочийн материалыг бүртгэн авч Бүртгэл хяналтын төвд хүргүүлж, шинээр хэвлэгдэж ирсэн 1089 жолоочийн үнэмлэхийг олгов.

-Нийтийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр;

Эрүүлжүүлэх баривчлах үйл ажиллагаа:

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ зөрчил гаргасан нийт 780 хүнийг эрүүлжүүлэх байранд хүлээн авч, биед эрүүл мэндийн үзлэг хийж бүртгэл хөтлөн, захиргааны зөрчлийн тоо бүртгэлийн нэгдсэн санд оруулан жижүүрийн эмч, цагдаагийн байнгын хяналтан дор эрүүлжүүлээ. Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 хүнээр буюу 3,7%-аар өссөн үзүүлэлттэй байна. Эрүүлжүүлэгдсэн 780 хүнээс 749 хүний үйлчилгээний хөлсөнд 3.108.350 төгрөгийг төрийн сангийн зохих дансанд тушааж, төлбөрийн чадваргүй 31 хүний багийн засаг даргын тодорхойлолтыг авч санхүүтэй тооцоог хийсэн.

Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/227 тоот тушаалаар батлагдсан Баривчлах шийдвэр биелүүлэх журмын хэрэгжилтийг хангаж Зөрчлийн тухай хуульд заасны дагуу сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн шийтгэврээр 7-30 хоногийн хугацаагаар 182 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 150 хүнээр буюу 5 дахин өссөн үзүүлэлттэй байна. Захиргааны журмаар баривчлагдаад суллагдсан 178 хүний 1038 хоногийн 9.333.000 төгрөгийн тооцоог төрийн сагийн зохих дансанд тушаалган санхүүтэй тооцоог хийсэн. 2 хүний хугацаа дуусаагүй баривчлах байранд хүмүүжиж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код-623, Монгол улсын засгийн газрын 1996 оны 91 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж зөрчил гаргасан 43 этгээдийг захиргааны журмаар албадан саатуулсныг саатуулах байранд хүлээн авч, биед болон эд зүйлд үзлэг хийж, эд зүйлийг тэмдэглэл хөтлөн түр хураан авч, бүртгэл хөтлөн, жижүүрийн

эмч цагдаагийн байнгын хяналтад саатуулж, хугацаа дуусмагц хариуцсан байцаагчид нь хүлээлгэн өгч зөрчлийг шийдвэрлүүлж ажиллаа. Саатуулагдсан хүмүүсийг урд оны мөн үетэй харьцуулахад 43 хүнээр өссөн үзүүлэлтэй байна.

Эрүүлжүүлэх баривчлах байрыг стандартад нийцүүлэх, алба хаагчийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор дотоод нөөц бололцоог ашиглан засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Эрүүлжүүлэгдсэн болон баривчлагдсан этгээдүүдийг дахин зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 7 хоногийн Даваагаас Баасан гарагуудад батлагдсан хуваарийн дагуу алба хаагч, ЭСБ-ны эмч, цагдаа нар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль эрхийн акт, Архи тамхины хор нөлөө, эрүүл мэндийн тодорхой мэдлэг мэдээлэлтэй болгох сургалтын сэдвийг бэлтгэн сургалт зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 796 хүн хамрагдсан байна. Сургалтын үр дүнд удаа дараа давтан эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан хүний тоо буурсан үзүүлэлтэй байна.

-Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны чиглэлээр;

Тус тасгаас 2017 оны 12 дугаар сарын байдлаар уламжлалт цагаан сар, хаврын хурдан морьдын уралдаан, мөргөл, тахилга, спорт, урлагийн тоглолт болон Тулгар төрийн 2226 жил, Их монгол Улсын 811, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Архангай аймгийн 94 жилийн ойн баяр, Эрдэнэбулган сумын 25 жилийн ой, бусад сумдын баяр наадам зэрэг 20 наадам, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дахин сонгуулийн 102 хэсгийн хорооны хамгаалалт, Монгол улсын хүчит арслан Дуламжавын Мөнх-Эрдэнэд хүндэтгэл үзүүлэх наадам, Батцэнгэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 90 жил ойн арга хэмжээ, Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн “Бага сургууль цэцэрлэгийн цогцолборын 60 жилийн ой”, Архангай аймгийн Хайрхан суманд уламжлал болгон зохион байгуулдаг Их Богд Цагаан суваргын тахилга “Хайрханы шигшмэл хурд-2” баяр наадам, БНХАУ-ын “Соёлын наадам-2017”, Ихтамир суманд зохион байгуулагдсан “Монгол сарлаг-2017” наадам, Багш нарын цалин нэмэгдүүлэх түр хорооноос зохион байгуулсан тайван жагсаал, Монгол Улсын Хурлын гишүүн Ё.Баатарбилэгийн санаачилгаар зохион байгуулсан “Намарын спартакиад”-ын Марафон гүйлтийн тэмцээн зэрэг 29 арга хэмжээний хамгаалалтад давхардсан тоогоор 402 алба хаагч 62 автомашин 12514 хүн цагийн үүрэг гүйцэтгэсэн.

Тус аймгийн Өгийнуур, Хашаат сум малын гоц халдварт цэцэг өвчний шинж илэрсэн тул 2016 оны 11 сарын 16-ны өдөр Аймгийн Засаг даргын Хорио цээрийн дэглэм тогтоох, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай А/481, А/482 тоот захирамжийн дагуу малын гоц халдварт өвчин гарсан сумуудад хорио цээрийн дэглэм тогтоож хамгаалалтад давхардсан тоогоор 38 албан хаагч ажиллаж 2017 оны 02 дугаар 09 ний өдрийн аймгийн Засаг даргын А/48 тоот захирамжаар Хорио цээрийг цуцалсан тус цагдаагийн алба хаагч нар хамгаалалтыг зохих түвшинд гүйцэтгэн ажилласан. 2017 онд гамшиг, хорио цээрийн дэглэмийн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах, дэг журам сахиулах чиглэлээр нэгдсэн төлөвлөгөөнд тодотгол хийж аймгийн Засаг дарга бөгөөд аймгийн онцгой комисс дарга Ц.Мөнхнасан, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Э.Золбаатар, Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Д.Эрдэнэбаатар нар хянан баталгаажуулсан. 2017 онд тус аймгийн Чулуут, Цахир, Өндөр-Улаан, Ихтамир, Жаргалант сумдын нутагт малын гоц халдварт мялзан өвчин гарч хорио цээрийн дэглэмийн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах, дэг журам сахиулах чиглэлээр 1 офицер, 6 цагдаа бусад мэргэжлийн байгууллагын алба хаагч нарын хамт хамгаалалтанд ажилласан. Энэ хугацаанд хорио цээрийн дэглэм зөрчсөн гэмт хэрэг зөрчил гаргаагүй хамгаалалт хэвийн явагдсан, хамгаалалтын мэдээг тухай бүр нь Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төвд нөхцөл байдлаа танилцуулан ажилласан.

Тус тасгаас “Илрүүлэлт-оргодол” нэгдсэн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу 2017 оны 9 дүгээр сарын 30-наас 11 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулав.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд орон нутгийнхаа эрүү, хэв журмын нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч гэмт хэрэг, захиргааны зөрчил их үйлдэгддэг цаг, эмзэг цэгүүдийг эргүүлийн чиглэл хугацаанд оруулж, эргүүлд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад агсамж, энгэрийн камерыг хуулийн дагуу хэрэглэх чиглэлээр зааварчилга өгч, эргүүлийг 15-19 цаг хүртэл явган эргүүл, 19-23 цаг хүртэл хөдөлгөөнт эргүүл, 23-03 цаг хүртэл шөнийн эргүүл гэсэн хуваариар гарган ажиллуулж байна.

Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Эрдэнэбулган сумын засаг даргатай хамтран гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Эрдэнэбулган сумын аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтан, алба хаагчдыг нийтийн эргүүлд ажиллуулах журмыг батлуулж, өдөр бүр нэг байгууллагаас хоёр алба хаагч, нэг авто машинтай 20-00 цагийн хооронд нийтийн эргүүлийн үүрэг гүйцэтгэх хуваарийг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл гарган ажиллуулж байна. Энэ хугацаанд 48 байгууллагын 96 алба хаагч 48 автомашинтай цагдаагийн алба хаагчтай хамтран хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэж ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр нийт бие бүрэлдэхүүнийг хамруулсан нэгдсэн эргүүлийг 3 удаа зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор давхардсан тоогоор 80 аж ахуй нэгжид албан мэдэгдэл өгч, мотоциклын хулгайн гэмт хэрэг үйлддэг бүлэг этгээдүүдийг үйлдэл дээр нь илрүүлэн баривчилж ажилласнаар тээврийн хэрэгслийн хулгайн гэмт хэрэг 2-ыг илрүүлэн ажилласан. Мөн сумдын хэв журмын цагдаа нараас Илрүүлэлт-оргодол нэгдсэн арга хэмжээний хүрээнд Өндөр улаан сумын хэв журмын цагдаа, цагдаагийн дэд ахлагч, Зоригтбаатар нь Сэлэнгэ аймгийн цагдаагийн газраас эрэн сурвалжлагдаж байсан Сандрай овогтой Пүрэвдоржийг дайчлан баривчилж, Сэлэнгэ аймгийн цагдаагийн газарт хүлээлгэн өгч ажилласан. Энэ хугацаанд эргүүл хяналт шалгалтаар нийт 3654 аж ахуйн нэгж байгууллагын харуул манаа, 639 хүнийг шалгаж, хууль эрх зүйн зөвлөгөө өгч, 432 тээврийн хэрэгсэл шалгаж, 159 санамж, сэрэмжлүүлэг тараан өгч, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 307,5,2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж 10 илтгэх хуудас бичиж Эрүүгийн цагдаагийн тасагт шилжүүлэн шалгуулж байна.

Галт зэвсгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Хууль зүй дотоод хэргийн сайдын Галт зэвсгийн тооллого явуулах журам" А/220 дугаар тушаалыг тус тус үндэслэн "Зэвсэг-2017" нэгдсэн арга хэмжээ явуулах Цагдаагийн ерөнхий газрын даргын удирдамжийн хэрэгжүүлж төлөвлөгөө гарган тус газраас 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 12 дугаар сарын 07-ны өдөр хүртэлх хугацаанд дараах ажлыг зохион байгуулан ажиллаа. Цагдаагийн газрын даргын 2017 оны А/65 дугаартай тушаалаар ажлын хэсэг байгуулж "Зэвсэг-2017" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гарган, иргэн хуулийн этгээдийн өмчлөлд байгаа галт зэвсгийн тооллого явуулах, эрэн сурвалжлагдаж байгаа болон алдагдсан, нуугдмал галт зэвсгийг олж илрүүлэх чиглэлээр аймгийн 18 сумын хэсгийн төлөөлөгч, зохицуулагч, цагдаа болон цагдаагийн газрын нийт 71 алба хаагчийг хамруулан

Тус газарт 2017 оны 12 дугаар сарын байдлаар тооллогод хамрагдсан 1350, хамрагдаагүй 1233 нийт галт зэвсгийн 52,2 хувь нь тооллогод хамрагдсан үзүүлэлттэй байна. Үүнээс 2017 онд шинээр бүртгэгдсэн 181, бүртгэлээс хасагдсан 47, бусад аймгаас 2 галт зэвсэг шилжиж ирсэн байна. Аймгийн хэмжээнд санд бүртгэгдсэн нийт 2583 галт зэвсгийг зориулалтаар нь ангилахад энгийн харуул манааны зориулалттай 13, ан агнуурын зориулалттай 2548, спорт сургалтын зориулалттай 22 байна. Үүнээс 549 галт зэвсгийг зурагтжуулан баталгаажуулан галт зэвсгийн мэдээллийн санд оруулж ажилласан.

"Зэвсэг-2017" нэгдсэн арга хэмжээний явцад хэв загвар өөрчилсөн, ашиглах боломжгүй 138 галт зэвсгийг хураан авч мэдээллийн нэгдсэн санд хасалт хийсэн. Шинээр галт зэвсгийн гэрчилгээ авах хүсэлт гаргасан 181 иргэнийг галт зэвсгийн сургалтад хамруулахаар аймгийн Батлан хамгаалах нийгэмлэгтэй хамтран ажиллав.

"Зэвсэг-2017" нэгдсэн арга хэмжээний явц байдал, тооллогын мэдээг 7 хоногийн "Баасан гаригт" тогтсон цагт хавсралт хүснэгтийн дагуу гаргаж Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвд хүргүүлэн ажиллаа.

Мөн албаны галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл 62-ыг зурагжуулан баталгаажуулж галт зэвсгийн мэдээллийн санд оруулан ажиллан, Цагдаагийн газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн а/39 дүгээр тушаалаар дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан албаны галт зэвсэг, галт хэрэглэл, техник тусгай хэрэгсэлд үзлэг тооллого явуулж, үзлэгээр албаны галт зэвсэг, галт хэрэглэлээс эвдэрсэн ашиглах боломжгүй болсон замаг, гол төмрийн дугаар зөрсөн, эд анги дагалдах хэрэгсэл дутсан зөрчил дутагдал илрээгүй ба галт зэвсэг, галт хэрэглэл бүрэн бүтэн хадгалалт, хамгаалалт хэвийн байсан болно.

Цагдаагийн газраас Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дүгээр "Музейн үзмэр, иргэний болон харуул хамгаалалтын зориулалтаар ашиглах боломжгүй, хөнөөх чадваргүй болсныг цагдаагийн байгууллага тогтоож гэрчилгээ олгоно "гэсэн заалтыг хэрэгжүүлэн иргэдийн дунд хуулийн заалтыг тайлбарлан таниулах, хөнөөх чадваргүй болсныг тогтоож гэрчилгээ олгох шаардлагатай галт зэвсгийн илрүүлэх зорилгоор судалгаа явуулж байна. Энэ ажлын хүрээнд тус аймгийн Музейд үзмэр байдлаар хадгалагдаж байгаа 15 ширхэг цахир бууг судалгаа бүртгэлд авсан, иргэн аж ахуйн нэгжид байгаа иргэний болон харуул хамгаалалтын зориулалтаар ашиглах боломжгүй, хөнөөх чадваргүй болсон галт зэвсгийг илрүүлэх бүртгэл судалгаанд авч ажилласан.

Аймгийн Тагнуулын хэлтэс болон Онцгой байдал, Байгаль орчин, Мэргэжлийн хяналтын газруудтай хамтран "Бэрэн майнинг" ХХК-ний тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахад үзлэг шалгалт явуулж, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслүүдэд нэг бүрчлэн тулгалт хийхэд ямар нэгэн зөрүүтэй зүйл гараагүй.

2017 онд Архангай аймгийн нутаг дэвсгэрээр нийт 9 удаагийн тээвэрлэлтээр 55 тонн тэсэрч, дэлбэрэх бодис дамжин өнгөрсөн бөгөөд аюулгүй байдлыг хангах чиглэлээр тухайн тээврийн хэрэгслүүдийг аймгийн төвөөр дайран өнгөрөхөд хамгаалалтад аван хяналт тавьж аюулгүй байдлыг нь хангаж ажиллаж байна.

Эрдэнэбулган сумын 7-р багийн нутаг үйл ажиллагаа явуулдаг Бага рашаант ХХК-ны сүү эздүүлж уураг гаргаж авхаар авч ирсэн давсны хүчлийн хадгалалт хамгаалалтанд 2017 оны 07 сард хамтарсан шалгалт хийсэн. Уг шалгалтын ажлын хэсэгт хэсгийн байцаагч цагдаагийн ахмад Ж.Амгаланбаатар орж ажилласан. Шалгалтаар ямар нэгэн зөрчил тудагдал илрээгүй үйл ажиллагаагаа хуулийн дагуу явуулж байсан.

Шүүхийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Тус тасгийн шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажил хариуцсан ахлах байцаагч 1, хамгаалалтын цагдаа 2, харуулын цагдаа 4 нийт 7 алба хаагч ажиллаж байна.

2017 оны 12 сарын 15-ны байдлаар харуулын 4 цагдаа, 4 ээлжээр 349 удаа 8376 цагийн үүрэг гүйцэтгэж, шүүхийн байрны аюулгүй байдалд хяналт тавьж, зөрчил дутагдалгүй ажиллаа. Шүүгч, шүүгчийн туслах, шүүхийн ажилтнуудтай уулзахаар ирсэн 4153 хүнийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлж ажилласан байна.

Хамгаалалтын 2 цагдаа Эрүүгийн хэргийн 470, Иргэний хэргийн 442, Захиргааны хэргийн 141 шүүх хуралдаанд журам сахиулан зөрчил дутагдалгүй ажиллаж, шүүх хуралдаан дээр согтууруулах ундааны зүйл хэрэглэж ирсэн шүүгдэгч 5, хариуцагч 7, иргэдийн төлөөлөгч 1, гэрч 2 нийт 15 зөрчлийг илрүүлэн, тэмдэглэл үйлдэн хуралдаан эхлэх цагаас өмнө хуралдаан даргалагч, шүүгч нарт танилцуулан албадан саатуулж ажиллаа.

Архангай аймгийн сум дундын шүүхэд 1053 шүүх хуралдаан болж шүүх хуралдааны 1053 буюу 100% хувьд нь журам сахиулан 6318 оролцогчийн аюулгүй байдлыг хангаж ажиллаа. 18 цагаас хойш үргэлжилсэн шүүх хуралдаан 10, олон холбогдогчтой шүүх хуралдаанд хүч нэмэгдүүлсэн хамгаалалтыг 8 удаа хийж 64 алба хаагч 24 авто машинтай ажилласан байна.

Шүүгч, шүүхийн тамгын газрын гаргасан хүсэлтээр хөдөө орон нутагт ажлаар явахад нь 2 шүүгчийг, 18 цагаас хойш үргэлжилсэн шүүх хурал, онц хүнд гэмт хэргийн шүүх хурал, маргаан бүхий хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүгч нарыг 10 удаа гэрт нь хамгаалан хүргэхэд 26 алба хаагч давхардсан тоогоор ажилласан байна.

Цагдан хорих байрнаас шүүх хуралдаанд 241 шүүгдэгч, ялтныг шүүхээс хорих ялаар шийтгүүлсэн болон таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан 247 шүүгдэгч, ялтныг ШШГА-ны харьяа цагдан хорих байранд нийт 488 хүнийг хуяглан хүргэж хяналт тавьж ажиллаа.

Иргэний хэргийн хариуцагч эрэн сурвалжлах 12 захирамж хүлээн авч 7 хүний оршин сууж байгаа хаягийг тогтоон, 5 иргэний хариуцагчийг эрэн сурвалжилж байна.

Шүүхээс эрүүгийн болон иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдааны шүүгдэгч, хариуцагч, гэрч, хохирогчийг албадан ирүүлж, шүүх хуралдаанд оролцуулах тухай шүүгчийн 28 захирамж хүлээн авснаас эрүүгийн хэргийн шүүгдэгч 8, иргэний хэргийн хариуцагч 16, эрүүгийн хэргийн гэрч 4, шинжээч 1, хохирогч 2 нийт 28 захирамжийн 31 хүнийг албадан ирүүлж шүүгчийн туслахад хүлээлгэн өгч захирамж шийдвэрийн биелэлтийг 100% ханган ажиллаа.

Хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Хяналт шалгалт:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 09 сарын 29-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор батлагдсан “**School police**” эцэг эхийн эргүүл ажиллуулах журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ерөнхий боловсролын 5 сургуулийн 175 анги бүлгийн 30.000 гаруй эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч 45 бүлэг бөөгнөрөл бүхий 300 гаруй хүүхдийг тарааж, сурагчдыг замын хөдөлгөөнд зөв боловсон оролцуулах, зөв дадал хэвшил олгох ажлыг хэрэгжүүлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн явган зорчигч 110 хүнд анхааруулга өгч, зөрчил гаргасан 13 тээврийн хэрэгслийн талаарх мэдээллийг тус газрын замын цагдаагийн тасагт мэдээлж ажилласнаар сургуулийн орчинд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил гараагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 410 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”, Архангай аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн “Интернет кафе, цахим тоглоомын газар ажиллуулах журам, “Харилцаа холбооны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрдэнэбулган сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, сургуулийн нийгмийн ажилтнуудтай хамтран “Цахим тоглоом” хэсэгчилсэн арга хэмжээг 3 удаа, хяналт шалгалтыг 5 удаа зохион байгуулж, 28 аж ахуйн нэгж байгууллагаар орж, 200 оюутан сурагчид зааварчилга зөвлөгөө өгсөн.

Мөн Их дээд, ерөнхий боловсролын сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн багш сурган хүмүүжүүлэгч нар Оюутан, сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, зам тээврийн осол гэмтэл, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаалах, багш сурган хүмүүжүүлэгч нарын сурагчдад тавих хяналтыг сайжруулж, хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор 2017-2018 оны хичээлийн жилд өдөр бүр хуваарийн дагуу 20.00-00.00 цагийн хооронд явган эргүүлийн үүргийг гүйцэтгэж эхлээд байна.

Нэгдсэн, тусгай, хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд:

Тус цагдаагийн газраас 2017 онд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Судалгаа”, “Зуслан”, “Хүүхэд хамгаалал” “Төгсөлт” “Хонх”, “Шинэ жил” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг удирдамж төлөвлөгөөний дагуу зохион байгуулж хариуцлагатай эргүүлд 285 гаруй багш сурган хүмүүжүүлэгчийг хамруулж, МСҮТөв, их дээд, ерөнхий боловсролын 25 сургуулийн давхардсан тоогоор 4580 гаруй оюутан, сурагч, 72 эцэг эх, асран хамгаалагчид урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, төгсөх ангийн 900 гаруй сурагчдад хууль эрх зүйн зөвлөгөө өгч, 300 гарын авлага, санамж, сэрэмжлүүлэг, албан мэдэгдлийг тараан, гэмт хэрэг зөрчил үйлдэж болзошгүй 4 хүүхэд, захиргааны хяналтад байгаа 3 хүүхдийн судалгааг гаргаж харьяа хамтарсан багийн гишүүдэд хариуцуулан өгч, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлж ажиллажээ.

Мөн арга хэмжээнүүдийн хүрээнд Архангай аймгийн 19 сумын “Хамтарсан баг”-тай хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүчирхийлэл үйлддэг болон хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй иргэдийг илрүүлж бүртгэл судалгаанд авч хяналт тогтоох, хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор 2017 оны 2, 9 дүгээр сард 2 удаа зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг болон үйлдэх эрсдэлтэй 75 иргэнийг илрүүлж, хяналт тавин ажиллаж байна.

Хэлэлцүүлэг:

Үе тэнгийнхний дарамт шахалт, өсвөр үеийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өртөж хохирохоос хамгаалах эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх “**Бариа**” сургалт хэлэлцүүлэг, “Үе тэнгийнхний дарамт байх ёсгүй” урианы дор “**Нар хүүхэд бүхэнд адилхан тусдаг**” сэдэвт аймгийн хүүхдийн 4 дүгээр чуулган зэргийг зохион байгуулж 19 сумын Засаг дарга, 6 сургуулийн 376 боловсролын нийгмийн ажилтан, багш, эцэг эхийн төлөөлөл, 1200 гаруй сурагчдыг хамруулав. Тус арга хэмжээний үед цагдаагийн газрын дарга “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, үе тэнгийнхний дарамт хүчирхийлэл түүнийг таслан зогсооход хүүхдийн оролцоо” сэдвээр илтгэл тавьж, ГБХ,ХГХУСАхлах мэргэжилтэн, хэсгийн байцаагч нар “Үе тэнгийнхэн буюу найз нөхдийн дунд хүүхэд хамгаалал” сэдвээр сургалт, хэлэлцүүлгийг хүүхдийн “Тамир” зуслан дээр зохион байгууллаа.

Зөвлөгөөн:

Мөн аймгийн ЗДТГ, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсрол соёл урлагийн газар, Эрдэнэбулган сумын ЗДТГ, ДЗМОУБ Архангай-1 ОНХХ байгууллагуудтай хамтран “**Эцэг эхийн зөвлөгөөн**”, “**ЕБС-н багш, менежерүүдийн чадавхжуулах**” зөвлөгөөн зэргийг зохион байгуулж, Ерөнхий боловсролын 19 сургууль, 13 цэцэрлэг, эцэг эхийн төлөөлөл, сургуулийн захирал, нийгмийн ажилтан, цэцэрлэгийн эрхлэгч арга зүйч нарын нийт 300 оролцогч хамруулж харилцан мэдээлэл солилцон ажиллажээ.

Өдөрлөг:

Японы хүүхдийг ивээх сантай хамтран 2017оны 04 дүгээр сарын 30-нд “**Хүүхдийг зодож шийтгэхгүй байх**” Дэлхий нийтийн өдрийн тохиолдуулан нээлттэй хаалганы өдөрлөг, “Флом” олон улсын байгууллагатай хамтран Олон улсын “**Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр**”-ийг тохиолдуулан “**Хүчирхийллийн эсрэг тэрбумаараа нэгдэцгээе**” өдөрлөгийг зохион байгуулж арга хэмжээг хүчирхийлэлгүй аймаг болох “Хүчирхийллийн эсрэг тэрбумаараа нэгдэцгээе” уриалга дэвшүүлж, алба хаагч нар “Флашмоб” бүжгийг бүжиглэж, хүчирхийллийн эсрэг уриалга аннос, хүчирхийллийн эсрэг үгнүүд барин жагсаж, “Миний хайртай” гэр бүл сэдэвт зургийг 120 гэр бүлээр зуруулж, фото зургийг авч өгч дурсган, захиргааны хяналтад байдаг, ял хойшлогдсон, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад шалгагдаж байгаа 7 хүүхдэд баярын бэлэг өгөх ажлыг зохион байгуулж ажиллав.

Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран 2017 оны 05 дугаар асрын 26-нд “**Хуулийн байгууллагуудын нээлттэй хаалга**”-ны өдөрлөгөөр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд шинээр орсон өөрчлөлтүүд, “school police” эцэг эхийн эргүүл“-ийн үйл ажиллагааг танилцуулах самбарыг шинээр хийж, Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар гарын авлага, санамж, сэрэмжлүүлгийг шинэчлэн гаргаж, 200 гаруй тарааж өгөх материалыг иргэд олон нийтэд тараан өгч 10 иргэнд эрх зүйн туслалцаа үзүүлж ажиллаа.

Эрүүл мэндийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Ерөнхий боловсролын сургууль, “Флом” олон улсын байгууллагатай хамтран 2017 оны 10 дугаар сарын 03-11-нд Олон улсын охидын өдрийг тохиолдуулан “**Охид юу хүсдэг вэ?**” эсээ бичлэгийн уралдаан, өдөрлөгүүдийг зохион байгуулж охидын эрхийн тухай болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өртөж хохирохоос хамгаалах, охидын эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх сургалтууд хийж, ерөнхий боловсролын сургуулиудаас 50 хүүхдийн төлөөлөл нийт 300 охин оролцон, аймгийн тамгын газрын дарга нээж үг хэлж, урлагийн үзүүлбэрүүд боллоо.

Оролцогч 300 охинд хос ягаан өнгийн үсний зүүлт, гарын авлага тараан өгч, асуулт

хариултын “АХА” тэмцээнийг зохион байгуулж, эсээ бичлэгийн уралдаанд тэргүүн байр эзэлсэн хүүхдүүдийг шагнаж урамшуулан, охидын эрхийг хамгаалах өдөрт зориулсан байгууллагуудын мэдээлэл санамж, сэрэмжлүүлэг 28 төрлийн 1300 ширхгийг тараан өглөө.

Тэмцээн:

Эрдэнэбулган сумын 4-р багийн “Хамтарсан баг”, Эрдэнэбулган сумын ГХУСАЗСЗөвлөл, Японы хүүхдийг ивээх сантай хамтран Өсвөр үе хүүхэд багачуудыг замын хөдөлгөөнд зөв боловсон оролцуулж хэвшүүлэх, зөв дадал хэвшил олгох, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, өртөж хохирохоос хамгаалах зорилгоор “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээн, “Хүчирхийллийн эсрэг хамтдаа” асуулт, хариултын “АХА” тэмцээн, Хүүхдийг зодож шийтгэхгүй байх дэлхий нийтийн өдрийг тохиолдуулан “Хүүхэд хамгаалал”, “Хүүхдийн эрх”, “Гэр бүлийн хүчирхийлэл”, цахим гэмт хэрэг, үе тэнгийнхний дарамт шахалт, интернет хэвлэл мэдээллийн сөрөг нөлөөлөл, хор уршгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Центавр” тэмцээн, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөл, авто жолооны курсүүдтэй хамтран Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Ногоон гэрэл, цагаан шугам” зэрэг тэмцээнийг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 6 баг, 6 сургуулийн 144 гаруй багш, эцэг эхийн төлөөлөл, 149 сурагч, 12 цэцэрлэгийн 144 хүүхэд хурд хүч, авхаалж самбаагаар өрсөлдөж 1-3 дугаар байр шалгаруулан өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан байна.

Мөн Цагдаагийн газрын дарга, Эрдэнэбулган сумын ГХУСАЗСЗөвлөлийн дарга, БСУСГазрын даргаар батлуулан, оюутан сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, зам тээврийн осол гэмтэл, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаалах, багш сурган хүмүүжүүлэгч нарын сурагчдад тавих хяналтыг сайжруулж, хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор 2017-2018 оны хичээлийн жилд 20.00-00 цагийн хооронд **явган эргүүлийн үүргийг гүйцэтгүүлж байгаа**, “Өсвөрийн сэргийлэгч”, “Оюутан цагдаа” **бүлгэмийг** шинээр байгуулан, гишүүдийг чадавхжуулах 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, Эрдэнэбулган сумын их дээд ерөнхий боловсролын сургуулийн 9 сургуулийн 160 гаруй оюутан, сурагчид хоёр өдрийн чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан зэрэг ажлуудыг шинээр санаачлан зохион байгуулж ажилласан.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Цагдаагийн газрын алба хаагчдыг чадавхжуулах”, “Эерэг хандлага-эрүүл оюутан” аяны хүрээнд “Оюутан сургагчдын гэр бүлийн хөгжил, төлөвшилт”, “Архины хэрэглээ ба залуу нас”, “Бие даасан хөгжил”, “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх нь”, “Хүчирхийллийн хохирогч, эрсдэлт нөхцөлд байгаа эмэгтэйчүүдэд анхаарах асуудал” зэрэг сургалтыг давхардсан тоогоор 101 цагдаагийн алба хаагч, 509 оюутан сурагч, 19 сумын 60 багш, сурган хүмүүжүүлэгч, 74 архины хамааралтай иргэн, 154 гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэй, 108 төрийн алба хаагч, 1400 орчим иргэдийг хамруулж, 8 төрлийн 100 гаруй гарын авлага, санамж, сэрэмжлүүлэг тараан хамтарсан багийн гишүүд болох ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудад бага дунд ангийн сурагчдыг заавал эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч байх талаар үүрэг чиглэл өгч гарын үсэг зуруулж баталгаа авч ажиллаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор “Судалгаа”, “Илрүүлэлт” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг удирдамж төлөвлөгөөний дагуу зохион байгуулж 19 сумын “Хамтарсан баг”-тай хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүчирхийлэл үйлддэг болон хүчирхийлэл үйлдэх эрсдэлтэй иргэдийг илрүүлж бүртгэл судалгаанд авч хяналт тогтоох, хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор 2017 оны 2, 9 дүгээр сард 2 удаа зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг болон үйлдэх эрсдэлтэй 75 иргэнийг илрүүлж, хяналт тавин ажиллажээ.

Гурав: Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа. соён гэгээрүүлэх болон авлигаас урьдчилан сэргийлэх ажлын талаар

-Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ; түүний үр дүн

Цагдаагийн газрын удирдлагаас албадын үйл ажиллагааг сайжруулж, оршиж буй алдаа дутагдлыг засч арилгах, орон нутгийн цагдаагийн тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажлын хариуцлага сахилгыг дээшлүүлэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, болзошгүй хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 32 “Үүрэг, зааварчилгаа, зөвлөмж, ажлын чиглэл”-ийг бичиж, биелэлт үр дүнг нь тооцов.

Монгол улсын засгийн газрын 2017 оны “сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, Цагдаагийн ерөнхий газрын даргын “Сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай” 01 дугаар албан даалгавар зэргийг хэрэгжүүлэх ажлын салбар төлөвлөгөө гарган тасаг, албадын дарга нарт хүргүүлэн биелэлт үр дүнг тооцож хугацаанд нь тайлагнав.

Цагдаагийн газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн б/61 дугаар тушаалаар “Сахилга ёс зүйн алба”-ыг 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан сахилга ёс зүйн албаны ажиллах журмыг боловсруулан ЦГ-ын даргын зөвлөлийн хурлаар баталж журмын дагуу тус албаар 2017 онд 41 алба хаагчийн цаг ашиглалт, өглөөний шуурхай, албаны бэлэн байдлыг бүртгэлээр гаргасан зөрчлийг хэлэлцэн сарын ажлын үр дүнгээр 5-20 хувь 18 алба хаагчийг хасаж, 12 алба хаагчийг амралтын цагаар эргүүлд ажиллуулж, 9 алба хаагчид сануулан 2 алба хаагчийг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр тус тус хариуцлага тооцож, алба хаагч бүрээс баталгаа гаргуулан авлаа.

Энэ онд алба хаагчдын албаны бэлэн байдлыг хангах, цагдаагийн алба хаагчдын дүрэмт хувцас хэрэглэх журмын хэрэгжилтийг шалгах Ц-111 тохиогоор 13 удаа түргэн цугларалтыг шалган 14 удаа дүрэмт хувцсанд жагсаалын үзлэг зохион байгууллаа.

Цагдаагийн газрын 2017 онд 3 удаа сахилга хариуцлага, ажлын үр дүнг дээшлүүлэх зөвлөгөөнийг зохион байгуулж сахилга ёс зүйн зөрчил гаргахгүй хамт олноо хошуучлан ажилласан 1 тасгийн дарга, 5 алба хаагчид “Талархал”, хамт олноо хангалтгүй удирдан зохион байгуулсан 1 тасгийн даргад, 1 алба хаагчид “Албан мэдэгдэл”, сахилга ёс зүйг дээшлүүлэх шаардлагатай 5 алба хаагчид “Шаардлага” хүргүүлж 5 удаа “Баталгаа” авч цагдаагийн газраас “Нэг гэр бүл”, “Архи, авлига, хүнд сурталгүй хамт олон болох” уриалгыг дэвшүүлж ажиллажээ.

Хоёрдугаар улирлын сахилгын зөвлөгөөний Булган ууланд явган аялал хийж, шинэлэг байдлаар мэтгэлцээн хийх зарчмаар зохион байгуулав. Мэтгэлцээнийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хэсгийн төлөөлөгч нарыг хоёр багт хуваан 1 дүгээр баг “Прокурор”-ын байгууллагаас шүүмжлэл хийх, 2 дугаар баг “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч”-ын алба хаагчдаас няцаалт хийх хэлбэрээр, мөн замын цагдаагийн байцаагч, хэв журмын байцаагч, цагдаа нарыг хоёр багт хуваарилан 3 дугаар баг “Иргэн”-ээс шүүмжлэл хийх, 4 дүгээр баг “Цагдаагийн алба хаагч” –аас няцаалт хийх хэлбэрээр зохион байгуулж, мэтгэлцээнд алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд болон ажил үүргээ гүйцэтгэх явцдаа гаргадаг зөрчлийг олон талаас нь энгийн байдлаар ойлголт өгөхөөр зохион байгуулсан нь үр дүнтэй арга хэмжээ болсон гэж дүгнэж байна. Цагдаагийн газраас зохион байгуулсан зөвлөгөөн бүрээс “Зөвлөмж” гарган дараа улирлын сахилгын зөвлөгөөнөөр үр дүнг тооцож ажиллав.

Мөн цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан хориглолтыг зөрчихгүй байх талаар нийт алба хаагчдаас баталгаа гаргуулан авснаас гадна дээд байгууллагаас ирсэн албан бичгийн хүрээнд тухай бүр баталгаа бичүүлэн авч, хэрэгжилтийг хянаж үр дүнг тооцлоо.

Алба хаагчдын сахилга ёс зүйн зөрчилд дүгнэлт хийж тэдний ажлын ачаалал, албандаа хандах хандлага, ар гэрийн нөхцөл байдал, сэтгэл зүйн онцлог, ажлын стресс тайлах, сэтгэл зүйн орчинд нөлөөлөх сорил, дасгалуудыг хийж Флом олон улсын байгууллагын мэргэжлийн сэтгэл зүйчийг 2 удаа, нэгдсэн эмнэлгийн сэтгэл судлаачийг 1 удаа, лектор, илтгэгч, докторыг 4 удаа нийт 7 удаа бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулжээ.

Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргын 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Алба хаагчийг ёс зүйн төлбөртэй сургалтад хамруулах тухай” 23 дугаар тушаалын дагуу 9 алба хаагчийг “Ёс суртахуун төлөвшил” сэдэвт сургалтад хамрууллаа.

Мөн соён гэгээрүүлэх ажлын хүрээнд цагдаагийн алба хаагчдын гэр бүлийн гишүүдтэй уулзах уулзалтыг 2 удаа, хамтарсан урлаг, спортын тэмцээн уралдааныг 3 удаа зохион байгуулснаас гадна Цагдаагийн байгууллагын өнгө төрхийг гадаад дотоодод илэрхийлэх, албаны нэр хүндийг бэхжүүлэх, урлаг соёлын болон соён гэгээрүүлэх олон талт ажлаар дамжуулан алба хаагчдын соёл, гоо зүйн мэдрэмж, сэтгэлгээг хөгжүүлэх, ажлын стрессийг тайлах, хууль сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2017 оны 07 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд Цагдаагийн ерөнхий газрын Сүлд чуулгын хамт олныг бүрэн бүрэлдэхүүнээр нь урьж хамтран ажилласан. Тус арга хэмжээний үед “Тантай үргэлж хамт” арга хэмжээ болон “цагдаагийн албаны тухай хуулийг хэн сайн мэдэх вэ” тэмцээн, алба хаагчдын дунд “Хайрын үдэш” зэрэг олон арга хэмжээг зохион байгуулснаас гадна Цахир, Ихтамир, Эрдэнэбулган суманд урлагийн тоглолтыг иргэд, алба хаагчдад үзүүлсэн нь үр дүнтэй ажил болсон юм.

Цагдаагийн газар нь алба хаагчдын цаг ашиглалтыг тооцох, хяналт тавих зорилгоор гарын хээний цагийн бүртгэл ZKТесо I clock 360 төхөөрөмжийг байршуулан алба хаагчдын цагийг өдөрт 4 удаа бүртгэж хэвшээд байна.

Сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж Цагдаагийн газрын батлагдсан оронд багтаан “Сэтгэл зүйч”-ийн орон тоог батлуулах тухай танилцуулгыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, албадад хүргүүлж орон тоог шийдвэрлүүлсэн.

-Сахилга, ёс зүйн зөрчлийн мэдээ, прокурор, шүүхийн мэдэгдэл, шаардлага; /өсөлт, бууралт тоо хувиар/

Цагдаагийн газрын удирдлага, алба хаагчдын талаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл, дотоодын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил бүрийг бүртгэн авч албаны шалгалт явуулан шалтгаан нөхцлийг тогтоож буруутай этгээдэд хариуцлага тооцох, буруугүй болох нь тогтоогдсон алба хаагчийн талаар гомдол мэдээлэл гаргагчид хариу мэдэгдэж байгууллагын болон алба хаагчийн нэр төрийг сэргээхэд анхаарч ажиллав.

Тус цагдаагийн газрын алба хаагчдаас 2017 оны 12 сарын байдлаар Эрүүгийн 3 гэмт хэрэгт 3 алба хаагч холбогдон шалгагдсан нь урьд оны мөн үеэс 3 нэгжээр буюу 100 хувиар өссөн.

Алба хаагчдын сахилгын зөрчлийг тоон үзүүлэлтээр авч үзвэл: Энэ онд сахилга ёс зүйн 28 зөрчилд 28 алба хаагч холбогдсоноос офицер 20, ахлагч 8 байна. Урьд оны мөн үед 29, энэ онд 28 алба хаагч сахилгын зөрчил гаргасан нь 1 нэгжээр буюу 3,4 хувиар буурсан байна.

Сахилга ёс зүйн зөрчлийн хэлбэрийг авч үзвэл: Цагдаагийн харилцааны соёл, ёс зүйг зөрчсөн урьд онд 3, энэ онд 2 буюу 33.3 хувиар буурсан, ажлын хариуцлага алдсан зөрчил урьд онд 4, энэ онд 3 буюу 25 хувиар буурсан, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль дүрэм зөрчсөн урьд онд 8, энэ онд 6 буюу 25 хувиар, ЦАХ-чийн ёс зүйн дүрмийг зөрчсөн урьд онд 3, энэ онд бүргэгдээгүй буюу 100 хувь буурсан, архидан согтуурсан зөрчил урьд онд 1, энэ онд 5 буюу 80 хувиар өссөн, үүрэг даалгавар үл биелүүлсэн урьд онд бүргэгдээгүй, энэ онд 2 буюу 100 хувь өссөн, бусад зөрчил урьд оны мөн үеэс 1 буюу өссөн үзүүлэлттэй байна.

Сахилга ёс зүйн зөрчлийн илрүүлэлт тухайн байгууллагын дотоод хяналтаар урьд онд 6, энэ онд 10 буюу 40 хувиар өссөн, ёс журмын хяналтаар урьд онд 4, энэ онд 5 буюу 20 хувиар, гадны хяналтаар урьд онд 9, энэ онд 8 буюу 11,1 хувиар буурсан тус тус үзүүлэлттэй байна.

2-рт Тус цагдаагийн газрын хүлээн авсан прокурорын шаардлага урьд оны мөн үетэй харьцуулахад 2016 онд давхардсан тоогоор 54 алба хаагчид холбогдох 144 зөрчилд 11 шаардлага, 2017 онд давхардсан тоогоор 26 алба хаагчид холбогдох 64 зөрчилд 7 шаардлага хүлээн авсан ба алба хаагчдаас гаргасан зөрчил 80 буюу 55.5 хувиар буурсан байна.

-Алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр дотооддоо зохион байгуулсан сургалт; /ашигласан техник хэрэгсэл/

Тус цагдаагийн газраас 2017 онд алба хаагчдын дунд явуулах албаны сургалтыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын, сургалтын бодлого боловсруулж хэрэгжүүлэх /код-118/ журам, "Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2017 оны сургалтын төлөвлөгөө", "Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2017 онд цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх ажлын дэд төлөвлөгөө" зэрэг эрхийн актуудын зорилго, агуулгын талаар бие бүрэлдэхүүнд танилцуулж, суралцах идэвх санаачилгыг өрнүүлэх зорилгоор тэднээс цагдаагийн газраас явуулж байгаа албаны сургалтын талаарх санал, гадаад хэл, компьютерийн мэдлэгийн түвшин, оффис-ын техник хэрэгсэл хэрэглэх, чадвар, цаашид мэдлэг боловсролоо дээшлүүлэхээр бакалавр, магистр, удирдлагын академид суралцах хүсэл сонирхлын талаар санал асуулга авч дүнг нэгтгэн албаны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.

Цагдаагийн газрын 2017 оны нэгдсэн сургалтын төлөвлөгөөний дагуу 7 хоногийн Пүрэв гарагт нийт бие бүрэлдэхүүнд, Мягмар гариг бүр тасаг, хэсгийн алба хаагчдад дотооддоо хичээл сургалтыг тогтмол зохион байгуулж ажиллаж байна.

Сургалтын төлөвлөгөөний дагуу Монгол улсын хууль, шинэчлэн баталсан найруулгууд, Монгол Улсын Засгийн газар, Цагдаагийн ерөнхий газраас баталсан дүрэм, журам, цагдаагийн газрын дотоод журам, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмуудаар алба хаагчдын мэдвэл зохих хууль тогтоомжийг мэдлэг олгох чиглэлээр тасгийн дарга, ахлах албан тушаалтнууд хичээлийн конспект бэлтгэн лекц 9 цаг, ярилцлага, хэлэлцүүлэг 23 цаг нийт 32 цаг, алба хаагчийг хөгжүүлэх чиглэлээр Гэр бүлийн бахархал ТББ-ын тэргүүн, Англи, Хятад, Герман хэлний багш, лектор Н.Аюурзана, ХААН банк харилцааны албаны сургагч багш Н.Цэцэгмаа, REMA төвөөс лектор А.Батхшиг, Флом олон улсын байгууллагын сэтгэл зүйч Т.Сувдаа, Оюуны олимпын аварга, үндэсний шилдэг илтгэгч, лектор А.Отгонбаатар нарын лектор, илтгэгчдийг урьж "Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл" "Хувь хүний хөгжил", "Алба хаагчдын ажлын төлөвлөлт, хувь хүний зохион байгуулалт", "Ёс зүйн төлөвшил", "Ажлын стресс, сэтгэл зүйн онцлог", "Хайрлая, хамгаалъя" зэрэг сэдвээр лекц 8 цаг, компьютер программ, англи хэлний дадлага, сургуулилт 48 цаг, ярилцлага, хэлэлцүүлэх 24 цаг, бие даалт 16 цаг нийт 96 цаг, мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах чиглэлээр сахилгын зөвлөгөөн 3 удаа, хууль хяналтын байгууллагын хамтарсан зөвлөгөөн 6 удаа, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын нэгдсэн цугларалт 12 удаа, "Шилдэг хэрэг бүртгэгч 2017", "Шилдэг хэсгийн төлөөлөгч 2017", "Шилдэг цагдаа 2017" зэргийг зохион байгуулж практик дадлага нийт 24 цаг, алба хаагчдын алдаан дээрээс суралцах сургалтын чиглэлээр "Прокурорын шаардлага", "Алба хаагчдын харилцааны соёл", "Архигүй хамт олон болцгооё",

“Сахилга хариуцлагыг дээшлүүлэе”, “Захиргааны хяналтын материал дээр гаргаж байгаа алдаа дутагдал” зэрэг сургалтыг нийт 24 цаг, алба хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх чиглэлээр спорт хамтлагын ахлагч, гишүүдээс лекц 4 цаг, цагдаагийн газрын “Бялдаржуулах танхим”, Пүрэв гариг бүрийн 19-21 цагийн спорт заал зэрэг 44 цаг нийт 48 цагийн албаны сургалтыг тус тус зохион байгуулжээ.

Энэ хугацаанд нийт батлагдсан орон тоогоор 133, давхардсан тоогоор 3860 алба хаагч лекц 21 цаг, ярилцлага, хэлэлцүүлэг 71 цаг, дадлага, сургуулилт 116 цаг, бие даалт 16 цаг нийт 224 цагийн сургалтад хамруулжээ.

Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэс, Сургалтын төвөөс өгсөн чиглэлийн дагуу алба хаагчдын эрхэлж байгаа албан тушаалын чиглэл, ажлын туршлага, ур чадвар, ажилласан жил, мэдлэгийн түвцлнийг урьдчилан шалгасны үндсэн дээр сургалтын сэдэв, арга хэлбэр, цагийг сонгож Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 6/58 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2017 оны сургалтын календарчилсан төлөвлөгөө”-ний дагуу тухай удирдамжид заагдсан сэдэв, хариуцсан чиглэлийн дагуу Цагдаагийн ерөнхий газар болон Сургалтын нэгдсэн төвд 2017 онд цагдаагийн газрын дарга болон тасгийн дарга 6, ахлах албан тушаалтан 9, офицер 18, ахлагч 14 нийт 47 алба хаагчийг хамруулсан байна.

Мөн шинэчлэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаарх мэдээлэл олгох, сургалтын арга зүйг эзэмшүүлэн ажиллаж буй нэгжийнхээ алба хаагчдад, нутаг дэвсгэрийн иргэд, нутгийн төрийн захиргааны байгууллага, ажилтан алба хаагчдад сурталчлах ажлыг хийж гүйцэтгэх “Сургагч багш”-ийг бэлтгэх сургалтад Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Анхбаатар, Олон нийттэй харилцах ажил хариуцах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Б.Наранчимэг нар 2 өдөр 14 цагийн сургалт, “Цагдаагийн сургагч ахлах бэлтгэх” сургалтад хэв журмын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Г.Насантогтох, “Цагдаа таны төлөө” ахлагч бүрэлдэхүүний сургалт зөвлөгөөнд тус цагдаагийн газраас 5 алба хаагч, Цагдаагийн ерөнхий газрын төв архивын газарт 2017 оны 03 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд “Архив, албан хэрэг хөтлөлт” сэдэвт 1,5 кредит, “Статистикийн анхан шатны мэдлэг олгох” 5 хоногийн сургалтад Захиргааны зөрчлийн тоо бүртгэгч, архивч цагдаагийн ахлах ахлагч О.Алимаа, Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын нэгдсэн төвд “Албаны нохой сургагч”-ийн 6 сарын сургалтад туслах төлөөлөгч, дэд ахлагч Б.Болд-Эрдэнэ нар тус тус хамрагджээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогтын ОХУ-д хийсэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд “ОХУ-ын ДХЯ-ны харьяа боловсролын байгууллагуудад тодорхой тооны алба хаагчийг богино хугацааны сургалтад оролцуулах ажлыг зохион байгуулах” ажлын хүрээнд ОХУ-ын Краснодарын Их сургуульд “Терроризм болон бусад хүч хэрэглэсэн экстремизмын илрэлүүдтэй тэмцэх орчин үеийн арга хэлбэрүүд” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Т.Ганзоригийг хамруулж сургалтын зардал болох 1700000 төгрөг, Хүний нөөцийн мэргэжилтэн цагдаагийн дэслэгч Д.Бадамгаравыг Архангай аймаг дахь Англи хэлний дунд шатны 2 сарын сургалтад хамруулж 200000 төгрөгийг аймгийн орон нутгийн санхүүжилтээр шийдвэрлэсэн байна.

Цагдаагийн байгууллагын өнгө төрхийг гадаад дотоодод илэрхийлэх, албаны нэр хүндийг бэхжүүлэх, урлаг соёлын болон соён гэгээрүүлэх олон талт ажлаар дамжуулан алба хаагчдын соёл, гоо зүйн мэдрэмж, сэтгэлгээг хөгжүүлэх, ажлын стрессийг тайлах, хууль сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2017 оны 07 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд Цагдаагийн ерөнхий газрын Сүлд чуулгын хамт олныг бүрэн бүрэлдэхүүнээр нь урьж хамтран ажилласан. Тус арга хэмжээний үед “Тантай үргэлж хамт” арга хэмжээ болон “цагдаагийн албаны тухай хуулийг хэн сайн мэдэх вэ” тэмцээн, алба хаагчдын дунд “Хайрын үдэш” зэрэг олон арга хэмжээг зохион байгуулснаас гадна Цахир, Ихтамир, Эрдэнэбулган суманд урлагийн тоглолтыг иргэд, алба хаагчдад үзүүлсэн нь үр дүнтэй ажил болсон юм.

Цагдаагийн газраас Хууль сахиулах их сургуулийн докторантын сургалтад 1, эчнээ 3,5 жилийн ангид 2, эчнээ 5 жилийн эчнээ 4, цагдаагийн офицер дамжаанд 1 алба хаагч хамрагдсан. Цагдаагийн газарт 3 ахлагч, 1 офицер шинээр томилогдсон ба Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөрийн дагуу цагдаагийн газрын даргын тушаалаар халамжлан хүмүүжүүлэгч, дадлагажуулагч багш 4 алба хаагчийг томилж хөтөлбөрийн дагуу 10 зөвлөмж, зааварчлагыг өгч сургалт зохион байгууллаа.

Зохион байгуулсан сургалтуудын үр дүнг тооцож тайлангийн хугацаанд 6 удаа 30-40 асуулт бүхий тестийн шалгалт авч, шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн а/129 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн

ёс зүйн дүрэм”-ийг алба хаагчдын дунд асуулт, хариултын “АХА” тэмцээнийг зохион байгууллаа.

Цагдаагийн газрын батлагдсан орон тоогоор 133 алба хаагчид цагдаагийн албаны тухай хуулийн чиглэлээр 46 удаа давхардсан тоогоор 6118 алба хаагчид, Эрүү, Зөрчлийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн чиглэлээр 24 удаа 3192 алба хаагчид, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн чиглэлээр 23 удаа 2029 алба хаагчид, бусад хууль тогтоомжийн чиглэлээр 33 удаа 4389 алба хаагчид нийт 148 удаа 18654 алба хаагчдад сургалт зохион байгуулжээ. Мөн давтан сургалтад 47 удаа 47 алба хаагч, мэргэшүүлэх сургалтад 22 удаа 23 алба хаагч, ур чадварын сургалтад 23 удаа 23 алба хаагч, 22 алба хаагч 10-20, 1 алба хаагч 21-40 багц цаг хамрагдаж 1800000 төгрөг зарцуулжээ.

-Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулагдсан сургалт уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнд алба хаагчдыг хамруулсан байдал;

Цагдаагийн газраас 2017 оны 02 дугаар сард Өвөрхангай аймгийн Хархорин суманд зохион байгуулагдсан хангайн бүсийн Цагдаагийн газруудын дунд зохион байгуулагдсан “Аймгийн хэмжээнд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажил, нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх ажил”, “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөгөөнд 32 алба хаагч, 09 дүгээр сард зохион байгуулсан “Хангайн бүсийн хэсгийн төлөөлөгч нарын бүсчилсэн сургалт”-нд 29 алба хаагч, “Цагдаагийн байгууллагын аж ахуйн ажилтан, нягтлан, нярав нарын ажлыг чадавхжуулах” сургалтад 2 алба хаагч, Архангай аймагт үе тэнгийнхний дарамт шахалт, өсвөр үеийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өртөж хохирохоос хамгаалах эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх “Бариа” сургалт хэлэлцүүлэг, “Үе тэнгийнхний дарамт байх ёсгүй” урианы дор “Нар хүүхэд бүхэнд адилхан тусдаг” сэдэвт аймгийн хүүхдийн 4 дүгээр чуулганд 8 алба хаагч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас “Хорихоос өөр төрлийн ял болон тэнсэн харгалзах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн ялын хэрэгжилтийн талаар” зөвлөгөөнд 22 алба хаагч, “Эцэг эхийн зөвлөгөөн”, “ЕБС-н багш, менежерүүдийн чадавхжуулах” зөвлөгөөн, аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Хөрөнгө орлогын мэдүүлэг авах эрх бүхий алба хаагчдын чадавхжуулах” сургалтад 2 алба хаагч, “Байгууллагын хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах” сургалтад 1 алба хаагч, “Жендерийн эрх тэгш байдлыг хангах” сургалтад 2 алба хаагч, аймгийн Залуучуудын холбоо, Үнэн сэтгэлтэй, зөв бодолтой эмэгтэйчүүдийн бүлэг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, Архангай сайхан бүсгүй групптэй хамтран “Эмэгтэйчүүдийн оролцоо” сэдвийн хүрээнд сургалт, хэлэлцүүлэгт 6 алба хаагч нийт хэлэлцүүлэг, зөвлөгөөнд давхардсан тоогоор 104 алба хаагч хамрагдсан байна.

Цагдаагийн газраас 2017 онд зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, өдөрлөгийн үеэр аймгийн ГХУСАЗСЗ, Эрдэнэбулган сумын ГХУСАЗСЗ, Эрүүл мэндийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, “Булганхангай төрийн бус байгууллага”, “Флом”, “Дэлхийн зөн Архангай -1”, “Дэлхийн зөн Архангай -2”, олон улсын байгууллагатай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа 121, уулзалт, хэлэлцүүлэг ярилцлага 24, өдөрлөг 10, уралдаан, тэмцээн 9, нийт 164 удаа 12209 иргэнийг оролцуулаа.

Флом олон улсын байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр цагдаагийн газрын алба хаагчдыг чадавхжуулах 2 өдрийн сургалтад 1.640.000 төгрөг, 2017 оны 6 дугаар сарын 1-ны өдөр зохион байгуулсан “Хүчирхийллийн эсрэг тэрбумаараа нэгдье” арга хэмжээнд 300.000 төгрөг, Олон улсын охидын эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулсан өдөрлөгийн арга хэмжээнд 1.000.000 төгрөг, Японы хүүхдийг ивээх сангаас Хүчирхийллийн эсрэг хамтдаа асуулт хариултын “АХА” тэмцээн, Хүүхдийг зодож шийтгэхгүй байх дэлхий нийтийн өдрийг тохиолдуулан зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгийн арга хэмжээнд 1.500.000 төгрөг, Дэлхийн зөн Архангай-2 олон улсын байгууллагаас Өсвөрийн сэргийлэгч, Оюутан цагдаа бүлгэмийн гишүүдийн үнэмлэх, энгэрийн тэмдэг, хантааз, 2 өдрийн чадавхжуулах сургалтад 3.900.000 төгрөг, Үе тэнгийнхний дарамт байх ёсгүй” урианы дор “Нар хүүхэд бүхэнд адилхан тусдаг” хэлэлцүүлгийн арга хэмжээнд 500.000 төгрөг, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зохион байгуулсан сургалтад 860.000, дэлхийн зөн Архангай-1 олон улсын байгууллагаас 540.000 төгрөгийг шийдвэрлүүлсэн байна.

Алба хаагч нарт явуулж буй хичээл сургалтыг алба хаагчдаас санал авч, сүүлийн үеийн техник технологийг ашиглан, үр дүнтэй зохион байгуулах талаар анхаарч сургалтынхаа төлөвлөгөөгөө боловсруулан ажиллан нийт гадна болон дотоод сургалтад төрийн болон төрийн бус байгууллага 13, лектор багш, Флом олон улсын байгууллагын сэтгэл зүйч 5-ыг урьж оролцуулав.

-Зохион байгуулсан соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ;

Цагдаагийн газраас 2017 онд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Соён гэгээрүүлэх ажил зохиох /код-940/ журам”-ын дагуу алба хаагчдын оюун санаа, сэтгэхүйг

хөгжүүлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, албаны онцлогоос үүссэн сөрөг нөлөө, сэтгэл зүйн алжаалыг тайлах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд:

Алба хаагчдад улс орны болон гадаад орнуудын улс төр, нийгэм, эдийн засаг болон танин мэдэхүйн бусад мэдээлэл өгөх зорилгоор цагдаагийн газрын ахлагч, дунд офицер бүрэлдэхүүнийг Мягмар, Лхагва, Пүрэв гаригт хуваарийн дагуу нийт бүрэлдэхүүнд 5-10 минут “Сонсгол”-ыг явуулж, тасгийн дарга, ахлах албан тушаалтныг Баасан гариг бүр хувь хүний болон байгууллагын соёл, хүн чанар, ажилд хандах хандлага, сэтгэлгээг өөрчлөх, стресс тайлах арга гэх мэт 5-10 минутын мэдээллийг тогтмол явуулж байна.

Хууль сахиулах их сургууль, аймгийн Хуулийн хэлтэс, хуулийн байгууллагаас зохион байгуулсан Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой холбоотой илтгэл, эссэ, эрдэм шинжилгээний хурал зэрэгт тухай бүр алба хаагчдыг идэвхтэй оролцуулж байна.

Бусад цагдаагийн газрын техник, технологийн ололтын талаарх мэдээллүүдийг сурталчилж судлуулах зорилгоор цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн алба хаагчдаас зохицуулагч, цагдаагийн ахмад Лхагвадорж, цагдаа- зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Эрдэнэцогт нар 2017 оны 04 дүгээр сард Улаанбаатар хот Чингэлтэй дүүргийн Замын цагдаагийн хэлтэст 10 хоногийн хугацаатай солилцоогоор ажиллав.

Цагдаагийн байгууллагын өнгө төрхийг гадаад дотоодод илэрхийлэх, албаны нэр хүндийг бэхжүүлэх, урлаг соёлын болон соён гэгээрүүлэх олон талт ажлаар дамжуулан алба хаагчдын соёл, гоо зүйн мэдрэмж, сэтгэлгээг хөгжүүлэх, ажлын стрессийг тайлах, хууль сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2017 оны 07 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд Цагдаагийн ерөнхий газрын Сүлд чуулгын хамт олныг бүрэн бүрэлдэхүүнээр нь урьж хамтран ажилласан. Тус арга хэмжээний үед “Тантай үргэлж хамт” арга хэмжээ болон цагдаагийн албаны тухай хуулийг хэн сайн мэдэх вэ тэмцээн, алба хаагчдын дунд “Хайрын үдэш” зэрэг олон арга хэмжээг зохион байгуулснаас гадна Цахир, Ихтамир, Эрдэнэбулган суманд урлагийн тоглолтыг иргэд, алба хаагчдад үзүүлсэн нь үр дүнтэй ажил болсон юм.

Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан Төрийн ордон болон хууль тогтоомж, төрийн болон байгууллагын бодлого чиглэл, үйл ажиллагаатай танилцах Залуучуудын нэгдсэн уулзалт, зөвлөгөөнд мөрдөгч, цагдаагийн дэслэгч Мандах 12 дугаар сард оролцлоо.

Цагдаагийн газраас 2017 онд батлагдсан орон тоогоор 133 алба хаагчид хууль тогтоомж болон байгууллагын бодлого чиглэл, үйл ажиллагаатай холбоотой бусад арга хэмжээ 15 удаа давхардсан тоогоор 1995 алба хаагчид, улс орны болон гадаад орнуудын улс төр, нийгэм эдийн засгийн болон танин мэдэхүйн бусад мэдээлэл 16 удаа 2128 алба хаагчид, түүхэн замнал, шинжлэх ухаан, техник, технологийн ололтын талаарх мэдээлэл 8 удаа 1064 алба хаагчид, бусад 69 удаа 8677 удаа нийт 108 удаа 12837 алба хаагчийг хамруулжээ. Мөн сонин хэвлэлд 58 удаа, телевиз 80 удаа мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулжээ.

Соёл, хүмүүжлийн арга хэмжээний хүрээнд:

Тус цагдаагийн газар нь алба хаагчдын эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, чийрэгжилт, албаны бэлэн н хангах зорилгоор долоо хоног бүр биеийн тамирын арга хэмжээг гадна талбайд болон аймгийн Биеийн тамир спортын газартай гэрээ байгуулан спортын төв зааланд долоо хоног бүрийн Пүрэв, Даваа гаригт биеийн тамирын арга хэмжээ, дасгал хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийн ажил арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Алба хаагчдын бие бялдрын өв тэгш хүмүүжил, албаны бэлэн байдал, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, албаны сургалтыг дэмжих зорилгоор цагийн хуваарийн дагуу 7 хоногт тус газрын бялдаржуулах танхимд тасаг албад хуваарийн дагуу бэлтгэл, сургуулилт хийж хэвшсэн.

Дотоодод зохион байгуулсан тэмцээн, уралдаан

Цагдаагийн газрын 2017 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө, спортын уралдаан тэмцээн зохион явуулах хуваарийн дагуу цагдаагийн газрын аварга шалгаруулах “Заалны хөл бөмбөг”-ийн тэмцээнийг Эрүүгийн цагдаагийн тасгаас 01 дүгээр сард, “Дартс”, “Билльярд”-ын тэмцээнийг Эрдэнэмандал сум дахь сум дундын цагдаагийн тасгаас 02 дугаар сард, “Буудлага”-ын /Хийн бууны/ тэмцээнийг цагдаагийн газрын нийт эмэгтэйчүүд алба хаагчид дунд Хэрэг бүртгэх мөрдөн байцаах тасгаас 03 дугаар сард, Монгол улсад Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 96 жилийн ойг угтаж “Марш тактик”, “Буудлага”-ын тэмцээнийг Нийтийн хэв журам хамгаалах тасгаас тасаг 3 дугаар сард, “Сагсан бөмбөг”-ийн тэмцээнийг Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгаас 4 дүгээр сард, “Үндэсний бөх”, “Элсний гар бөмбөг”-ийн тэмцээнийг Захиргааны удирдлагын тасгаас 7 дугаар сард, намар цагийн хичээл сургалтын нээлтийг гадна талбайн “Хөл бөмбөг”-ийн аварга шалгаруулах тэмцээнийг Нийтийн хэв журам хамгаалах тасгаас 9 дүгээр сард, “Гар бөмбөг”-ийн аварга шалгаруулах тэмцээнийг Замын цагдаагийн тасгаас 10 дугаар сард, төв, орон нутгийн тасгийн алба хаагчдын дунд тус тус зохион байгууллаа. Энэ оны 12 дугаар сард “Шатар, даам”-ын аварга шалгаруулах болон Цагдаагийн газрын даргын нэрэмжит цогцолбор хаалтын тэмцээнийг зохион явуулахаар

төлөвлөөд байна.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгаас хэрэг бүртгэх эрх бүхий алба хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, хэрэг бүртгэх чадавхыг дээшлүүлэх зорилгоор “Шилдэг хэрэг бүртгэгч-2017” тэмцээнийг 5 дугаар сард, замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх “Уран зохицуулагч 2017” тэмцээнийг 4 дүгээр сард, “Шилдэг хэсгийн төлөөлөгч 2017” тэмцээнийг 9 дүгээр сард, “Шилдэг цагдаа 2017” тэмцээнийг 11 дүгээр сард тус тус зохион байгуулж үр дүнг тооцов.

Мөн цагдаагийн газраас нийт алба хаагчдын авьяас чадварыг нээх, хөгжүүлэх, хамт олны идэвх хамтын оролцоог нэмэгдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойн баярын бэлтгэл ажлын хүрээнд “Урлагийн баг” бүрдүүлэх зорилгоор 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр цагдаагийн газрын “Урлагийн наадам”-ыг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд гоцлол дуу, хамтлаг болон дуэт дуу, гоцлол бүжиг, хамтлаг бүжиг, язгуур урлаг, хөгжим гэсэн 6 төрөлд 5 багийн нийт 80 орчим алба хаагч өрсөлдөж номер тус бүрд байр эзлүүлсэн ба арга хэмжээнд алба хаагчдын гэр бүл идэвхтэй оролцсон юм.

Тэмдэглэлт баяр, ёслолын арга хэмжээ

Цагдаагийн газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу “Алтан унжилгат” хэмээх гал тахиа жилийн Цагдаагийн газрын алба хаагчдын нэгдсэн золголт арга хэмжээг Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсэг, “Ахмад ажилчдыг хүлээн авах” арга хэмжээг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасаг 2, 10 дугаар сард, “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн арга хэмжээг Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасаг, “Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 96 жилийн ойн баяр”-ыг эмэгтэйчүүдийн зөвлөл 3 дугаар сард, “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан алба хаагчдын гэр бүлийн зөвлөгөөн зохион байгуулах арга хэмжээг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасаг 6 дугаар сард, Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 96 жилийн ойг Замын цагдаагийн тасаг 7 дугаар сард, “Монголын болон Олон улсын ахмадын эрхийг хамгаалах өдөр”-ийн арга хэмжээг Захиргааны удирдлагын тасаг 10 дугаар сард, “Ахлагч нарын баяр”-ыг Нийтийн хэв журам хамгаалах тасаг 11 дүгээр сард, БНМАУ тунхагласны 93 жилийн ойн баярыг тохиолдуулан “Цол гардуулах арга хэмжээ”-г Захиргааны удирдлагын тасаг 11 дүгээр сард тус тус зохион байгуулж арга хэмжээ бүрийг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу тэмцээн уралдаан, урлаг соёлын арга хэмжээтэй өргөн дэлгэр иргэд олон нийт, гэр бүл, алба хаагчдыг хамруулсан ажил болсон.

Дээрх тэмдэглэлт баяр, ёслолын арга хэмжээнд аймгийн Ичинхорлоогийн нэрэмжит Хөгжимт драмын театр, Цагдаагийн ерөнхий газрын “Сүлд” чуулга, аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран алба хаагч, түүний гэр бүл, ахмад ажилчдын соёл, гоо зүйн хүмүүжил, мэдлэгийг дээшлүүлэх ажлыг хамтран зохион байгууллаа.

Улс, аймаг бүсийн тэмцээн уралдаанд оролцсон байдал:

Аймгийн Засаг даргын тамгын газар, Биеийн тамир спортын газраас Алба хаагчдыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, амралт чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор “Тамирын жавар” өвлийн бэсрэг наадмыг байгууллагуудын дунд зохион байгуулж тус наадмын хүрээд зохион байгуулагдсан тэмцээн уралдаанд цагдаагийн алба хаагчид оролцож мөсний “Кирлинг”-ийн төрөлд цагдаагийн дэд ахлагч О.Батсуурь 3-р байр,

Цагдаагийн ерөнхий газрын Хүч спорт хорооноос зохион байгуулсан Хүндийн өргөлтийн аварга шалгаруулах тэмцээнд цагдаагийн газраас 2 алба хаагч оролцож 69 кг-ын жинд О.Батсуурь мөнгөн медаль, 77 кг-ын жинд Б.Баттогтох шагналт тусгай байр, мөн хүчний “Гурван төрөлт”-ийн тэмцээнд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч О.Батсуурь Суулт, Таталтын төрөлд тус 2 дугаар байр эзлэн хос мөнгөн медаль, нийлбэр дүнгээрээ хүрэл медаль,

ЦЕГ-ын аварга шалгаруулах Сагсан бөмбөг, Гар бөмбөгийн тэмцээнд шигшээ баг бүрдүүлэх, иргэд олон нийтэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор Хангайн бүсийн аварга шалгаруулах тэмцээн Өвөрхангай аймгийн Хархорин суманд зохион байгуулагдаж Архангай, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор аймгуудын баг тамирчид хурд, хүч оюун ухаанаараа өрсөлдсөнөөс тус цагдаагийн газрын баг тамирчдаас “Үндэсний бөх”-ийн төрөлд багийн дүнгээр 3-р байр, “Шатар”-ын ганцаарчилсан төрөлд цагдаагийн хошууч Ч.Цэрэнбат 3-р байр, багийн дүнгээр 2 дугаар байр, сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй баг тамирчид хүрэл медаль,

2017 оны 03 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Архангай аймгийн Онцгой байдлын газар, Цэргийн штаб хамтран аймгийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын аймгийн аварга шалгаруулах “Марш-тактик”-ын тэмцээнд Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Тагнуулын хэлтсийн нийт 7 багийн 56 тамирчин оролцож

хурд хүч авхаалж самбаагаа сорьсноос нийлбэр дүнгээр Цагдаагийн газрын баг тамирчид 1-р байр эзэлж алтан медаль, шилжин явах цом,

Аймгийн Биеийн тамир спорт хорооноос 05 дугаар сард зохион байгуулсан насанд хүрэгчдийн “Сагсан бөмбөг”-ийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 32 баг тамирчид өрсөлдсөнөөс тус цагдаагийн газрын эрэгтэй баг тамирчид тэргүүн байр,

ХААН банкны нэрэмжит “Гар бөмбөг”-ийн аймгийн аварга шалгаруулах /холимог/ тэмцээнд нийт 24 баг тамирчид өрсөлдсөнөөс цагдаагийн газрын баг тамирчид тэргүүн байр эзэлж алтан медаль, шилжин явах цомоор,

Архангай аймгийн хуулийн байгууллагуудын дунд зохион байгуулсан хүчний гурван төрөлт “Фауэрлифтинг”-ийн аварга шалгаруулах тэмцээнд тус цагдаагийн газраас 66кг жинд цагдаа, цагдаагийн дэд ахлагч Б.Даваадорж 1 алт, 1 хүрэл, хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Д.Цэнд-Аюуш 1 мөнгө, 73 кг жинд харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч О.Батсуурь 2 алт, 83 кг жинд хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Б.Баттогтох 2 алт, -93 кг жинд хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Э.Алтанбаатар 2 алт, +93кг жинд харуулын цагдаа, цагдаагийн ахлагч М.Ариунболд 2 хүрэл, мөрдөн байцаагч, цагдаагийн дэслэгч У.Амгаланбаатар 2 мөнгөн медалийг тус тус хүртэж багийн дүнгээр 1 дүгээр байр эзлэн шилжин явах цомоор,

Аймгийн аварга шалгаруулах 3x3 сагсан бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцож тусгай байр,

БНХАУ-аас Монгол Улсад суугаа бүрэн эрхэд элчин сайдын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах холимог багийн “Гар бөмбөг”-ийн тэмцээнд тэргүүн байр эзэлж алтан медаль, цомоор тус тус шагнагдлаа.

Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2017 оны 09 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулсан ажил мэргэжлийн аварга шалгаруулах “Шилдэг хэсгийн байцаагч” шалгаруулах тэмцээнд тус цагдаагийн газрын хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад Ж.Амгаланбаатар амжилттай оролцжээ.

Музей, түүх дурсгалын газруудыг үзүүлэх, байгалийн үзэсгэлэнт газраар тойрон аялал:

Улсын их хурлын гишүүн Ё.Баатарбилэгийн санаачилгаар Монгол улсаар ОХУ-ын Улан-Уда хотод 10 хоногийн хугацаанд үнэ төлбөргүй аялах эрхийн бичгээр Хангай сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Ц.Самбуу, Өндөр-Улаан сумын хэсгийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Зоригтбаатар, эдийн засгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч Д.Баяржаргал нарыг шагналаар аялуулсан.

Мөн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 802-ийн хэрэгжилтийг хангах, цагдаагийн газрын албаны байр, эд зүйлсийн эмх цэгц, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ашиглалтыг сайжруулах алба хаагчдын ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх болзолт уралдаан зохион байгуулан үр дүнг тооцож тэргүүн байранд шалгарсан Замын цагдаагийн тасгийн 10 алба хаагчдыг Оросын Холбооны Улсын Улан-Уда хот, Сэлэнгэ, Дархан, Эрдэнэт, Булган аймаг дахь цагдаагийн газраар туршлага судлан аялуулж, Дэд байр эзэлсэн Захиргааны удирдлагын тасгийн 10 алба хаагчийг Монгол улсын үзэсгэлэнт газар Архангай, Өвөрхангай аймгийн Суврага хайрхан, Дөвхөний хийд, Өгий нуур, Цогтын хар балгас гэх мэт түүх соёлын дурсгалт газруудаар эртний түүхэн замнал соёлыг судлах аялах эрхийн бичгээр шагнаж аялууллаа.

Цагдаагийн газраас 2016 онд хамт олноо хошуучлан ажилласан Хотонт сум дахь сум дундын цагдаагийн тасгийн 8 алба хаагчийг 01 дүгээр сард Улаанбаатар хотын Цагдаагийн газрын ахмадын зөвлөлтэй уулзаж туршлага судлах, Скай ресорт цанын баазад амралтын өдрийг зөв боловсон өнгөрүүлэх 3 хоногийн эрхийн бичгээр шагнаж урамшуулав.

Аймгийн Ичинхорлоогийн нэрэмжит Хөгжимт драмын театрын “Хавар цагийн нээлтийн тоглолт”, “Би эндээс явахгүй” жүжиг, Монгол улсын гавьяат жүжигчин Чулуунхүү, залуу дуучин Б.Минжүүр нарын бие даасан тоглолт зэрэг үзвэрийг 5 удаа алба хаагчдад үзүүлжээ.

Олон нийтийг хамарсан соён гэгээрүүлэх ажил:

Цагдаагийн газраас ЦБҮАЖ /код 802/-ын дагуу цагдаагийн газрын албаны байр болон алба хаагчийн ажиллах таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр “Цэцэгжүүлэлт” аян зохион байгуулж 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдөр цагдаагийн газрын гадна саадад цэцгийн төгөл хийж цэцэг тарилаа. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүх нийтээр “Мод тарих үндэсний өдөр”-ийг 2017 оны 05 дугаар сарын 13-нд “Нэг иргэн-Нэг мод” урианы дор зохион байгуулахаар Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Цагдаагийн газрын алба хаагчид 11.00-14.00 цагийн хооронд Барилгын 16-р байрны баруун талд төв зам дагуу хайсанд 15 ширхэг “Хайлаас”, 50 ширхэг “Шар хуайс” модыг стандартын дагуу тарьж усаллаа.

Аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Эрүүл Монгол” хөтөлбөрийн хүрээнд тус цагдаагийн газрын 98 алба хаагч “Явган аялал”-д хамрагдсан.

Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч З.Баярсайханы санаачилгаар захиргааны хяналтад байсан 15 настай Мягмарнаран хүү болон түүний ээж П.Даваадорж нарыг 5 ханатай иж бүрэн гэртэй болгох сайн үйлсийн аяныг зохион байгууллаа. Дээрх хүмүүнлэгийн ажлыг “Бие даасан хөгжил” төрийн бус байгууллагын тэргүүн С.Нямсүрэн таатай хүлээн авч иж бүрэн 5 ханатай гэрийн санхүүжилтийг богино хугацаанд шийдвэрлэсэн юм.

Цаашид хүүг дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлж, эерэг зан үйл олгох, амьдралын зөв хэвшилд төлөвшихөд бодитой хувь нэмэр болсноос гадна тухайн арга хэмжээг дэмжиж төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллахаа илэрхийлж байсан юм.

Цагдаагийн газраас 2017 онд соёл, гоо зүйн хүмүүжил, мэдлэгийг дээшлүүлэх талаар 6 удаа давхардсан тоогоор 798 алба хаагчид, соёл, урлагийн чиглэлээр 7 удаа 931 алба хаагчид, биеийн тамир, спортын арга хэмжээний чиглэлээр 22 удаа 2926 алба хаагч, улс орон байгууллагын түүхийг сурталчлах, ахмад ажилтан, алдар цуутай хүмүүстэй уулзалт 5 удаа 665 алба хаагч, музей, түүх дурсгалын газруудыг үзүүлэх, байгалийн үзэсгэлэнт газраар тойрон аялал 2 удаа 102 алба хаагч, мэргэжлийн болон зарим ном, хэвлэлийн талаар ярилцлага, хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн 3 удаа 317 алба хаагч, бусад 6 удаа 798 алба хаагч нийт 51 удаа зохион байгуулж 6537 алба хаагчийг хамруулжээ.

- Урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Цагдаагийн газар нь 2017 онд Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хуулиар хүлээсэн чиг үүрэг, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас батлан хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсээс ирүүлсэн төлөвлөгөө, ажлын чиглэлийн хүрээнд хариуцсан орон нутгийн хэмжээнд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх” зорилт дэвшүүлэн дараах ажлыг зохион байгуулж ажиллаа.

Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд бичсэн танилцуулга, саналын тоо, шийдвэрлэлт: Тус цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд 79 удаа танилцуулга, санал хүргүүлснээс Цагдаагийн ерөнхий газарт хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, аймгийн Засаг даргад эрүү хэв журмын мэдээ, танилцуулгыг сар бүр, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөх журмын төслийг шийдвэрлүүлэхээр 1, нийт 17 удаа, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд эрүү хэв журмын нөхцөл байдлан мэдээ, танилцуулгыг сар бүр, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус бүр 3, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, архи дан согтуурахтай тэмцэх чиглэлээр 1, нийт 21 удаа, Сум дүүргийн Засаг даргад бусдын биед гэмтэл учруулах чиглэлээр 7, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 6, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, хулгайлах гэмт хэрэг, архи дан согтуурахтай тэмцэх, бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус бүр 1 нийт 18 удаа, Сум дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, бусдын биед гэмтэл учруулах чиглэлээр 8, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архи дан согтуурахтай тэмцэх чиглэлээр тус бүр 1, нийт 21 удаа танилцуулга, санал, хүсэлтийг хүргүүлэн ажиллажээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт тус цагдаагийн газраас зохион байгуулсан онцлог үйл явдал, зохион байгуулсан арга хэмжээний талаар фото зурган танилцуулгыг сар бүр хүргүүлэн, үйл ажиллагаагаа танилцуулан ажилласан байна.

Ухуулга, яриа, сургалт, сурталчилгаа: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа 114 уулзалт, хэлэлцүүлэг ярилцлага 22, өдөрлөг 9, уралдаан, тэмцээн 7, нийт 152 удаа зохион байгуулж 15850 иргэнийг хамруулсан байна. Энэ арга хэмжээг агуулгаар нь авч үзвэл: нийт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 17, хулгайлах гэмт хэргийн талаар 3, бусдын биед гэмтэл учруулах 4, танхайрах гэмт хэргийн талаар 4, залилан мэхлэх гэмт хэргийн талаар 1, зам тээврийн осол хэргийн талаар 17, гэр бүлийн хүчирхийллийн талаар 43, хүүхдийн гэмт хэргийн талаар 44, архи дан согтуурахтай тэмцэх чиглэлээр 17, хар тамхи мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн талаар 1 нийт 152 удаа ухуулга, яриа, сургалт сурталчилгаа зохион байгуулжээ.

Ухуулга, яриа, сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэд, байгууллага: Дээрх ухуулга, яриа, сургалт, сурталчилгаанд 15850 иргэн хамрагдсаны дотор хувиараа хөдөлмөр эрхлэгч 2509, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан 2951, малчин 3004, оюутан 2550, сургууль завсардсан хүүхэд 17, сурагч 3482, ажилгүй 1337 иргэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ухуулга сурталчилгааны ажилд нийт давхардсан тоогоор 768 байгууллага, аж ахуйн нэгж хамрагдсаны дотор төрийн байгууллага 229, төрийн бус байгууллага 93, аж ахуйн нэгж 197, их дээд сургууль коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв 37, ерөнхий боловсролын сургууль 145, цэцэрлэг 68 удаа оролцсон байна.

Бичсэн мэдэгдэл, шаардлага, авсан хариу: Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 117 мэдэгдлийн дугаар авч, 850 аж ахуй нэгж, байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллаа.

Үүнд: Бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 13, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 17, бусдын биед гэмтэл учруулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 13, танхайрах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 21, зам тээврийн осол гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 17, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 8, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 14, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 12 мэдэгдлийг 850 аж ахуй нэгж, байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэн, хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, мөрдөгч, хэрэг бүртгэгч нараас хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр 252, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр 528, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах чиглэлээр 46 байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтанд албан мэдэгдлийг тус тус хүргүүлж, биелэлт үр дүнг тооцон ажиллаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгууллага, аж ахуй нэгжийн камержуулалт, хамгаалалт аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр 11 мэдэгдлийг 119 байгууллага, аж ахуй нэгжид хүргүүлж, биелэлтийг газар дээр нь шалгаж, биелэлт үр дүнг тооцон ажиллахад 100 хувь цонхны хамгаалалт, хаалганы бат бөх байдлыг хангаж, 55 байгууллага, аж ахуй нэгж гадна, 33 аж ахуй нэгж дотор камержуулалтын системийг суурилуулан ажилласан байна.

Гэмт хэрэгт холбогдсон, зөрчил гарган шүүгчийн захирамжаар баривчлагдсан, эрүүлжүүлэгдсэн этгээдүүдийг дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах чиглэлээр 99 мэдэгдлийг 479 сум, багийн засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн дарга, байгууллага, аж ахуй нэгжийн захирал нарт хүргүүлснээс хуулийн хугацаанд 62 мэдэгдлийн 252 албан тушаалтнаас ирүүлсэн биелэлтийн үр дүнг тооцон ажиллаа.

Одоогийн байдлаар 27 мэдэгдлийн 98 албан тушаалтнаас хуулийн хугацаанд хариу ирүүлээгүй байна. Хуулийн хугацаанд хариу ирүүлээгүй 1 аж ахуй нэгжийг Зөрчлийн тухай хуулиар торгож шийдвэрлэсэн байна.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр явуулсан ухуулга, сурталчилгаа:

Телевизээр: Тус цагдаагийн газраас орон нутгийн хэвлэл мэдээллийн албадтай хамтран 2017 онд хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрээний хүрээнд тасаг албадаас газрын даргын баталсан хуваарийн дагуу 7 хоног бүр эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 117 удаа мэдээ, мэдээлэл, ярилцлага, нэвтрүүлгийг бэлтгэн МОНЦАМЭ, малчин, ТВ-9, ТВ-5, MHD, Нутаг-21 телевизэд мэдээг явуулж, иргэд олон нийтэд хүргэж ажилласан.

Үүнээс: бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 21, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 16, бусдын биед гэмтэл учруулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 7, танхайрах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4, залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 20, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 14, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 13, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 10, бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 6, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 удаа тус бүр мэдээлэл, ярилцлага, нэвтрүүлгийг явуулж, 8 төрлийн зар, мэдээг 3-4 удаа өгсөн байна.

Цагдаагийн газрын үйл ажиллагаа, алба хаагчдын өдөр тутам хийж гүйцэтгэж байгаа ажлыг иргэд олон нийтэд таниулах, цагдаагийн байгууллага иргэд олон нийттэй уялдаа холбоотой ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг ойлгуулах, үйл ажиллагааг сурталчлах зорилгоор төрөл бүрийн байгууллагын алба хаагчдыг оролцуулсан “Мэргэжил бүхэн сайхан” нэвтрүүлгийг “АВ” телевизтэй хамтран 1 удаа зохион байгууллаа.

Монголын уламжлалт “Цагаан сар”-ын баярыг угтан согтуугаар үйлдэгдсэн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 төрлийн шторк бэлтгэн “Архангай” “АВ” телевизээр 7 хоногийн турш өдөр бүр нэвтрүүлэн ажиллаа.

Орон нутгийн “Тамир” телевизтэй хамтран “Мал, орон байрны хулгай”, “Зам тээврийн осол, гэмт хэрэг”-ээс урьдчилан сэргийлэх 3 шторкыг бэлтгэн, телевизээр болон цахим

сайтад тавьж иргэдэд сэрэмжлүүлгийг хүргэлээ.

Мөн гол усны үерээс сэрэмжлүүлэх, халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, "Цэнхэр халим" тоглоомын сөрөг нөлөөлөл, ахуйн хэрэглээний газ, мансууруулах төрлийн эм бэлдмэл хэрэглэх түүний хор уршиг, үр дагаврын талаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон өсвөр насны хүүхдүүдэд үнэн зөв мэдээлэл хүргэх, болзошгүй үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор "АВ", "Тамир" телевизүүдээр болон "Архангай цагдаагийн газар"-ын сайтад сэрэмжлүүлэг, шторк бэлтгэн ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажилласан.

Цагдаагийн газрын тасаг албадаас "Архангай амьдрал", "Архангай толь" сонинд бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3, архидан согтуурахтай тэмцэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр 2, бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3, танхайрах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1, залилан, мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, нийт 25 удаа мэдээлэл, нийтлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмж бэлтгэн, иргэд олон нийтэд хүргэсэн байна.

Цахим хуудсаар: Мөн цахим вэб сайт, www.facebook.com/Архангай, www.facebook.com/архангай замын цагдаа/ хаяганд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр 112 удаа мэдээлэл, сэрэмжлүүлэг, нэвтрүүлэг, шторк, зөвлөмжийг тухай бүр оруулан байгууллагынхаа үйл ажиллагааг иргэд, олон нийтэд шуурхай хүртээмжтэй хүргэж ажиллаа. Архангай цагдаа фэйсбүүк хаягт одоогоор 4.600 дагалдагчтай, оруулсан 112 мэдээллийг 18000 гаруй иргэд үзэж хандсан байна.

Цагдаагийн газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага 35, зурагт хуудас 23, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж 48-ийг нийт 8310 ширхгийг боловсруулан иргэд, олон нийтэд тарааж сурталчилсан байна.

Судалгаа хяналтад бүртгэсэн: Гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг 5, зочид буудал 16, автомашин дулаан граж, ил зогсоол 2, банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо 19, томоохон зах бөөний төв 3, хаягдал түүхий эд авдаг газар 5, эмнэлэг 14, архи согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгж 157, аялал жуулчлал, амралтын газар 3, авто засвар сэлбэг хэрэгсэл борлуулдаг газар 23, интернет, РС тоглоом, өнгөт хэвлэгч, олшруулагч ашигладаг газар 5, боловсролын байгууллага 22, эмийн сан, үйлдвэр 17, улсын онц чухал объект 18, буяны шашны байгууллага 12 буюу нийт 14 бүртгэлд 321 объект, **субъектийн бүртгэлд:** гэмт хэрэгт уруу татагч 27, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 66, архаг архичин 160, тэнэмэл иргэд 9, сэжигтэй бүлэг бөөгнөрлийн гишүүд 23, сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүс 11, тусгай мэргэжлийн хүмүүс 3, ченжүүд 35, хэрэгт холбогдож, өртөж болзошгүй этгээд 156, алт мөнгөний дархан 2, төв суурин газрын мал бүхий иргэд 5, буюу нийт 11 бүртгэлд 844 субъектийг бүртгэж картыг маягтын дагуу бичиж санд баяжилт хийсэн.

Захиргааны хяналтад буй хүнтэй ажилласан байдал:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2012 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 352 дугаар тушаалаар батлагдсан "Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоох" /код 601, 619/, ЦБҮАЖ-ын Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн заавар /код 702/, Хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон, тэнсэж хянан харгалзах ял шийтгүүлсэн ялтан захиргааны хяналтаас зайлсхийж оргон зайлсан тохиолдолд түүнийг "Эрэн сурвалжлах ажил" /код 228/-д зэрэг журам, "Алдаанаасаа суралцъя" сэдэвт сургалтыг хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын нэгдсэн 6 удаагийн 46 алба хаагчид 9 цагийн сургалтыг зохион байгуулж, "Тэнсэгдсэн ялтанд хяналт тавих журам"-ыг хэрэгжүүлэн ажиллах чиглэлээр "Ажлын чиглэл", "Зааварчилга" 3 удаа хүргүүлж, мэргэжил арга зүйн таслалцаа үзүүлэн биелэлтийг сар бүр тооцон ажиллаа.

Тус цагдаагийн газрын эрх бүхий алба хаагч нар дээр оны эхэнд хорихоос өөр төрлийн ялтай, захиргааны хяналттай нийт 75, хяналтын хугацаа дууссан 94, нэмж хяналтад авсан 72, нийт 166 ялтанд хяналт тавьж ажилласнаас шүүхээс шинээр хорих ял тэнсэн суллагдсан 57, хорихоос тэнсэн суллагдсан 6, хүмүүжлийн чанартай арга хэмжээ оногдуулсан, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 17, нийт 80 ялтанд хувийн хэргийг шинээр нээж хяналт тавин ажилласан байна.

Одоо хяналтад нийт 79 ялтан байгаагаас, ял хойшлогдсон 2, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ арга хэмжээ авагдсан 2, шүүхээр тэнсэн суллагдсан 64, хорих ял тэнсэн суллагдсан 11 байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 зүйлд зааснаар Хорих ял эдлээд суллагдсан 3 хүнд хяналт тавьж ажиллаж байна.

Хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй хүмүүсийг хүлээн авч бүртгэл судалгаанд хамруулахдаа гарын хээ дардас, фото зураг, анкетийг бүртгэн авч

папилон болон генетик мэдээллийн санд оруулан хяналтын хувийн хэрэг нээж, бүртгэл судалгаанд авч, нэгдсэн санд мэдээллийг орууллаа. Захиргааны хяналттай хүмүүст 4 удаа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх чиглэлээр сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулан ажилласан нь үр дүнтэй ажил болсон.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр

Нийтийн эргүүлд: Монгол улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг татан оролцуулах, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа эрчимжүүлэх, гудамж талбай, олон нийтийн газарт нийтийн хэв журам сахиулах чиглэлээр иргэдийг **“Нийтийн эргүүл”**-д ажиллуулах хуваарийг гарган сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн даргаар батлуулж хуваарийн дагуу 19 сумын 410 төр, захиргааны байгууллага, аж ахуй нэгжийн 5914 иргэн давхардсан тоогоор нийтийн эргүүлд ажиллаа.

Монголын уламжлалт “Сар шинэ”-ийн баярын амралтын өдрүүдэд тодорхой төрлийн гэмт хэрэг, гарч болзошгүй осол аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллага, аж ахуйн нэгжүүдэд **“Хариуцлагатай эргүүл жижүүр”** томилон ажиллуулах, байгууллагын аюулгүй байдлыг хангаж, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл 42-ийг хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, өдөрлөг, хэлэлцүүлэг, сургалт, зөвлөгөөний хүрээнд байгууллага, аж ахуй нэгжийн ажилчид, иргэд, олон нийтийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжуудыг сурталчлах, мэдээлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр 768 байгууллага, аж ахуйн нэгжийн 15850 гаруй иргэнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулсан.

Олон нийтийн цагдаагийн ажилтан: Аймгийн хэмжээнд 2017 онд ажиллах олон нийтийн цагдаагийн ажилтны тоо, ажилтны урамшууллыг шийдвэрлүүлэх чиглэлээр аймгийн Иргэдийн хурлын даргад 2017 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн 33/21, сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, засаг дарга нарт 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 33/388 тоотой саналыг тус тус хүргүүлснээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 122-128 тоот албан бичгээр Цэнхэр, Тариат, Ихтамир, Эрдэнэмандал, Жаргалант Хотонт, Хайрхан сумдад олон нийтийн цагдаа ажиллуулах саналыг хүргүүлснээр Хайрхан, Цэнхэр, Хотонт, Булган, Хангай сумдад олон нийтийн цагдаагаар 5 иргэнийг судалж байна. Аймгийн 19 сумын Засаг дарга, Хурлын дарга нарт 2018 оны төсөвт олон нийтийн цагдаагийн ажилтныг ажиллуулах урамшуулал, хувцасны зардлыг шийдвэрлэж 2018 онд хариуцсан сумандаа олон нийтийн цагдаагийн ажилтныг ажиллуулах талаар газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 35/3011 дугаарт албан бичгээр хүргүүлсэн.

Гудамж талбайн камержуулалтын талаар:

2017 онд гудамж талбайг хяналтад авах 4 ширхэг камерыг Эрдэнэбулган сумаас шилжүүлэн авч цагдаагийн газарт Хяналтын төвийг байршуулахад гарах зардал болох 1515000 төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн байршуулсан.

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын захирамжаар **“Орон нутгийн хөгжлийн сан”**-аас нийт 9.168.900 төгрөгийн хөрөнгө санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэн, камержуулах ажлыг гүйцэтгүүлэхээр Улаанбаатар хотын харьяат **“ДАКДД” ХХК**-тай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажилласан байна.

Тус компаниас гэрээнд заасан нөхцөлийн дагуу Европ стандартын **Hikvision /20xZoom/** брэндийн 5 ширхэг **хяналтын камер**, 1 ширхэг **NVR Hikvision ds 7116** маркийн **камерын бичлэг хадгалагч**, 6 ширхэг **Loco M5** маркийн агаарын дамжуулагч тус тус худалдан авч, Эрдэнэбулган сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах 38 дугаар байр /Спорт хорооны арын 10 давхар байр/, 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах 39 дүгээр байр /Худалдааны төвийн баруун талын 9 давхар байр/, Эрдэнэбулган сумын төвийн баруун урд талд байрлах **Майнт уулын станц**, Булган уулын өвөрт байрлах **“Зая гэгээний хийд”**, ЭБС-ын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах **Цогт-уулын станц** зэрэг газруудад тус тус байрлуулснаар гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд ашиглаж байна.

Аж ахуй нэгж, байгууллагыг камержуулах ажлын хүрээнд: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгууллага, аж ахуй нэгжийн камержуулалт, байрны аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр 11 мэдэгдлийг 119 байгууллага, аж ахуй нэгжид хүргүүлж, биелэлтийг газар дээр нь шалгаж, биелэлт үр дүнг тооцон ажиллахад 100 хувь цонхны хамгаалалт, хаалганы бат бөх байдлыг хангаж, 55 байгууллага, аж ахуй нэгж гадна, 33 аж ахуй нэгж дотор камержуулалтын системийг шинээр суурилуулан ажилласан байна.

Мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан талаар:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн болон

төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа идэвхжүүлэх чиглэлээр 19 сумын 414 байгууллага, аж ахуйн нэгжид мэргэжлийн удирдлагаар ханган хууль эрх зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллаа.

Иргэдийн үүсэл санаачилгын бүлэг, тоо:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумдын ГХУСАЗСЗ-ийн ажилтай танилцан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн хэрэгжилтийг хангуулан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Малчдын бүлгэм”, “Хөршийн хяналтын бүлгэм” байгуулах ажлыг танилцуулан ажилласнаар Эрдэнэмандал, Хайрхан, Өндөр-улаан, Ихтамир, Төвшрүүлэх, Хашаат, Чулуут сумдад нийт 37 малчдын бүлгэм байгуулагдан 229 иргэн сайн дураараа нэгдэн үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

Иргэдийн орон байранд хууль бусаар нэвтэрч эд зүйл хулгайлах төрлийн гэмт хэргийн гаралт өсөх хандлагатай байгаад анхаарч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурдын тэргүүлэгчдийн 2016 оны 03 сарын 01-ний өдрийн 09 тоот тогтоолоор “Хөршийн хяналт”-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр журмыг батлан Хайрхан, Эрдэнэмандал, Эрдэнэбулган сумдын багт 24 хөршийн хяналтын бүлгэм байгуулагдан, 245 гишүүдэд хууль тогтоомж, журмаар хичээл сургалтыг зохион байгуулан мэргэжил арга зүйгээр хангаж хамтран ажилласан.

Оюутан сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургуулийн эргүүлийг 5 сургуульд, хамтарсан багийг 19 сумын 25 багт, өсвөрийн сэргийлэгч бүлгийг 5 сургуульд тус тус байгуулан нийт 39 бүлгийн 5704 гишүүн ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд байгууллагыг урамшуулах.

Цагдаагийн газраас 2016 онд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд идэвх санаачлан гарган хамтран ажилласан, хуулиар хүлээсэн үүргээ сайн биелүүлсэн нэр бүхий иргэн, аж ахуй нэгж хамт олныг Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар шагнаж, Цагдаагийн газраас “Дурсамж”, “Талархал”-ыг гардуулав. Үүнд: “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан”-аар 1, цагдаагийн газрын “Талархал”-аар 8, “Дурсамж”-аар 4 иргэнийг тус тус шагнаж урамшуулав.

Мөн аймгийн төрийн байгууллагын удирдах албан хаагчдыг оролцуулсан “Мэргэжил бүхэн сайхан” нэвтрүүлгийн зохион байгуулсан ба тус нэвтрүүлгээр цагдаагийн албыг сурталчлах, олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд дээрх иргэдийг цагдаагийн албаны 1 өдрийн эргүүл, шалгалтыг бие даан гүйцэтгүүлж АВ телевизтэй хамтран зохион ажилласан юм.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх санаачилгатай оролцсон иргэдийг урамшуулах зорилгоор 200000 төгрөгийг шийдвэрлэснийг гэмт хэргийн талаар ач холбогдол бүхий мэдээлэл өгсөн иргэнд өгч урамшуулав.

Архангай аймаг дахь Цагдаагийн газрын Цахир сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч У.Баяртогтохыг албан үүргээ гүйцэтгэж яваад 3 хүүхдийн алтан амийг аврах үед иргэний үргээ нэр төртэй биелүүлж тусалсан Цахир сумын иргэн Энхбат болон эмчийн өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэн дээрх хүүхдүүдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлсэн тус сумын хүн эмнэлгийн эмч, сувилагч нарт талархаж Цагдаагийн газрын дарга “Талархал” хадгалуулан www.arkhangai.police.gov, Цагдаагийн ерөнхий газрын www.police.gov, хаяг, орон нутгийн телевиз, TV5, нутаг 21 телевиз, Архангайн толь, Архангайн амьдрал зэрэг сайт, цахим хаяг, телевиз, сонинд мэдээлж сурталчиллаа.

-Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар, түүний үр дүн.

Авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг байгууллага, нийт бие бүрэлдхүүний үйл хэрэг болгон алба хаагчтай байгуулсан үр дүнгийн гэрээнд заалт оруулж, авлигад өртөхгүй байх, удирдах албан тушаалтнуудын үлгэрлэл манлайлалтай ажиллаж, алба хаагч нарт тавих дотоодын хяналт, зарчимч шаардлагыг өндөржүүлэн ажилласнаас гадна авлигын хор уршиг, ашиг сонирхолыг зөрчил, түүнээс ангид байхыг уриалж хамт олноороо авлигыг тэвчиж ажиллахыг санал болгон гарын үсэг зуруулан авлигад өртөхгүй байх баталгааг гаргуулж “Нэг нь нийтийн төлөө”, “Авлига хүнд сурталгүй хамт олон” болох уриаг дэвшүүлэн хэрэгжүүлж ажиллаа.

Тус цагдаагийн газрын алба хаагчдаас хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах нийт 66 алба хаагчийн нэрсийн жагсаалтыг гаргаж, мэдүүлгийг хугацаанд нь гаргуулж авсан ба 2017 онд шинээр ахлагч бүрэлдэхүүнд 5 алба хаагч, шилжин ирсэн офицер алба хаагч 5, шинээр офицер алба хаагч томилогдсон 2, нийт 12 алба хаагчийн хөдөлгөөнийг шилжилт хөдөлгөөн хийгдэж тухай бүрт хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргуулан ажилласан.

Мэдүүлэг гаргагч 66 алба хаагчийн цаасаар болон цахим хэлбэрээр өгсөн мэдүүлэгт баталгааны маягтийг хүлээн авч тулган баталгаажуулж, мэдүүлгийг бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж ямар нэгэн алдаа зөрчилгүй бүрэн гүйцэд, хугацаандаа мэдүүлгийг гаргаж өгсөн. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, бүртгэх хянахтай холбогдуулсан Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 4/246 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу, ХАСХОМ-1, ХАСХОМ-3 тайланг гарган баталгаажуулж, хугацаанд нь хүргүүлсэн.

Мэдүүлэг гаргагчдад “Хуулийн хугацаа сануулах”, цахим хэлбэрээр мэдүүлгийг үнэн зөв бөглөх талаар 1 дүгээр сарын цугларалтаар сум дундын 3 цагдаагийн тасаг, сумдын хэсгийн төлөөлөгч нар нийт 27 алба хаагчдад 1 цагийн танхимын сургалт, 4 дүгээр сарын цагдаагийн газрын нэгдсэн хичээл сургалтаар Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шинээр батлагдаж гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад цаашид анхаарах асуудал сэдвээр 2 цагийн танхимын сургалтыг аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн С.Мөнгөнзаяаг урьж оролцуулан сургалт орж, алба хаагчдад зөвлөгөө өгч ажилласан.

Алба хаагчдаас Авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт бүрэлдэхүүнд 2 удаа 2 цагийн сургалт зохион байгуулж нийт 130 алба хаагч хамрагдсан ба “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх” талаар 2 удаа баталгаа гаргуулан авчээ. Тус цагдаагийн газрын 2017 онд нийт алба хаагч сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчдаас авлига ашиг сонирхол өртсөн тохиолдол алба хаагчдын дунд гараагүй байна.

Дөрөв: Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар

-Байгууллагын санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар хийсэн ажил, арга хэмжээ;

Тус цагдаагийн газар нь 2017 онд батлагдсан төсвийг тухайн жилд мөрдөгдөх орон тоо, үнэ тарифийн өсөлт болон бусад хүчин зүйлсийг бодитой тооцоолж зарцуулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэмнэлттэй, зөв зарцуулж ажилласнаар хэвийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлсэн байна. 2017 оны 12 дугаар сарын 22-ны байдлаар төвлөрсөн төсвийн санхүүжилт 1,826,465,400.00 төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 1,826,465,400.00 төгрөг зарцуулагдсан байна.

Төсвийн төлөвлөлтийг үндэслэл сайтай төлөвлөхийн тулд сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийг харьцуулан судалж оны эхнээс зардлын зүйл тус бүр дээр зарцуулалтын тооцоог гаргаж, гарсан зардлыг ажлын үр дүнтэй нь холбон тооцож, холбогдох арга хэмжээг авч төсвийг хэмнэлттэй үр ашигтай зарцуулж ажиллаа.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 2017 онд 57,326,000 сая төгрөгөөр батлагдаж, албадан саатуулах баривчилгааны орлого, тээврийн хэрэгсэл түр саатуулахын орлогыг хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийн дагуу орлогод авч, тээврийн хэрэгсэл түр саатуулахын орлого 3,064,000 төгрөг, албадан саатуулах байранд баривчлагдсан этгээдийн 1447 өдрийн ажлын хөлсний 8,827,700 төгрөг, эрүүлжүүлэхийн 764 хүний 3,173,500 төгрөг, Монгол банктай 4 гэрээт цагдаа ажиллуулж 47,583,396 төгрөгийг тус тус цагдаагийн газрын үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэж төсөвт 62,6 сая төгрөг төвлөрүүлэн ажилласан байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 62,9 сая төгрөгийг төсөвт байгууллагын орлогоор бүртгэн, тайлан тэнцэлд тусган, зарцуулалт хийгээгүй улсын төсөвт төвлөрүүлэн ажилласан болно.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн б/288 тоот тушаалаар баталснаар тус цагдаагийн газар 133 алба хаагчийн орон тоогоор ажиллаж байна.

Алба хаагчдын ажлыг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон Монгол Улсын “Төрийн албаны тухай хууль”-ийн 19 дүгээр зүйл, Цагдаагийн ерөнхий газрын 2010 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн 351 тоот тушаалаар батлагдсан “Алба хаагчийн ажлыг үнэлэх журам” /код 111/, үндэслэн 2017 оны 11 сарын 30-ний байдлаар 209 алба хаагчийн цалинг 5-20% нэмж, 69 алба хаагчийн цалинг 5-20% хасч үр дүнг тус тус тооцлоо. Алба хаагчдын цалингаас хууль тогтоомжид заагдсанаас бусад суутгалууд хийлгүй олгож байна.

Хүний нөөцийн судалгаагаар хугацаа болсон алба хаагч нараас 3 алба хаагчийн төрийн тусгай алба хаасны нэмэгдэл, 21 алба хаагчийн цалингийн шатлалыг тооцож олгох байгууллагын даргын тушаалыг үндэслэн бодож олгосон.

Эд хариуцагч нь санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг тухай бүр нь баримтжуулан хийж, Нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг боловсруулан бүртгэл, ерөнхий болон дэлгэрэнгүй данс хөтлөх, төсвийн зарцуулалтын мэдээг гаргахдаа нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санхүү бүртгэлийн ажилтан, эд хариуцагч нарын эрх зүйн мэдлэг, сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор нярав, эд хариуцагчаар бараа материал, мөнгөн хөрөнгийн тайланг

сар бүрийн 25-ны өдөр гаргуулахдаа баримтын анхан шатны бүрдэлтийг нарийн шалгаж үзэж нягтлан бодогч биечлэн хянан шалгаж авч хэвшсэн.

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болох ажил гүйлгээг нотлох, зохих ёсоор үйлдсэн орлого зарлагын баримт, бэлэн мөнгө хүссэн өргөдөл, банкны харилцахын хуулга, нэхэмжлэх, төлбөрийн даалгаварыг гүйлгээ гарсан тухай бүр бүрдүүлж тайланг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон гаргуулж, гүйцэтгэлийн хяналт тавих ажиллагааг нягтлан бодогч биечлэн хянаж шалган, хүлээн авч ажиллаа.

“Төсвийн байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.1- д заасны дагуу мөнгөн кассын гүйлгээг нярав хариуцан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын дагуу мөнгөн касс бэлэн мөнгө, үнэт цаасны баримтыг нэг бүрчлэн бүрдүүлж орлогод авах, мөнгөн кассын орлого, зарлагын ордерийг тухай бүр бичиж төсвийн эрх захирагч, нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажуулах, зарлагыг төсвийн эрх захирагч нягтлан бодогчоор заавал зөвшөөрүүлэн олгож хэвшсэн. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр боловсруулж дараа сарын 01-ний өдөр ЦЕГ-ын Санхүү аж ахуйн газарт хүргүүлж хэвшсэн.

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой бараа ажил үйлчилгээ худалдан авсан тайланг төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг боловсруулсаны үндсэн дээр тухайн сард хийсэн худалдан авалтыг олон нийт, алба хаагчдад мэдээлж, бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаа.

Үнэт цаас, торгуулийн тасалбар, шийтгэвэр, галт зэвсгийн гэрчилгээг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанаас захиалж авсан тухай бүрдээ кассын орлого авч, алба хаагчидтай тооцоо хийхдээ няраваас авсан орлогыг тулган шалгаж зарлагыг банкинд тушаасан баримт, торгуулийн тасалбарын санхүүд үлдэх хэсгийн хамт авч үлдэгдлийг тоолж, акт үйлдэн тооцоо хийсэн талаар нягтлан бодогч тусгай дэвтэр хөтлөн, тооцоо хийсэн алба хаагчийн хувийн тооцооны дэвтэрт тэмдэглэл үйлдэн баталгаажуулав.

Тус газар 2017 онд торгуулийн хуудас 2000 ширхэг, шийтгэвэр 3000 ширхэг, шийтгэлийн хуудас маягт-1 500 ширхэг, маягт-2 500 ширхэг захиалан авч байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж, эрх бүхий алба хаагчидтай тооцоог тухай бүрд нь хийж, аймгийн хүү торгуулийн 100010000985 тоот дансанд 2017 оны 12 дугаар сарын 13-ны байдлаар 143,6 сая төгрөг, 100010000987 тоот дансанд 64,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Урсгал төсвийн зардал, тогтмол зардлууд болох гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардал нь батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлтэй зөв зарцуулснаар ямар нэгэн өр үүсээгүй байна.

Шуурхай албанд ашиглагдаж байгаа автомашины техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, цаг хугацаанд нь засвар үйлчилгээг хийж, норм нормативаар нь тооцон 2017 оны 12 дугаар сарын 22-ны байдлаар 34,1 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг олгож, иргэд байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийг шалгах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, оргодол этгээдүүдийг олж баривчлах, байгууллагын бэлэн байдлыг хангах ажиллагаанд 112,2 сая төгрөгийн шатах тослох материалаар бүрэн ханган ажилласан байна.

Тус газраас энэ онд Аймгийн засаг даргын 2017 оны А/260 тоот захирамжийн дагуу 30,0 сая төгрөг шийдүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу тендэр зарлагдан тусгай төхөөрөмж, бараа материалыг хүлээн авсан болно.

Тус газар Сангийн яамны mof.gov.mn сайтаас цагдаагийн газрын үндсэн санхүүжилтийн 100010012001 тоот данс, нэмэлт санхүүжилтийн 100010012402 тоот данс, хүү торгуулийн орлогын 100010000985 тоот дансдын орлого, зарлагын гүйлгээний хуулгыг тухай бүрт нь авч санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, цалин хөлснөөс суутгасан нийгмийн даатгалын тайланг онлайнаар сар бүр Нийгмийн даатгалын ерөнхий газрын ndaatgal.mn нэгдсэн сайтад байрлуулах, мөн цалин хөлснөөс суутгасан татварын тайланг Татварын ерөнхий газрын e-tax.mta.mn сайтад онлайнаар тоон гарын үсэг ашиглан илгээж хэвшсэн байна.

-Шилэн дансны ил тод байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Монгол улсын засгийн газрын 2016 оны “ ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМ ХУУДСАНД ТАВИХ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА, НИЙТЛЭГ СТАНДАРТЫГ ТОГТООХ ЖУРАМ” 29 дүгээр тогтоолын 2 дугаар заалтын дагуу мэдээллийг бүрэн оруулан 2017 оны 10 дугаар сарын байдлаар Шилэн дансны нэгдсэн цахим санд байршуулсан мэдээлэл 133 байгаа бөгөөд үүнээс 24 мэдээлэл хугацаа хоцорч байршуулсан ба мэдээллийг мэдээлээгүй зөрчил байхгүй болно. Мэдээлэл хугацаанд нь үнэн зөв байршуулахад цаашид анхаарч ажиллах болно.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчмын дагуу мэдээллийг төрийн сангийн гүйлгээгээр баталгаажуулж үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой,

тогтоосон хугацаанд, шуурхай мэдээлж ажиллаж байна. Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Монгол улсын засгийн газрын 2016 оны “ ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМ ХУУДСАНД ТАВИХ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА, НИЙТЛЭГ СТАНДАРТЫГ ТОГТООХ ЖУРАМ” 29 дүгээр тогтоолын 2 дугаар заалтын дагуу мэдээллийг бүрэн оруулан өөрийн байгууллагын цахим хуудсанд цагдаагийн газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлж, цагдаагийн газрын 2017 оны тодотгосон төсвийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршууллаа.Цагдаагийн ерөнхий газрын болон байгууллагын цахим хуудсанд цагдаагийн газрын мэдээллийг хугацаанд нь үнэн зөв оруулж хэвшсэн. Тайлант хугацаанд нийт 111 төрлийн мэдээлэл байршуулсан бөгөөд төсөв/гүйцэтгэл 42 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт хэсэгт 35 мэдээлэл, бусад хэсэгт 56 мэдээлэл тус тус байршуулсан байна. 2017 оны 12 дугаар сарын 22-ны байдлаар төвлөрсөн төсвийн санхүүжилт 1,826,465,400.00 төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 1,826,465,400.00 төгрөг зарцуулагдсан байна. Бусад байгууллага иргэдэд өгөх өглөг 0,9 сая төгрөг, авлага 0,6 сая төгрөг байна. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг цэсэд Эх голомтын элч ХХК-аас нийт 78,4 сая төгрөг, Ник ХХК-аас 73,8 сая төгрөгийн худалдан авалт тус тус хийсэн байна.

Тав: Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр

-Алба хаагчдын ажиллах нөхцөл байдал, нийгмийн асуудлыг дээшлүүлэх чиглэлээр;

Алба хаагчдаас байр орон сууц, хашаа байшин, тээврийн хэрэгсэл болон бусад эд хөрөнгө шинээр худалдан авах, засвар хийх, эмнэлэг сувилалд явах зэрэг зайлшгүй хэрэгцээ шаардлага хангахын тулд цалингийн зээл авах хүсэлтийг хүлээн авч цаашид тогтвор суурьшилтай ажиллах 41 ажилтан, алба хаагчдад банкуудтай хамтран ажиллах гэрээний дагуу 500.0-20000.0 мянган төгрөг хүртэлх хэмжээний цалингийн зээлийн баталгаа гаргаж бололцоо нөхцлөөр хангав.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын дагуу туслах аж ахуй эрхлэн Ихтамир сумын Эрдэнэ толгой баг Талын толгой газарт нийт 1 га талбайд тус газрын алба хаагчид 1,2 тонн кг төмс, хүнсний ногоо тариалан 9 дүгээр сард 5 тонн төмс хүнсний ногоо хурааж алба хаагчдын хүнсний хэрэгцээг хангасан.

Орон нутгийн хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажиллах, амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, засвар үйлчилгээ хийх нэн шаардлагатай кобан барилгын судалгааг гарган 2017 оны 05 дугаар сард Батцэнгэл сум дахь цагдаагийн кобан барилгыг Цагдаагийн ерөнхий газрын 7800000 төгрөгийн санхүүжилтээр “Тулгуур түмэн тулга” ХХК-аар засварын ажлыг гүйцэтгүүлж ашиглалтад оруулсан. Мөн Хайрхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 3,5 сая төгрөгийг шийдвэрлэн алба хаагчийн амьдрах байрны халаалтыг төвийн шугамд холбох ажлыг зохион байгуулснаас гадна нийт 19 сумдын алба хаагч нар өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд орон байр, дулаан, цахилгаан, түлээ нүүсний туслалцааг тухайн нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргад асуудал оруулж шийдвэрлүүлээд байна.

Цагдаагийн байгууллагын эзэмшлийн газарт алба хаагч, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор байгууллагаас орон сууц бариулах, түүний захиалгад эхний ээлжинд өөрийн өмчлөлийн орон сууцгүй, эсхүл орон сууцны нөхцөлөө сайжруулах шаардлагатай алба хаагчдын судалгаанд үндэслэн Цагдаагийн газрын алба хаагчдын хөнгөлөлтэй орон сууц 1 мк талбайг 950000 төгрөгөөр барихаар “Тулгуур түмэн тулга” ХХК-тай тохиролцон одоогоор 6 алба хаагч 2-3 өрөө байрны захиалга өгч барилгын ажил эхлээд байна.

Байгууллагын хамт олны 2017 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар алба хаагчдыг мөнгөн хуримтлалтай болгох, мөн санхүүтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилготойгоор алба хаагч нэг бүрт хадгаламжийн дэвтэр нээлгэн сар бүрийн цалингаас алба хаагчид өөрсдийн боломжит мөнгөн дүнг суутган ХААН банктай гэрээг 13 сарын хугацаатай жилийн 18,0 хувийн хүүтэй байгуулсан. Одоогоор алба хаагч бүр дунджаар 30,9 сая төгрөгний хадгаламжтай болоод байна.

Шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу аймгийн төвөөс бусад сум орон нутагт 60 сараас дээш хугацаагаа ажилласан 3 алба хаагчийн материалыг тавигдах шаардлагын хэмжээнд бүрдүүлэн 30 сарын тэтгэмжийг олгосон.

Цагдаагийн газрын ажилчин, алба хаагчдын сайн дурын санаачлагаар бий болгосон дундын мөнгөн хуримтлал болох “Журмын нөхөр” сангаас зарцуулах журмын дагуу нийт 9,3 сая төгрөгийг сангаас зарцуулав.

Байгууллагын ажлын байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг хангаж 1,2 дугаар давхрын 33 өрөө, эрүүлжүүлэх баривчлах байр, цайны газар, зочид буудал зэрэгт газарт засвар үйлчилгээ хийж тохилог орчныг бүрдүүлж алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх бялдаржуулах өрөөг тохижуулан саун, дүш шинээр хийж ариун цэврийг хангав.

Цагдаагийн газрын шуурхай албаны болон хөдөлгөөнт эргүүлийн цагдаа жолооч нарыг чадавхжуулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах, албаны бэлэн байдлыг хангах, шинэ санал, санаачилгыг дэмжих зорилгоор 45 хоногийн аян зохион байгуулж аяны хүрээнд цагдаа-жолооч нар өөрсдийн санал, санаачилгаар цагдаагийн газрын авто гражийн өнгө үзэмжийг сайжруулан дотор хэсэг шохой болон будгаар өнгөлгөө хийн, шалыг цементээр цутгаж, галын булан, дотор гэрэл, цахилгаан монтажийг шинэчлэх ажлыг зохион байгууллаа. Мөн алба хаагчид хөдөлмөр хамгаалах хувцас, багаж хэрэгсэл хадгалах шүүгээ, автомашинд засвар үйлчилгээ хийж мотор өргөгч тайл, хөшүүлэг, дугуйт тавцан гэх мэт гарын доорх хаягдал материалаар тоног төхөөрөмж хийж өөрсдийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

Тус цагдаагийн газрын Спорт хамтлагийн ахлагчийн санаачлагаар цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүн спорт уралдаан, аялал зугаалга, нийтийн хамарсан соён гэгээрүүлэх арга хэмжээг өссөх ижил загварын БНСУ-ын чанартай материалаар биеийн тамирын хувцас хийлгэх захиалга өгч 120 алба хаагч хувцастай болоод байна.

Алба хаагчид албан үүргээ гүйцэтгэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлж орон нутгийн санхүүжилтаар Police reader бэлэн бус торгуулийн төхөөрөмж 5 ширхэг, согтуурал хэмжигч багаж 24 ширхэг, станц 20 ширхэг, сандал 100 ширхэг, төвийн эргүүлийн Элентра маркийн авто машин 1 ширхэг, хөдөлгөөнт эргүүлийн Ford Transit машин 1 ширхэгийг шийдвэрлүүлсэн.

Аймгийн Ичинхорлоогийн нэрэмжит Хөгжимт драмын театрын “Хавар цагийн нээлтийн тоглолт”, “Би эндээс явахгүй” жүжиг, Монгол улсын гавьяат жүжигчин Чулуунхүү, залуу дуучин Б.Минжүүр нарын бие даасан тоглолт зэрэг үзвэрийг 5 удаа алба хаагчдад үзүүлжээ.

2017 оны сар шинийн баярыг тохиолдуулан Цагдаагийн газрын дэргэдэх ахмадын хороонд бүртгэлтэй ахмад настнуудыг Цагдаагийн газрын удирдлага хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2-р сард зохион байгуулан тэдэнтэй уулзан санал хүсэлтийг сонсож, амьдрал ахуйтай нь танилцан зоог барьж, 10 кг бүхий гурил хүн нэг бүрт олгов. Хөдөлмөр, халамжийн газартай хамтран ажиллах төлөвлөгөө батлан хэрэгжүүлж 2017 оны 10 дугаар сард амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой бэлтгэл ахлах дэслэгч Ш.Дугаржавыг түлшний хөнгөлөлтийн санхүүжилтээс 140000 /нэг зуун дөчин мянга/ төгрөг, бэлтгэл ахмад Ж.Батбаатарыг 250000 төгрөг, бэлтгэл ахмад С.Батнасанд 130000 төгрөгийн халамж үйлчилгээнд тус тус хамруулсан байна.

Аймгийн Цагдаагийн газрын “Б” танхимд ахмад настнуудыг чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх “Ахмадын өрөө”-г шинээр гаргаж, засварын ажилд зориулж 100000 төгрөгийн барилгын материалын туслалцаа үзүүлж, 2 алба хаагчыг засварын ажилд оролцуулсан байна.

-Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ;

Цагдаагийн газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/06 дугаар тушаалаар Алба хаагчийн эрүүл мэндийг хамгаалах комисс байгуулан аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран ажиллах төлөвлөгөө гарган батлуулан ажиллаж байна.

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2016 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар “Хепатитын В вирусийн халдвараас сэргийлье” урианы дор явагдаж буй дархлаажуулалтын аяны хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газар, Немойн нэрэмжит нэгдсэн эмнэлгийн Захиргаа, Монголын элэгний эмч нарын нийгэмлэг, Оном сантай хамтран элэгний хатуурал, хорт хавдрыг үүсгэгч элэгний вирусийн халдварыг эрт илрүүлэх, уг өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулах ажлыг 2016 оны 10 дугаар сараас зохион байгуулж 2017 оны 04, 08 дугаар сард 3 дахь тунг үргэлжлүүлэн хийж алба хаагчдыг бүрэн хамрууллаа. Хамрагдсан алба хаагчдаас элэгний В вирус илэрсэн 3, элэгний С вирустэй 9, В,С вирус давхар илэрсэн 1, нийт 13 алба хаагч дахин шинжилгээ, вирус тоолуулах эмчилгээнд хамруулан “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээн 11 алба хаагчид эмчилгээг хийлгэж байна.

Архангай аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/131 дугаар захирамжаар Хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох, сорилын сарын аяны хүрээнд Биеийн тамир спортын газрын мэргэжилтнүүд цагдаагийн газрын алба хаагчдаас 2017 оны 04 дүгээр сард сорил авч, чийрэгжилтийн түвшнийг тогтооход алба хаагчдын 40 хувь таргалалттай ба хэт таргалалттай байгаа тул жингийн илүүдлийг хасах “Цусны даралт ихсэлт, түүний хүндрэлээс сэргийлье” 3 сарын аяны хүрээнд “Өглөөний алхалт, гүйлт, дасгал” аяныг зохион байгууллаа.

Мөн Архангай аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран албан байгууллагуудад “Алхалт-аэробик”-ийн сургагч багш бэлтгэх сургалтад Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Мэдээлэл хүлээн авагч цагдаа, Цагдаагийн ахлагч Ц.Мандухай оролцож гэрчилгээ авсан ба цаашид алба хаагч нарын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дасгал хөдөлгөөн зааж сургахаар төлөвлөн ажиллаж байна.

Цагдаагийн газрын алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр

Цагдаагийн ерөнхий газрын “Сүүж уул” сэргээн засах сувиллын газарт амрах алба хаагчдын нэрсийг авч, хуваарь гарган, амралтын тал зардлыг хамт олны “Журмын нөхөр сан”-аас олгож, 3 алба хаагч, 2 ахмад ажилтан хамрагдаад байна.

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын иргэд, албан хаагчдыг “Цусны даралт ихсэлт, түүний хүндрэлээс сэргийлье” 3 сарын аяны хүрээнд “Өглөөний алхалт, гүйлт, дасгал” аян зохион байгуулагдаж, энэ аяны хүрээнд Цагдаагийн газрын нийт бүрэлдэхүүн 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Булган уул уруу явган аялал хийлээ.

Цагдаагийн газрын 123 алба хаагчийг 2017 оны 08 дугаар сарын 10-нд аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Тарваган тахлын тарилга” хамгаалалтын вакцинд хамруулав.

Алба хаагчдын хөдөлгөөний дутагдал, биеийн жингийн илүүдэл, эрүүл мэндийг хамгаалах ажлыг хүрээнд цагдаагийн газрын Б танхимд бялдаржуулах танхимт аробик болон бодибилдинг, цагариг, теннис, билльард зэрэг хөдөлгөөнт дасгал хийж нөхцөлөөр хангаж тасаг, албаадыг хуваарийн дагуу хичээллүүлж байна.

Эрүүл мэндийн газраас 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр 5 эмч, мэргэжилтэн цагдаагийн газрын нийт алба хаагчдад Сүрьеэ, Бэлгийн замын халдварт өвчин, Элэгний өвчлөлтийн талаар 1 өдрийн сургалтыг хамтран зохион байгуулж 64 алба хаагч хамрагдав.

Цагдаагийн газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах шууд үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, автомашин, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах зорилгоор жил бүр МИГ даатгалын Архангай аймаг дахь салбартай хамтран ажиллах гэрээг 1 жилийн хугацаатай гэрээ байгуулж тус даатгалын газраас 1 алба хаагч 1600000 төгрөгийн даатгал авсан байна.

-Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Дотоод аюулгүй байдлыг хангах /код113/ журам”-ын дагуу цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хэсгийг дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн даргаар ахлуулан 6 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй томилж, байгууллагын аюулгүй байдлыг хангах ажлыг хүний нөөцийн, алба хаагчийн, мэдээллийн, санхүүгийн, галт зэвсэг, тусгай хэрэгслийн, барилга байгууламж /объект/-ийн гэсэн чиглэлээр нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Тус цагдаагийн газраас 2017 онд цагдаагийн газрын хэмжээнд Дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр 7 зүйл, 47 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, тодорхой ажлуудыг зохион байгууллаа. Тухайлбал: байгууллагын аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2017 оны эхний 9 сард цагдаагийн газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу “Цахим-Хяналт” хэсэгчилсэн арга хэмжээг 01 дүгээр сард 10 хоногийн хугацаанд зохион явуулж нийт 14 алба хаагчийн албаны компьютер, шаардлагатай мэдээлэл агуулсан файлуудын аюулгүй байдлын шаардлага хангасан нууц түлхүүрээр хамгаалагдсан эсэхэд үзлэг шалгалт явууллаа.

Шалгалтаар 3 алба хаагчийн төрийн нууц мэдээлэл агуулсан зарим нэг файлууд нууц түлхүүрээр хамгаалагдаагүй зөрчил илэрснийг тухайн алба хаагчдад анхааруулга өгч, зөрчлийг арилгуулан цаашид дахин давтан зөрчил дутагдал гаргахгүй байх талаар зааварчилгаа өгч хяналт тавин ажиллаа.

Мөн цагдаагийн газрын 1 давхрын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаах алба хаагчдын өрөөний төмөр сараалжийг сольж, эд мөрийн баримт хадгалах өрөөг шинэчлэн засварлан бүртгэлийг нээж тусгаарлах тавцан, цонх болон хаалганы аюулгүй байдлыг хангаж камержуулсан. Цагдаагийн газрын галт зэвсэг хадгалах өрөөг тусгай хэрэгсэл хадгалах өрөөнөөс тусгаарлан засварлах ажлыг зохион байгуулжээ. Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлын 2017 оны төлөвлөгөөний дагуу 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр сонсгол мэдээллийг даргын зөвлөлийн хуралд танилцуулж цаашид хэрэгжүүлэх ажлын талаар үүрэг чиглэл өгч ажиллав.

Зургаа: Дотоод хяналтын хүрээнд

-Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийсэн байдал; /код-110/ -

Цагдаагийн газраас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Засгийн газрын тогтоол шийдвэр, Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан Үндэсний хөтөлбөрүүд, Хууль Зүйн сайдын өгсөн үүрэг, даалгавар болон Цагдаагийн байгууллагаас 2016 онд дэвшүүлсэн зорилт, төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, цагдаагийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, 2015 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж өгсөн үүрэг, байгууллагын ил тод байдал, эдийн засаг нийгмийн хөгжлийг хэрэгжүүлэх талаар хийсэн ажилд Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 842 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд

хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам” /код 110/-ыг удирдлага болгон 2016 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж 92,7 үнэлгээ өгч тайланг хүргүүлсэн.

Хяналт шинжилгээ хийсэнтэй холбогдуулан төвийн болон орон нутгийн тасгийн дарга нар “Зөвлөмж” хүргүүлж биелэлт үр дүнг тооцлоо.

Цагдаагийн ерөнхий газраас цагдаагийн байгууллагын 2016 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний дагуу нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх ажлын салбар төлөвлөгөөг 4 бүлэг 11 заалттай боловсруулан биелэлт үр дүнг хагас, бүтэн жилээр тооцон Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.

Аймгийн Аудитын газраас тус цагдаагийн газрын 2016 оны санхүүгийн үйл ажиллагааг шалгаж санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан нь хууль дүрэм журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн “СТАНДАРТ ТАЙЛАН, ЗӨРЧИЛГҮЙ ДҮГНЭЛТ”-ээр баталгаажуулсан.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын талаар;

Цагдаагийн газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/38 дугаар тушаалаар “Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус ажлын хэсэг”-ийг шинэчлэн байгуулж байгууллагын эрсдэлийн бүртгэлд эрсдэл өндөр тогтоогдсон заалт бүрийг бууруулах чиглэлээр ажлаа зохион байгууллаа.

Хууль зүйн сайдын 2013 оны А/248 тоот тушаалаар батлагдсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын эрсдэлийг үнэлэх аргачлал”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх /код-137/ журам”-ын дагуу байгууллагын удирдлагын баг эрсдэлийг бүртгэлийг хөтлөн, эрсдэлийн үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэн зөв, бодитой бүртгэн, үнэлгээний мөрөөр эрсдэлийг шийдвэрлэх арга замыг судалан одоогоор төсөв санхүүгийн эрсдэл 15, үйл ажиллагааны эрсдэл 57, нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл 7, гадаад хүчин зүйлийн буюу давагдашгүй хүчин зүйлийн эрсдэл 8-ийг санд бүртгээд байна.

Үүнээс эрсдэлийн шийдвэрлэх арга замын төлөвлөгөөнд магадлал болон нөлөөллөөр өндөр тогтоогдсон төсөв санхүүгийн эрсдэл 6, үйл ажиллагааны эрсдэл 23, нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл 3, гадаад хүчин зүйлийн буюу давагдашгүй хүчин зүйлийн эрсдэл 4 тодорхойлж, урьдчилан сэргийлэх, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж Цагдаагийн ерөнхий газрын Хяналт шалгалт үнэлгээ, дотоод аудитын хэлтэст Эрсдэлийн үнэлгээний тайланг хагас, бүтэн жилээр гарган хүргүүлэв.

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 6/58 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2017 оны сургалтын календарчилсан төлөвлөгөө”-ний дагуу “Эрсдэлийн удирдлага”, “Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит, эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтад тус газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга нийт 2 кридит сургалтад хамрагдсан болно.

-Хяналт шалгалт, албаны шалгалтын талаар;

Цагдаагийн газрын удирдлага нь Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Хууль зүйн сайдын 2015 оны А/238 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам”-ын дагуу тасаг, албад, алба хаагчдын ажлын алдаа, зөрчил дутагдлыг засч арилгах, таслан зогсоох, ажлын хэвийн нөхцлийг хангах, чанар үр дүнг дээшлүүлэх, алба хаагчдын ажлын болон сахилга ёс зүйн дутагдлыг илрүүлэх, засуулах зорилгоор “Дотоодын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө”-ны дагуу цагдаагийн газрын даргын тушаалаар “Тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон зөрчлийг шалгаж шийдвэрлэсэн байдал”-д “Захиргааны зөрчлийг бүртгэх, шалгаж шийдвэрлэх хариу өгөх ажиллагаа”, “Дотоод албаны дүрмийн хэрэгжилтийг шалгах /Алба хаагчдын сахилга ёс зүй, дүрэмч ажиллагаа/, “Иргэдээс ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг түргэн шуурхай бүртгэн авч шийдвэрлэж буй байдал, “Гэмт хэрэг зөрчлийн дуудлага үнэлгээний хуудас”-ны хэрэгжилт, Захиргааны зөрчлийн шийдвэрлэлт, нэгдсэн сан, шийдвэрийн хуудасны зарцуулалттай тулгалт хийх, “Эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаа”, хамт олны “Журмын нөхөр сан”-ийн үйл ажиллагаа, төвийн болон орон нутгийн тасгийн үйл ажиллагаа зэрэгт дотоодын хяналт шалгалт явуулж зөрчил дутагдлыг арилгаж даргын зөвлөлийн хурлаас үүрэг чиглэл өгч биелэлт үр дүнг тооцлоо.

Цагдаагийн газрын хэмжээнд ашиглагдаж байгаа, гар станцыг жижүүрийн шуурхай албанд нэгтгэн, жижүүрийн шуурхай албан байвал зохих эд зүйлсийг бүрдлийг 2 удаа шалган дутуу эд зүйлийг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулан албаны бэлэн байдлыг хангуулж, томилгоот алба хаагчдад үүрэгт хугацаанд тогтмол ашиглуулж байна.

Цагдаагийн газрын дарга 18 сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажлыг шалган зааварчлах, сумдын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нартай уулзаж, алба хаагчдын ажиллах, амьдрах орчин, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд

цагдаагийн газрын даргын А/57, А/55, А/56 тушаалаар тасгийн дарга нараар ахлуулсан 3 ажлын хэсгийг томилон 2017 оны 09 дүгээр сарын 02-07-ны өдрүүдэд хяналт шалгалтыг явуулж үр дүнг 10 дугаар сарын 02-ны өдрийн даргын зөвлөлийн хуралд танилцуулан нийт 22 алба хаагчид 14 хоногийн хугацаатай үүрэг өглөө. Үүргийн биелэлтийг 11 дүгээр сарын 03-ны өдөр алба хаагч бүрээр шалгаж хангалтгүй үнэлэгдсэн алба хаагчдад хариуцлага тооцов.

Мөн цагдаагийн газрын даргын А/58 дугаар тушаалаар төвийн тасгийн үйл ажиллагааг 10 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд шалгаж дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж тасгийн дарга нарт 14 хоногийн хугацаатай үүрэг өгч биелэлтийг тооцсон байна.

Алба хаагчдад явуулсан албаны шалгалт 2016 онд 21 алба хаагчид холбогдох 17 албаны шалгалт явуулснаас 2 алба хаагчид холбогдох зөрчил нотлогдоогүй, 3 алба хаагчийг албанаас дутагдлаар халах сахилгын шийтгэл, 11 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалинг ажлын үр дүнгээр болон Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2-т зааснаар цалинг 1-6 сар хасах сахилгын шийтгэл ногдуулж, 5 алба хаагчид зөвлөлийн хурлаар сануулах болон “Сануулах” сахилгын шийтгэл тооцож шийдвэрлэсэн бол 2017 онд 34 алба хаагчид холбогдох 21 албаны шалгалт явуулснаас 5 алба хаагчид холбогдох зөрчил нотлогдоогүй, 1 алба хаагчийг албанаас дутагдлаар халах сахилгын шийтгэл, 1 алба хаагчид албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулж, 22 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалинг ажлын үр дүнгээр болон Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.2-т зааснаар цалинг 1-3 сар хасах сахилгын шийтгэл ногдуулж, 5 алба хаагчид зөвлөлийн хурлаар сануулах болон “Сануулах” сахилгын шийтгэл тооцож тус тус шийдвэрлэсэн байна. Үүнийг 2016 оны мөн үетэй харьцуулахад албаны шалгалтын тоо 4 буюу 19 хувиар өсөж, холбогдон шалгагдсан алба хаагчдын тоо 13 буюу 38,2 хувиар өссөн, албаны шалгалтын шийдвэрлэлт нотлогдоогүй зөрчил 3 буюу 66.6 хувиар өссөн, албанаас дутагдлаар халах сахилгын шийтгэл 2 буюу 66.6 хувиар буурсан, албан тушаалын сарын үндсэн цалинг хасах шийтгэл 11 буюу 50 хувиар өссөн, сануулах шийтгэл 5 буюу ижил түвшинд байгаа тус тус үзүүлэлттэй байна.

Долоо: Дүгнэлт

Тухайн тайлангийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, цаашид анхаарах асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээ:

Тус цагдаагийн газраас алба хаагчдын нийгмийн баталгаа, эрүүл мэндийг хамгаалах, сургалт чанарыг дээшлүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулах, хэргийн илрүүлэлтийг сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ бодит хүрсэн үр дүн, аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлуудтай уялдуулан 2018 онд дараах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Архангай аймагт ихээр үйлдэгдэж байгаа мал хулгайлах, орон байрны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулж, энэ төрлийн гэмт хэргийг бууруулах, цаашид зарим нэг шинэлэг ажлыг нэвтрүүлж, хяналт шалгалтын үйл ажиллагаанд хяналтын камерын системийг өргөнөөр нэвтрүүлэх.

2. Төв зам дагуу гарч байгаа зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг тогтоож, нас баралтыг бууруулан, хар цэгийг тодорхойлж замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй үр дүнтэй зохион байгуулах.

3. Хор хохирол үүсэхээс нь өмнө гэмт явдлаас урьдчилан сэргийлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг цаашид анхаарч хүн амын нягтрал, нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг шат дараалан авч байх саналыг аймаг, сумдын удирдлагад тухай бүр боловсруулан хүргүүлэх, хэрэгжилтийг хангах

4. Гэмт хэргийн илрүүлэлтийг хувийг ахиулах.

5. Алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сахилга ёс зүй, ажлын хариуцлагыг сайжруулах талаар үр дүнтэй ажил арга хэмжээнүүдийг шинэлэг байдлаар зохион байгуулж, сургалтын чанарыг ахиулах.

6. Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлын ханган алба хаагчдын эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр шат дараалсан ажлыг зохион байгуулах. .

7. “Иргэдэд ойр, эрх зүйн үйлчилгээний жил”-ийн хүрээнд шинэлэг ажлыг санаачилж үр дүнтэй зохион байгуулах

8. Цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойн баярын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх зөвшөөрлийг авч Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын дагуу зохион байгуулах.

ХЯНАСАН:

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Э.ЗОЛБААТАР

ТАЙЛАН БИЧСЭН:
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН АХМАД П.МӨНХБАЯР